

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА



Улаанбаатар
2024 он

АГУУЛГА

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ГҮЙЦЭТГЭЛ	11
1.1. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, хүлээгдэж буй гүйцэтгэл.....	11
1.2. Макро эдийн засгийн 2025 оны чиг хандлага, төсөөлөл.....	16
ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨСӨВ, САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ГҮЙЦЭТГЭЛ	21
2.1. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсөв.....	21
2.1.1. Төсвийн орлогын гүйцэтгэл, хүлээгдэж байгаа гүйцэтгэл.....	21
2.1.2. Төсвийн зарлагын гүйцэтгэл, хүлээгдэж байгаа гүйцэтгэл.....	22
2.1.3. Улсын төсөв, гадаад зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл.....	22
2.2. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл.....	24
2.2.1. Татварын бодлогын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ.....	24
2.2.2. Төсвийн орлого	24
2.2.3. Төсвийн урсгал зардал	27
2.2.4. Засгийн газрын тусгай сан	32
2.2.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаад зээл, тусламжийн санхүүжилт:	39
2.2.6. Орон нутгийн төсөв.....	43
2.2.7. Засгийн газрын өр.....	45
2.3. Төсвийн болзошгүй эрсдэлийн тойм	50
ГУРАВДУГААР БҮЛЭГ: НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД.....	51
3.1. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд	51
3.2. Төсвийн тусгай шаардлага.....	51
3.3. Сангийн үлдэгдлүүд.....	52
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ТӨСВИЙН ТӨСЛИЙН ХАВСРАЛТ	53
4.1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн тайлбар.....	53
4.2. Олон нийтийн хэлэлцүүлэг.....	55
4.3. Хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл	58
4.4. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний талаарх товч танилцуулга.....	59

ХҮСНЭГТ

Хүснэгт 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, салбаруудаар (хувь)	11
Хүснэгт 2. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл (хувь).....	16
Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн 2024 оны эхний 10 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан харьцуулалт (тэрбум төгрөг)	21
<i>Хүснэгт 4. 2024 оны эхний 10 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг)</i>	<i>21</i>
Хүснэгт 5. 2024 оны эхний 10 сарын нэгдсэн төсвийн урсгал зарлагын гүйцэтгэл (тэрбум төгрөг).....	22
Хүснэгт 6. 2025 оны нэгдсэн төсвийн нийт орлого (тэрбум төгрөг).....	25
Хүснэгт 7. 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн (тэрбум төгрөг)	25
Хүснэгт 8. Татварын зарлагын хэмжээ (тэрбум төгрөг).....	27
Хүснэгт 9. Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын задаргаа /тэрбум ₮/. 30	
Хүснэгт 10. Бараа үйлчилгээний бусад зардлын задаргаа /тэрбум ₮/.....	31
Хүснэгт 11. Засгийн газрын тусгай сангийн зардлын төсөл /тэрбум ₮/	32
Хүснэгт 12. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Төсвийн ерөнхийлөн захирагчаар	40
Хүснэгт 13. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, зориулалтаар	41
Хүснэгт 14. Гадаад зээл, тусламжийн 2025 оны ашиглалт, тэрбум төгрөг.....	41
Хүснэгт 15. Аймгуудын санхүүгийн дэмжлэг (сая төгрөг)	43
Хүснэгт 16. Дээд шатны төсөвт төвлөрүүлэх дүн (сая төгрөг).....	44
Хүснэгт 17. Орон нутгийн хөгжлийн сан.....	44
Хүснэгт 18. Засгийн газрын өрийн бүтэц /тэрбум ₮/	45
Хүснэгт 19. Засгийн газрын өрийн хүүгийн төлбөр /тэрбум ₮/	46
Хүснэгт 20. Засгийн газрын гадаад зээл, зээлдүүлэгчээр, тэрбум төгрөг.....	46
Хүснэгт 21. Гадаад үнэт цаас, 2024.06.30 /тэрбум ₮/	47
Хүснэгт 22. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)	51
Хүснэгт 23. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь	52
Хүснэгт 24. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь.....	52
Хүснэгт 25. Засгийн газрын өрийн төсөөлөл, нэрлэсэн дүнгээр (ДНБ-д эзлэх хувь).....	52
Хүснэгт 26. Хэлэлцүүлгийн үр дүн.....	55
Хүснэгт 27. Хэлэлцүүлгийн үр дүн.....	55
Хүснэгт 28. ТЕЗ-ийн хавсралт-1. 2025 он	60

ЗУРАГ

Зураг 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, эрэлтийн бүрэлдэхүүнээр (хувь).....	12
Зураг 2. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь).....	12
Зураг 3. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбараар (мянган хүн).....	13
Зураг 4. Ажиллах хүч (мян.хүн), ажиллах хүчний оролцооны түвшин (хувь).....	13
Зураг 5.Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар).....	13
Зураг 6. Гадаад валютын нөөц (сая ам.доллар).....	13
Зураг 7.Импорт, хэрэглээний зориулалтаар (тэрбум ам.доллар).....	14
Зураг 8. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.доллар).....	14
Зураг 9. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн).....	17
Зураг 10. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/трой унц).....	17
Зураг 11. Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн).....	18
Зураг 12. Австралийн коксжих нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн).....	18
Зураг 13. Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель).....	18
Зураг 14. Улсын төсвийн 2020-2024 оны хөрөнгө оруулалт, гүйцэтгэл (их наяд төгрөг).....	23
Зураг 15. Гадаад зээл, тусламжийн ашиглалт (их наяд төгрөг).....	23
Зураг 16. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээ.....	23
Зураг 17. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого, салбараар (тэрбум төгрөг).....	26
Зураг 18. Импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлого (тэрбум төгрөг).....	26
Зураг 19. Дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын орлого (тэрбум төгрөг).....	26
Зураг 20. Хувь хүний орлогын албан татварын орлого (тэрбум төгрөг).....	27

Төсвийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.2 дахь хэсэгт заасан төсвийн төслийн танилцуулгад туссан зүйлийн талаар

№	Заалтууд	Туссан байдал
32.2.1.	Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс боловсруулсан макро эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлын үнэлгээ, ирээдүйн чиг хандлагын төсөөлөл, тооцоо;	Улсын төсвийн төслийн танилцуулгын араас хавсаргав
32.2.2.	макро эдийн засаг, төсвийн тогтвортой байдлыг хангах талаар Засгийн газраас тухайн жилд баримтлах бодлого, тэргүүлэх чиглэл, тэдгээрийг хэрэгжүүлэх асуудлыг төсвийн төсөлд тусгасан байдал;	Нэгдүгээр бүлэг: макро эдийн засгийн нөхцөл байдал, хүлээгдэж байгаа гүйцэтгэл
32.2.3.	төсвийн тэнцлийн зорилтот үзүүлэлтийг тооцсон байдал;	3.1. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд
32.2.4.	төсвийн гүйцэтгэлд нөлөөлж болзошгүй эрсдэлийн үнэлгээ;	2.3. Төсвийн болзошгүй эрсдэлийн тойм
32.2.5.	төсвийн жилийн татварын зардлын тооцоог татварын орлогын нэр төрөл бүрээр, өмнөх хоёр жилийн гүйцэтгэл, дараагийн хоёр жилийн төсөөлөл;	2.2.2. Төсвийн орлого /Татварын зарлага/
32.2.6.	хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, санхүүжилтийн эх үүсвэрээр/;	2.2.5.Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаад зээл, тусламжийн санхүүжилт:
32.2.7.	санхүүжилтийг нь зогсоох болон багасгах хөтөлбөр, арга хэмжээний жагсаалт, түүний төсөвт үзүүлэх нөлөөлөл, тайлбар;	2.2.5.Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаад зээл, тусламжийн санхүүжилт:
32.2.8.	гадаад зээл, тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, объект, үнийн дүнгээр/;	2.2.5.Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаад зээл, тусламжийн санхүүжилт: /Тооцооллын хавсралт №14/
32.2.9.	тусгай сангийн орлого, зарлагын тооцоо;	2.2.4. Засгийн газрын тусгай сан
32.2.10.	төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон орон нутгийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн төсөвт төлөх ногдол ашгийн хэмжээ;	2.2.2. Төсвийн орлого /Хувьцааны ногдол ашиг/
32.2.11.	төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээ, түүнд шаардагдах орц, хүрэх үр дүн, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт, тэдгээртэй холбогдсон тайлбар, танилцуулга;	4.4.Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний талаарх товч танилцуулга
32.2.12.	төсвийн тусгай шаардлагад болон дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцэж байгаа талаарх тайлбар;	3.2.Төсвийн тусгай шаардлага
32.2.13.	<i>төсвийн тусгай шаардлагыг түр баримтлахгүй тохиолдолд түүний үндэслэл, санал;</i>	<i>Төсвийн тусгай шаардлагыг баримталж байна</i>
32.2.14.	нэгдсэн төсвийн орлого, зарлагын үзүүлэлтийн хураангуй тайлбар;	3.1. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд
32.2.15.	төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг тооцсон байдал;	2.2.2. Төсвийн орлого /Монгол Улсын 2025 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн/
32.2.16.	<i>төсөв алдагдалтай төлөвлөгдсөн бол уг алдагдлыг санхүүжүүлэх тухай санал;</i>	<i>Төсвийн төслийг алдагдалгүй төлөвлөсөн</i>
32.2.17.	Засгийн газрын өрийн үлдэгдэл, төслийн зээлийн дотоод эх үүсвэрийн хэмжээ, Засгийн газраас гаргасан баталгаа, түүний дүн;	2.2.7.Засгийн газрын өр

32.2.18.	нэгдсэн төсвийн орлогын нэг хувиас хэтэрсэн дүнтэй тэнцэх болзошгүй өр төлбөр, түүнээс учирч болзошгүй эрсдэлийн тооцоо;	2.2.7.Засгийн газрын өр /Засгийн газрын болзошгүй өр төлбөр/
32.2.19.	<i>Энэ заалтыг 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцсон</i>	-
32.2.20.	төсвийн төсөлтэй холбогдуулан шийдвэрлүүлэх хууль тогтоомжийн төсөл.	4.3.Хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл
32.2.21.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн дагуу түншлэлээр хэрэгжүүлэхээр гэрээ байгуулсан төслүүдийн танилцуулга, мэдээлэл, хэрэгжилт, үр дүн, төсөвтэй уялдсан байдал болон төсвөөс санхүүжүүлэх төрлөөр гэрээ байгуулсан төслүүдийн төсвөөс төлөх төлбөрийн хуваарь, төсвийн төсөлд тусгах саналыг түншлэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас ирүүлснээр хянаж тусгасан мэдээлэл.	2.2.5.Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаад зээл, тусламжийн санхүүжилт
32.2.22.	энэ хуулийн 28 ¹ .2.3-т заасны дагуу хэлэлцүүлгээс гарсан саналыг тухайн жилийн төсвийн төсөл, төсвийн тодотголын төсөлд хэрхэн тусгасан талаарх мэдээлэл.	4.2. Олон нийтийн хэлэлцүүлэг

МОНГОЛ УЛСЫН 2025 ОНЫ ТӨСВИЙН ОНЦЛОГ, БАРИМТЛАХ БОДЛОГО, ТЭРГҮҮЛЭХ ЧИГЛЭЛ

Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлт болох сонгуулийн холимог тогтолцоогоор нийт ард иргэдийн саналыг гээхгүй байх зарчим дор анхны гурван намын хамтарсан Засгийн газар байгуулагдаж, Улсын Их Хурлын 21 дүгээр тогтоолоор “Хурдтай хөгжлийн төлөөх зориг” гэрээнд суурилсан ирэх 4 жилд хэрэгжүүлэх 4 бүлэг, 4 үндсэн чиглэл бүхий “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр” батлагдсан билээ.

Ирэх 2025 он нь Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр болон Бүсчилсэн хөгжлийн цогц реформыг хэрэгжүүлж, шинэ 30 жилийн хөгжлийн эхлэлийг тавих эхний жил учраас Засгийн газраас хөгжлийн тулгамдсан асуудлуудыг шийдвэрлэж, эдийн засгийн суурийг тэлэх томоохон зорилт бүхий Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 8 дугаар сарын 30-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан.

Улсын Их Хурал Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөл болон дагалдах бусад хууль тогтоомжийн төслийг 2024 оны 11 дүгээр сарын 8-ны өдөр хэлэлцэн баталсан. Улмаар Монгол Улсын Ерөнхийлөгчөөс гадаад зах зээлийн тогтворгүй байдал, түүхий эдийн үнийн хэлбэлзлээс үүдэн 2025 оны төсвийг үр ашигтай, хэмнэлттэй, алдагдалгүй батлах шаардлагатай гэсэн үндэслэлээр 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдөр бүхэлд нь хориг тавьсан. Улсын Их хурлын нэгдсэн чуулганаар Ерөнхийлөгчийн хоригийг 2024 оны 11 дүгээр сарын 22-ны өдөр хэлэлцэн, хүлээн авч “алдагдалгүй төсөв батлах” чиглэл өгсний дагуу Засгийн газраас Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг шинэчлэн боловсруулж, дахин өргөн барьж байна.

Төсвийн төсөлд **УРСГАЛ ЗАРДАЛ**-ыг бууруулахад дараах зарчим баримтлав:

1/Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмж, Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, нийгмийн халамжийн сангаас олгох хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, түүнчлэн төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмжийн зардал, зээлийн үйлчилгээний төлбөр, мөн хуульд заасны дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хорооноос төсвийг нь хянаж жилийн төсөвт тусгуулахаар ирүүлсэн төрийн тусгай байгууллагуудын урсгал зардлыг тус тус бууруулахгүй;

2/Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг дараах байдлаар 10-100 хувь бууруулна:

а/салбар харгалзахгүйгээр бүх төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт, семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүнд ажлын хөлс, урамшуулал олгох зардлыг 100 хувь бууруулах;

б/соёлын эрхийн бичиг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, Кино урлагийг дэмжих сан, засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, эрүүл мэндийн сургалт сурталчилгаа хийх зардлыг 100 хувь бууруулах;

в/эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр шатахууны зардал, Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Монгол Улсын Ерөнхий сайд, Гадаад харилцааны сайдаас бусад төсвийн ерөнхийлөн захирагч нарын гадаад албан томилолт болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, гадаад харилцаа, хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл сургуулилт хийх зардал, бүх шатны төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж техник хэрэгсэл худалдан авах зардлыг тус тус 50 хувиар бууруулах;

г/дээр дурдсан 50-100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материал, шуудан холбоо, эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар ашиглалт, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг 10 хувиар бууруулах зэрэг болно.

Улсын төсвийн **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ГАДААД ЗЭЭЛИЙН АШИГЛАЛТ**-ыг төлөвлөхөд дараах зарчим баримталлаа:

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан, ажлыг эхлүүлсэн төслүүдийг дуусгана.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр тусгагдсан төсөл, арга хэмжээнээс гэрээ байгуулсан, ажлыг эхлүүлсэн 512 төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг бууруулаагүй буюу 2,080.0 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тусгасан.

Хоёр. Гэрээ байгуулаагүй, ажил эхлээгүй улсын төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг эрэмбэлж, хойшлуулна.

1/Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлж эхлүүлэхээр батлагдан ирэх онд үргэлжлэн хэрэгжих боловч 2024 оны 12 дугаар сарын 02-ны байдлаар гэрээ байгуулаагүй 32 төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих 117.8 тэрбум төгрөгийг хойшлуулсан.

2/Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд зам тээвэр, эрчим хүч, дэд бүтцийн томоохон төслүүдийн хүрээнд 38 төслийг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг дахин эрэмбэлж бүс нутагт нэн тэргүүний, богино хугацаанд хэрэгжих боломжтой, дараа онуудад төсөвт ачаалал бага үүсгэх төслүүдийг 2025 онд хэрэгжүүлэхээр 29 төсөл, арга хэмжээнд 497.0 тэрбум төгрөгийг тусгасан.

Гурав. Зарим их засвар, ТЭЗҮ, зураг төсөв, тоног төхөөрөмжийн санхүүжилтийг бууруулна.

1/Зарим их засвар, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах 8 төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 62.1 тэрбум төгрөгөөр бууруулсан.

2/Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэх, иргэдийг төрийн үйл ажиллагаагаар хэвийн хангахад шаардлагатай тоног төхөөрөмж болон шинээр ашиглалтад орж буй сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн салбарын барилгуудын тоног төхөөрөмжийн зардлыг 2025 оны төсвийн төсөлд анх төлөвлөж өргөн барьсан хэмжээнээс 20 хувь бууруулсан.

Дөрөв. Хэлэлцээрийн шатанд байгаа төслийг хойшлуулна.

Үндэсний хиймэл дагуулын төсөл хэлэлцээрийн шатанд байгаатай холбогдуулан 2025 оны зээлийн ашиглалт 211.6 тэрбум төгрөг, зарим зээлийн төслүүдийн санхүүжилтийг 300.0 тэрбум төгрөгөөр тус тус бууруулж, нийтдээ 511.6 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалтыг төсвийн төсөлд буурууллаа. Мөн тус зээлийн ашиглалттай холбоотой Монголын талын санхүүжилтийг бууруулах зарчим баримталлаа.

Тав. “Хавдар судлалын Үндэсний төв-II” хөрөнгө оруулалтыг нэмж тусгана.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр “Хавдар судлалын Үндэсний төв-II барилга” төсөл, арга хэмжээ тусгагдсан боловч газрын асуудлыг бүрэн шийдвэрлэгдээгүйгээс тендер шалгаруулалт зарлаагүй хасагдсан. Төслийн газрын асуудлыг шийдвэрлэгдсэн бөгөөд хавдрын эрт илрүүлэг, оношилгоог сайжруулах, хавдрын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэхэд ач холбогдолтой, нийгмийн үр ашигтай учир төслийн төсөвт өртөг 10.0 тэрбум, санхүүжих дүнг 5 тэрбум төгрөгөөр төсвийн төсөлд тусгалаа.

Мөн Хавдар судлалын үндэсний төвийн одоогийн барилга нь 1981 онд баригдсан бөгөөд урсгал засвар зайлшгүй хийж, хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор их засвар, шинэчлэлтэд 5.7 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 2.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлэхээр төсвийн төсөлд шинээр тусгалаа.

НЭГДСЭН ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГЫГ төсвийн хөрөнгө оруулалт, зарлагын бууралттай холбогдуулан 394.7 тэрбум төгрөгөөр буурахаар тооцлоо. Үүнд: гаалийн орлого 174.0 тэрбум, нийгмийн даатгал, эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн орлого 25.0 тэрбум, дотоодын барааны НӨАТ 112.3 тэрбум, хувь хүний орлогын албан татвар 21.0 тэрбум, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар 50.3 тэрбум, бусад орлого 12.0 тэрбум төгрөгөөр тус тус буурахаар байна.

Ингэснээр нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35.2 хувь, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35.2 хувьд хүрч нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалгүй болж, суурь тэнцэл дотоодын нийт бүтээгдэхүүний 3.5 хувийн ашигтай болохоор байна.

Ирэх 2025 оны төсөв алдагдалгүй болсноор импорт буурч, гадаад худалдааны тэнцэл сайжран, инфляцын дарамтыг саарч, мөнгөний бодлогын орон зайг нэмэгдүүлэх зэрэг нөлөөтэй ч гэсэн хөгжлийн бүтээн байгуулалтуудын хөрөнгө оруулалтууд хумигдаж, Засгийн газрын ирэх 4 жилд дэвшүүлж буй нэг хүнд ногдох дотоодын нийт бүтээгдэхүүнийг 10 мянган ам.долларт, хүний хөгжлийн индексийг 10 байраар ахиулах, ядуурлын түвшнийг 2 дахин бууруулах зэрэг хөгжлийн зорилтуудад хүрэх боломжийг хойшлуулж болзошгүй.

Иймд Засгийн газраас урт хугацааны тогтвортой хөгжлийн суурь дэд бүтцийг бий болгох 14 мега төслийг 2025 онд эхлүүлж, уул уурхайн бус салбарын өсөлтийг дэмжих замаар макро эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах, төсвийн орлогыг нэмэгдүүлэх салбаруудын бодлогын цогц реформыг хэрэгжүүлнэ.

Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хамгаалж, хөрөнгө оруулалтын орчныг сайжруулан төр, хувийн хэвшлийн түншлэл, гадаадын шууд хөрөнгө оруулалтаар хэрэгжих томоохон төслүүдийг урагшлуулж, төрийн өмчийн компаниудын засаглалыг сайжруулах, зарим чиг үүргийг хувийн хэвшилд шилжүүлэх замаар эдийн засгийг тэлэх бодлогыг баримтална.

Бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэх татварын ялгаатай бодлогыг 2025 оноос эхлэн хэрэгжүүлж, бүс, орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлэх, бие даан хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн бодлогоор өрсөлдөх боломжийг бүрдүүлнэ.

Монгол Улсын хөгжлийн 2025 онд баримтлах бодлогын тэргүүлэх чиглэл нь “урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах суурийг бэхжүүлэх” бөгөөд Эдийн засаг, Бүсчилсэн хөгжил, Хүний хөгжил, Хүний эрхийг дээдэлсэн засаглалын үндсэн бодлогын хүрээнд өнөөгийн нөхцөл байдал, тулгамдаж байгаа асуудлуудад үндэслэн тодорхойлж, шаардлагатай салбарын реформыг эхлүүлж, тэргүүлэх ач холбогдолтой хөгжлийн томоохон төслүүдийг эрчимжүүлэхээр тусгасан.

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн дагуу Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсөв нь улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэсэн байна.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ГҮЙЦЭТГЭЛ

1.1. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл байдал, хүлээгдэж буй гүйцэтгэл

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Нэрлэсэн ДНБ 2024 оны эхний 3 улирлын байдлаар 56.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 19 хувиар, 2015 оны зэрэгцүүлэх үнээр тооцсон бодит ДНБ 23 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар тус тус өслөө. Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйгаас бусад салбарууд эерэг хувь нэмэр орууллаа.

Хүснэгт 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, салбаруудаар (хувь)

ҮЗҮҮЛЭЛТ	2020	2021	2022	2023	2024.III
ДНБ	-4.6	1.6	5.0	7.4	5.0
Хөдөө аж ахуй	0.8	-0.8	1.7	-1.3	-3.5
Үйлдвэрлэл	-1.3	-0.6	-1.2	3.2	1.7
Уул уурхай	-1.4	0.1	-2.1	2.6	1.4
Боловсруулах	0.3	-0.1	0.5	0.4	0.0
Цахилгаан, ус	0.0	0.2	0.1	0.1	0.1
Барилга	-0.1	-0.9	0.2	0.1	0.1
Үйлчилгээ	-3.0	1.8	3.2	4.7	4.6
Худалдаа	-1.4	0.6	1.1	0.8	0.9
Тээвэр	-1.0	-0.3	0.4	1.8	0.9
Бусад	-0.6	1.5	1.7	2.1	2.9
Цэвэр татвар	-1.1	1.3	1.4	0.8	2.1

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо


Худалдаа, үйлчилгээний салбар идэвхжиж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдсэн нь эдийн засгийн өсөлтийг дэмжиж байгаа бол хөдөө аж ахуйн салбарын уналт өсөлтийг хязгаарласан хэвээр байна. Нүүрс, төмрийн хүдрийн олборлолт болон зэсийн баяжмалын үйлдвэрлэл¹ нэмэгдсэнээр уул уурхайн салбар 2024 оны эхний 3 улиралд 11.4 хувиар, тээврийн салбар 15.7 хувиар тус тус тэлж, эдийн засгийн өсөлтийн 2.3 нэгж хувийг бүрдүүллээ. Өрхийн бодит орлого нэмэгдэж, эдийн засаг дахь худалдан авалтын идэвх нэмэгдсэнээр бөөний болон жижиглэн худалдааны салбар 7.9 хувиар өсөж, үйлчилгээний салбарын идэвх сайжрав. Бүх төрлийн ундаа, химийн бодис болон химийн бүтээгдэхүүн үйлдвэрлэл боловсруулах салбарын өсөлтийг хадгалсаар байна. Нийслэлийн инженерийн барилга байгууламжийн бүтээн байгуулалт барилгын салбарын өсөлтийг тэтгэлээ. Харин том малын зүй бус хорогдол 2024 оны 3 дугаар улирлын байдлаар 8.1 сая толгойд хүрч өмнөх оны мөн үеэс 4.2 сая толгой малаар нэмж хорогдсоноор хөдөө аж ахуйн салбар 25 хувиар агшлаа.

Эрэлт талаас цалин, тэтгэврийг нэмэгдүүлснээр төрийн болон өрхийн хэрэглээ тэлж, эдийн засгийн өсөлтийг голлон тайлбарлаж байна. Дотоод эрэлтийн өсөлтийн дам нөлөөгөөр хөрөнгө оруулалт, хэрэглээний бараа, бүтээгдэхүүний импорт эрчимжиж, цэвэр экспорт өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна.

¹ 2024 оны эхний 10 сарын байдлаар нүүрс олборлолт 81.1 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 26 хувиар, төмрийн хүдэр, баяжмал олборлолт 8.3 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 25 хувиар, зэсийн баяжмал үйлдвэрлэл 1,257 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар тус тус өссөн байна. Харин алт олборлолт 11.0 тонн, газрын тос олборлолт 3.5 сая баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 12 болон 15 хувиар тус тус буураад байна.

Эдийн засгийн өсөлтийг 2024 оны эцэст 5.6 хувь байхаар төсөөлж байна. Салбаруудаар авч үзвэл, Оюутолгойн гүний уурхайн олборлолтын нөлөөгөөр баяжмал дахь зэс болон алтны агуулга нэмэгдэхийн зэрэгцээ нүүрс, төмрийн хүдрийн олборлолт өсөж, уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэмэгдэхээр байна. Уул уурхайн салбарын дам нөлөөгөөр ачаа тээвэр өсөлттэй байх бол жуулчдыг татахад чиглэсэн арга хэмжээнүүдийн нөлөөгөөр 2024 оны сүүлийн хагас жилд аялал жуулчлал, үйлчилгээний салбар өсөх хүлээлттэй байна. Цалин, тэтгэвэр, тэтгэмж нэмэгдсэнээр өрхийн хэрэглээ өсөж, дотоод эдийн засгийн идэвхжил хадгалагдан улмаар худалдаа, үйлчилгээний борлуулалт нэмэгдэн эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлэхээр байна. Харин цаг агаарын таагүй нөхцөл байдлын улмаас хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл 2024 онд агшиж, өсөлтийг хязгаарлахаар байна.

Зураг 1. ДНБ-ий өсөлтийн бүтэц, эрэлтийн бүрэлдэхүүнээр (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Инфляц: Инфляц 2024 оны 10 дугаар сард 7.0 хувь хүрч, өмнөх оны мөн үеэс 2.0 нэгж хувиар буурч, өмнөх сараас 0.3 нэгж хувиар эрчимжлээ. Инфляц өмнөх оны мөн үеэс буурахад хүнсний бараа, согтууруулах бус ундаа, тээвэр, хувь хүнд хандсан бараа, үйлчилгээний үнэ голчлон нөлөөлсөн бол өмнөх сараас эрчимжихэд хувцас, орон сууцны түрээсийн болон засварын зардал өссөн нь голчлон нөлөөллөө. Импортын барааны үнэ 2024 оны 10 дугаар сард жилийн 5 хувиар өсөж, инфляцын 2.2 нэгж хувь буюу 32.8 хувийг бүрдүүлсэн байна. Импортын инфляцын дийлэнх хэсгийг хүнсний бус барааны үнийн өсөлт бүрдүүлсэн хэвээр байна. Дотоодын бараа, үйлчилгээний үнэ 2024 оны 10 дугаар сард жилийн 8.8 хувиар өсөж, инфляцын 4.8 нэгж хувь буюу 67.2 хувийг бүрдүүллээ.

Улсын жилийн инфляц 2024 оны эцэст төв банкны зорилтот түвшин болох 6 ± 2 хувийн дээд интервал орчимд байхаар хүлээгдэж байна.

Зураг 2. Жилийн инфляц ба зорилтот түвшин (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Мөнгөний нийлүүлэлт: Мөнгөний нийлүүлэлт 2024 оны 10 дугаар сарын байдлаар 42.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.1 хувиар өслөө. Мөнгөний нийлүүлэлт өсөхөд эх үүсвэр талаас (пассив) төгрөгийн харилцах, хадгаламжийн өсөлт голлон нөлөөсөн бөгөөд нийлбэр дүнгээрээ өмнөх оны мөн үеэс 35.3 хувиар өсөж, нийт өсөлтийн 23.9 нэгж хувийг бүрдүүлжээ. Харин байршуулалт талаас (актив) дотоод зээл болон гадаад цэвэр активын өсөлт мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд голлох нөлөөг үзүүлэв.

Ажил эрхлэлт, ажилгүйдэл: Ажилчдын тоо 2024 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 34 мянгаар, цар тахлын өмнөх үеэс 121 мянгаар өсөж 1 сая 360 мянгад хүрлээ. Салбараар авч үзвэл үйлчилгээ, худалдаа, тээвэр, уул уурхай, барилгын салбарын ажилчид өмнөх оны мөн үеэс өссөн үзүүлэлттэй байна. Харин хөдөө аж ахуйн салбарын бууралт болон боловсруулах үйлдвэр, цахилгаан, ус хангамжийн салбарын ажилчдын тоо буурсан нь өсөлтийг саарууллаа. Ажиллах хүч 2024 оны 3 дугаар улирлын байдлаар өмнөх оны мөн үеэс 48 мянгаар өсөж 1 сая 448 мянгад хүрлээ. Үүнд ажилчдын тооны өсөлтөөс гадна, ажиллах хүчнээс гадуурх хүн ам буурсан нь нөлөөллөө. Ингэснээр ажиллах хүчний оролцооны түвшин өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар өсөж 63.0 хувьд хүрсэн байна.

Зураг 3. Ажиллагчдын тооны өөрчлөлт, салбараар (мянган хүн)




Зураг 4. Ажиллах хүч (мян.хүн), ажиллах хүчний оролцооны түвшин (хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Төлбөрийн тэнцэл: Төлбөрийн тэнцэл 2024 оны эхний 10 сард 257 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 1.0 тэрбум ам.доллароор нэмэгдсэн бол импортын өсөлт 2.2 тэрбум ам.долларт хүрснээр урсгал данс 1.5 тэрбум ам.долларын алдагдалтай гарлаа. Шууд хөрөнгө оруулалт, гадаад бондын орох урсгал нэмэгдсэнээр санхүүгийн дансны ашиг 1.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.4 тэрбум ам.доллароор нэмэгдлээ. Гадаад валютын улсын нөөц 2024 оны 10 дугаар сарын эцсийн байдлаар 4.7 тэрбум ам.доллар буюу бараа, үйлчилгээний импортын 3.6 сарын хэрэгцээг хангах түвшинд байна.

Зураг 5. Төлбөрийн тэнцэл (сая ам.доллар)



Зураг 6. Гадаад валютын нөөц (сая ам.доллар)



Эх сурвалж: Монголбанк

Эх сурвалж: Монголбанк, ЭЗХЯ-ны тооцоолол


Гадаад худалдаа: Гадаад худалдааны нийт бараа эргэлт 2024 оны эхний 10 сард 22.7 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 13.7 хувиар өссөн бол худалдааны тэнцэл 3.6 тэрбум ам.долларын ашигтай гарлаа.

Экспорт 2024 оны эхний 10 сард 13.2 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 5.9 хувиар өслөө. Оюутолгойн гүний уурхайн олборлолт эхэлсэнтэй холбоотойгоор тус компанийн зэсийн баяжмал дахь цэвэр зэсийн агуулга нэмэгдсэн, дэлхийн зах зээл дэх цэвэр зэсийн үнэ өссөн зэргээс шалтгаалан зэсийн баяжмалын экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 18.7 хувиар өссөн байна. БНХАУ-ын уурхайн хяналт шалгалтын улмаас тус улсын коксжих нүүрсний дотоод үйлдвэрлэл буурсан нь коксжих нүүрсний эрэлтийг өдөөж, Монгол Улс энэ оны эхний 10 сард 68.5 сая тонн нүүрс экспортолж, нүүрсний экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 3.6 хувиар нэмэгдлээ. Төмөр замын тээвэр зохион байгуулалт сайжирч, дотоод үйлдвэрлэл нэмэгдсэнээр төмрийн хүдрийн экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 35.6 хувиар, дэлхийн зах зээл дэх алтны үнэ өссөнөөс шалтгаалан алтны экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 24.1 хувиар тус тус өссөн байна. Харин уул уурхайн бус бүтээгдэхүүний экспортын орлого өнгөрсөн оны мөн үеэс 15 хувиар буурсан бөгөөд үүнд нийт нутгийн дийлэнх хэсгийг хамарсан өвөлжилт, хаваржилтын хүндрэл голлон нөлөөллөө. Тухайлбал, 2024 оны эхний 10 сард өмнөх оны мөн үетэй харьцуулахад махны экспорт 19 хувиар, ноосны экспорт 17 хувиар, арьс ширний экспорт 18 хувиар тус тус буурсан байна.

Импорт 2024 оны эхний 10 сард 9.6 тэрбум ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 26.7 хувиар буюу 2.0 тэрбум ам.доллараар өслөө. Импортын өсөлтийн 15 хувийг үнийн өсөлт, 85 хувийг тоо хэмжээний өсөлт бүрдүүлж байна. Харин импортын өсөлтийг барааны бүлгээр авч үзвэл нийт өсөлтийн 9.9 нэгж хувийг машин механик, тоног төхөөрөмж, 10.6 нэгж хувийг хэрэглээний бүтээгдэхүүн, 4.5 нэгж хувийг аж үйлдвэрийн орц тус тус бүрдүүлсэн байна. Дотоодын эдийн засгийн өсөлт тогтвортой хадгалагдаж, аж ахуй нэгжүүдийн санхүүгийн эх үүсвэр сайжирснаар тоног төхөөрөмжийн импорт өмнөх оны мөн үеэс 34 хувиар өсөж, 1.8 тэрбум ам.долларт хүрлээ.

Дотоодын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх хүрээнд эрчим хүч, хүнс, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалттай зарим тоног төхөөрөмжийг гаалийн татвараас чөлөөлснөөр тоног төхөөрөмжийн импорт нэмэгдэж, цаашид боловсруулах үйлдвэрлэлийн салбарыг дэмжихээр байна. Мөн уул уурхай болон тээврийн салбарын

Зураг 8. Гадаад худалдааны нийт бараа эргэлт (тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

Зураг 7. Импорт, хэрэглээний зориулалтаар (тэрбум ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

идэвхжилтэй холбоотойгоор ачааны тээврийн хэрэгслийн импорт 610 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 83 хувиар, экскаватор, шанагат ачигчийн импорт 285 сая ам.долларт хүрч 2 дахин, дизелийн түлшний импорт 1.1 тэрбум ам.долларт хүрч, 25 хувиар тус тус өслөө.

Иргэдийн зээлийн өсөлт нь удаан эдэлгээтэй хэрэглээний бүтээгдэхүүний эрэлтийг нэмэгдүүлэх хандлагатай байдаг бөгөөд энэ оны 3 дугаар улирлын байдлаар иргэдийн зээл өмнөх оны мөн үеэс 37 хувиар өсөж, суудлын машины импорт 900 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 59 хувиар өссөн байна. Суудлын авто машины импорт өсөж, аймаг, сумдын тэмдэглэлт ойн арга хэмжээтэй холбоотойгоор орон нутаг руу зорчих хөдөлгөөн нэмэгдсэнээр авто бензиний импорт 510 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 20 хувиар өслөө.

1.2. Макро эдийн засгийн 2025 оны чиг хандлага, төсөөлөл

Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал

Дэлхийн эдийн засгийн өсөлт 2024 болон 2025 онд 3.2 хувьд тогтвортой хадгалагдана гэж Олон улсын валютын сан (ОУВС) тооцоолж байна. Инфляцын дарамт буурсантай холбоотойгоор дэлхийн томоохон эдийн засгууд бодлогын хүүг бууруулж эхэлсэн нь цаашид эдийн засгийн идэвхжилийг дэмжихээр хүлээгдэж байна. Гэсэн хэдий ч геополитикийн тогтворгүй нөхцөл байдал үргэлжилж, худалдааны бодлогоос үүдэлтэй тодорхой бус байдал нэмэгдэх, голлох эдийн засгуудын өсөлт удаашрах, инфляц төсөөллөөс удаан хугацаанд өндөр түвшинд хадгалагдах зэрэг эрсдэлүүд дэлхийн эдийн засгийн төлөвийг муутгаж болзошгүй хэвээр байна.

Хүснэгт 2. Дэлхийн эдийн засгийн өсөлтийн төсөөлөл (хувь)

БАЙГУУЛЛАГА	2024	2025
ОУВС	3.2	3.2
Дэлхийн банк	2.6	2.7
ОЕСД	3.2	3.2

Эх сурвалж: Дэлхийн эдийн засгийн төлөвийн тайлангууд

БНХАУ: БНХАУ-ын эдийн засаг 2024 оны эхний 3 улиралд 4.8 хувиар өслөө. Тус улсын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилсэн хэвээр, дотоод эрэлт сул байгаа нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлаж байна. АНУ-ын зүгээс БНХАУ-аас импортлох бараа, бүтээгдэхүүнд ногдуулах тарифыг нэмэгдүүлэхээр байгаа нь тус улсын эдийн засагт хэрхэн нөлөөлөх нь худалдааны бодлогын өөрчлөлтийн цар хүрээ, хэрэгжих эхлэх хугацаанаас хамаарахаар байна. БНХАУ-ын эдийн засгийн өсөлт 2024 онд 4.8 хувь, 2025 онд 4.5 хувь орчимд байна гэж ОУВС төсөөлж байна.

ОХУ: ОХУ-ын эдийн засаг 2024 оны 3 дугаар улиралд 3.1 хувиар өссөн байна. Эдийн засгийн өсөлтөд дайнтай холбоотой цэрэг армийн зардлын өсөлтөөс шалтгаалсан төсвийн тэлэлт голлон нөлөөллөө. Цаашид дайнтай холбоотойгоор тус улсын эдийн засагт тогтворгүй байдал үргэлжлэх төлөвтэй байна. ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2024 онд 3.6 хувь, 2025 онд 1.3 хувь орчимд байна гэж ОУВС тооцоолж байна.


АНУ: Хувийн хэрэглээ, хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр АНУ-ын эдийн засаг 2024 оны 3 дугаар улиралд 2.8 хувиар тэллээ. Тус улсын төв банк үнийн өсөлт, хөдөлмөрийн зах зээлийн төлөв байдалтай уялдуулан бодлогын хүүг энэ онд 2 удаа бууруулаад байна. ОУВС-гаас тус улсын эдийн засгийн өсөлт 2024 онд 2.8 хувьд хүрэх бол хөдөлмөрийн зах зээлийн халалт намжиж, хэрэглээний өсөлт саарах нөлөөгөөр эдийн засгийн өсөлт 2025 онд 2.2 хувьд хүрч саарна гэж тооцоолж байна.

Евро бүс: Евро бүсийн эдийн засгийн өсөлт 2024 оны 3 дугаар улиралд 0.4 хувьд хүрч, хүлээлтээс давлаа. Европын төв банк бодлогын хүүг инфляцын зорилтот түвшинтэй уялдуулан 2024 онд 3 удаа бууруулаад байна. Мөнгөний бодлогын нөлөөгөөр тус бүсийн эдийн засаг 2024 онд 0.8 хувиар өсөх бол хэрэглээ болон хөрөнгө оруулалтын өсөлтийн нөлөөгөөр өсөлт 2025 онд 1.2 хувьд хүрч нэмэгдэнэ гэж ОУВС тооцоолж байна.

Түүхий эдийн зах зээлийн хандлага

Зэс: Лондоны металлын бирж дэх цэвэр зэсийн 2024 оны эхний 11 сарын дундаж үнэ 9,166 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 8 хувиар өссөн байна. Дэлхийн томоохон зэсийн ил уурхайнуудын нэг болох “Кобре Панам” хаагдсан, “Англо Американ” компани зардлаа танаж, зэсийн үйлдвэрлэлээ бууруулахаа мэдэгдсэн нь богино хугацаанд нийлүүлэлтийн тодорхой бус байдлыг нэмэгдүүлж, үнэ өсөхөд нөлөөлж байна. Сэргээгдэх эрчим хүч, цахилгаан автомашины үйлдвэрлэлийн өсөлтийн нөлөөгөөр зэсийн эрэлт дунд хугацаанд нэмэгдэх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар зэсийн дундаж үнэ 2024 онд 9,500 ам.доллар, 2025 онд 10,000 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 9. Зэсийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл
(ам.доллар/тонн)



Зураг 10. Алтны үнийн хөдөлгөөн, төсөөлөл
(ам.доллар/трой унц)



Эх сурвалж: Блүүмберг терминал

Алт: Лондоны бирж дэх алтны 2024 оны эхний 11 сарын дундаж үнэ 2,366 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 22 хувиар өслөө. Геополитикийн хурцадмал байдал, дэлхийн эдийн засгийн тогтворгүй байдал нэмэгдэж байгаа нь алтны эрэлт болон үнэ өсөхөд нөлөөлж байна. Дэлхийн банкны үзэж байгаагаар дунд хугацаанд дэлхийн эдийн засаг тогтворжиж, алтны эрэлт бага зэрэг сулрах хүлээлттэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар алтны дундаж үнэ 2024 онд 2,200 ам.долларт, 2025 онд 1,850 ам.долларт хүрэхээр байна.

Төмрийн хүдэр: Төмрийн хүдрийн (62 хувийн агууламжтай) 2024 оны эхний 11 сарын дундаж үнэ 111 ам.доллар болж, өмнөх оны эцсээс 8 хувиар буурсан байна. БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбар сул хэвээр байгаа, Австрали улс шинэ уурхайн бүтээн байгуулалтын төслүүдийг эрчимжүүлж, Бразил улс нийлүүлэлтээ жил бүр 6 хувиар нэмэгдүүлэхээ зарласан нь үнэ буурахад голлон нөлөөллөө. Олон улсын шинжээчдийн таамаглалаар төмрийн хүдрийн дундаж үнэ 2024 онд 120 ам.доллар, 2025 онд 100 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 11. Төмрийн хүдрийн үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)



Зураг 12. Австралийн коксжих нүүрсний үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/тонн)



Эх сурвалж: Блүүмберг терминал

Коксжих нүүрс: Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2024 оны эхний 11 сарын дундаж үнэ 247 ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 17 хувиар буурсан байна. Байгалийн гамшигт үзэгдлээс шалтгаалан саатаад байсан Австралийн коксжих нүүрсний олборлолт хэвийн болж, нийлүүлэлт тогтворжсон нь үнэ буурахад голлон нөлөөллөө. БНХАУ коксжих нүүрсний татварыг сэргээсэн нь эрэлтийг бууруулахаар байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар дундаж үнэ 2024 онд 250 ам.доллар, 2025 онд 215 ам.долларт хүрэхээр байна.

Газрын тос: Брент төрлийн газрын тосны 2024 оны эхний 11 сарын дундаж үнэ 77 ам.долларт хүрч, өмнөх оны эцсээс 2 хувиар өслөө. ОПЕК-ийн орнууд өнгөрсөн оны 6 дугаар сард 2024 онд олборлох газрын тосны хэмжээг бууруулахаар шийдвэрлэснээс гадна нефть, газрын тосны олборлолтын 35 орчим хувийг бүрдүүлдэг Ойрх дорнод дахь мөргөлдөөн нь газрын тосны нийлүүлэлтийн тогтворгүй байдлыг бий болгож, үнэ өсөж байна. Түүнчлэн, алт болон газрын тосны томоохон хэрэглэгч Энэтхэг улсын эдийн засгийн идэвхжил газрын тосны эрэлтийг нэмэгдүүлэх төлөвтэй байна. Олон улсын шинжээчдийн таамаглалаар дундаж үнэ 2024 онд 85 ам.доллар, 2025 онд 80 ам.долларт хүрэхээр байна.

Зураг 13. Газрын тосны үнийн хөдөлгөөн, төсөөлөл (ам.доллар/баррель)



Эх сурвалж: Блүүмберг терминал

Монгол Улсын макро эдийн засгийн 2025 оны төсөөлөл

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Эдийн засгийн өсөлтийг 2025 онд 8.0 хувь байхаар төсөөлж байна. Үүнд, Оюутолгойн гүний уурхайгаас олборлох зэсийн баяжмалын үйлдвэрлэл болон баяжмал дахь зэс, алтны агуулга нэмэгдсэнээр уул уурхайн салбар 2025 оны эдийн засгийн өсөлтийн гуравны нэгийг бүрдүүлж, экспортын орлого нэмэгдэн өсөлтийг дэмжих хүлээлттэй байна. Мөн сүүлийн 2 жил дараалан агшсан хөдөө аж ахуйн салбар сэргэж, мал аж ахуйн үйлдвэрлэл нэмэгдсэнээр хөдөө аж ахуй болон боловсруулах салбарын өсөлт нэмэгдэх төлөвтэй байна. Түүнчлэн, эдийн засгийн дотоод

идэвх болон уул уурхайн салбарын өсөлт хадгалагдаж, хөрш орнуудтай хийх чөлөөт худалдааны хэлэлцээр гадаад эрэлтийг тэлснээр боловсруулах салбарын өсөлт тэлж, эдийн засгийн өсөлтөд эерэг нөлөө үзүүлнэ. Мөн хөгжлийн томоохон төсөл хөтөлбөрүүдийн нөлөөгөөр барилгын салбар дах хувийн хэвшлийн хөрөнгө оруулалт тэлснээр барилга, боловсруулах, санхүү, худалдааны салбарын үйл ажиллагааны идэвхийг дэмжиж, нийт эдийн засагт эерэг нөлөө үзүүлэх хүлээлттэй байна.

Гадаад худалдаа: Гадаад худалдаа эрчимжиж, 2025 онд нийт бараа эргэлт 32.5 тэрбум ам.долларт хүрч, тэнцэл 5.3 тэрбум ам долларын ашигтай гарахаар төсөөлж байна. Оюутолгойн зэсийн баяжмал дахь цэвэр зэс, алтны агуулга нэмэгдэж, Тавантолгойн бүлэг ордын нүүрс баяжуулах үйлдвэр ашиглалтад орсноор нүүрсний экспортод эзлэх чанар сайтай баяжуулсан нүүрсний хэмжээ нэмэгдэхээр байна. Түүнчлэн Монгол Улсын Засгийн газраас экспортын зах зээлийг өргөжүүлэх, хилийн боомтуудын дэд бүтцийг нэмэгдүүлж, ачаа нэвтрүүлэх процессыг хөнгөвчлөх зэрэг арга хэмжээнүүдийг хэрэгжүүлснээр нийт экспортын дүн 2025 онд 18.9 тэрбум ам.долларт хүрэхээр байна. Эдийн засгийн өсөлт тогтвортой хадгалагдаж, үйлдвэрлэлийн завсрын хэрэглээнд ашиглагдах бүтээгдэхүүний импорт нэмэгдэнэ. Мөн эдийн засгийг тэлэх томоохон төслүүдийн бүтээн байгуулалтын ажил эрчимжиж, шинээр том төсөл эхлүүлснээр тоног төхөөрөмж, барилгын материалын импорт өснө. Ингэснээр 2025 онд нийт импорт 13.6 тэрбум ам.долларт хүрэхээр төсөөлж байна. Мөн бараа, бүтээгдэхүүнийг импортлохтой холбоотой бүртгэлийг автоматжуулж, боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг өргөжүүлж, нэг боомт дээр төвлөрсөн ачааллыг бууруулснаар импортын барааны эргэлтийн хурд нэмэгдэхээр хүлээгдэж байна.

Инфляц: Инфляц 2025 онд 7.2 хувь орчимд байхаар төсөөлж байна. Түүнчлэн эрчим хүчний найдвартай байдал, хөрөнгө оруулалт ба үйлдвэрлэлийн боломжит хүчин чадлыг нэмэгдүүлэх хүрээнд эрчим хүчний салбарын либералчлалыг эхлүүлсэн нөлөөгөөр 2025 онд инфляц бага зэрэг өсөж, суурь үеийн нөлөө 1 жил хадгалагдахаар байна. Дотоодын хүнсний инфляцыг бууруулах хүрээнд хөдөө аж ахуйн салбарт цогц шинэчлэл хийж, хөдөө аж ахуйн тоног төхөөрөмжийг импортын тарифаас чөлөөлөн, үйлдвэрлэл, технологийг дэмжих бодлого хэрэгжүүлж, дотоодын хүнсний нийлүүлэлт, худалдааны сүлжээг сайжруулах чиглэлд арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.

ШИГТГЭЭ: АЛДАГДАЛТАЙ ТӨСӨВ ҮҮ? АЛДАГДАЛГҮЙ ТӨСӨВ ҮҮ?

Төсвийн алдагдал гэж юу вэ? Төсвийн алдагдал гэдэг нь төсвийн орлогоос давсан зарлагыг хэлдэг. Энэхүү ерөнхий тодорхойлолтоос гадна улс орнууд төсвийн анхдагч алдагдал, төсвийн бүтцийн алдагдал, мөчлөгөөр засварласан төсвийн алдагдал зэрэг олон янзаар төсвийн алдагдлыг тооцдог байна.

Олон Улсын Валютын Сангийн судалгаанаас² авч үзвэл өндөр хөгжилтэй буюу орлого өндөртэй улс орнууд болон өрийн түвшин өндөр улс орнууд алдагдалгүй болон ашигтай төсөв баталж байна.

Хүснэгт 1. Алдагдалгүй эсвэл ашигтай төсөв баталдаг улс орнууд

Өндөр хөгжилтэй буюу төсвийн орлого өндөр улс орнууд	Өрийн түвшин өндөр улс орнууд
<ul style="list-style-type: none"> Хуулийн заалтад алдагдалгүй төсөв батлахыг тусгасан: Австрали, Сингапур, Швейцар гэх зэрэг улсууд. Алдагдалтай тэнцлийн дүрэмтэй ч алдагдалгүй төсөв баталдаг: Норвег, Дани, Ирланд гэх зэрэг улсууд. 	<p>Португал, Конго, Бразил, Ливи, Конго гэх зэрэг улсууд ордог.</p>

Түүнчлэн, улс орнууд өөрсдийн эдийн засгийн онцлогтоо тулгуурласан төсвийн дүрмийг хэрэгжүүлдэг. Нийт төсвийн тэнцлийн дүрэмтэй 93 улс орон байгаагаас 82 улс орон алдагдалтай төсвийн дүрэм баримталдаг байна.

Яагаад алдагдалтай төсөв баталдаг вэ? Алдагдалтай төсөв батлах нь улс орнуудад хөгжлийн төслүүдийг санхүүжүүлэх, эдийн засгийн өсөлт болон нийгмийн хэрэгцээг хангахын тулд хэрэгжүүлдэг нийтлэг арга барил юм.

Монгол улстай ойролцоо эдийн засаг бүхий улс орнуудыг авч үзвэл сүүлийн жилүүдийн төсөв нь тодорхой хязгаарт алдагдалтай байна (зураг 1).

Зураг 1. Улс орнуудын нэг хүнд ногдох ДНБ ба батлагдсан төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь



² Олон Улсын Валютын Сангийн улс орнуудын төсвийн нэгдсэн сан

ХОЁРДУГААР БҮЛЭГ: ТӨСӨВ, САНХҮҮГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ, ХҮЛЭЭГДЭЖ БАЙГАА ГҮЙЦЭТГЭЛ

2.1. Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсөв

Нэгдсэн төсвийн нийт орлого 2024 оны эхний 10 сарын гүйцэтгэлээр өмнөх оны мөн үетэй харьцуулахад 28.7 хувиар өсөж 25,455.6 тэрбум төгрөгт, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 32.2 хувиар өсөж 22,343.9 тэрбум төгрөгт хүрсэн үзүүлэлттэй байна.

Хүснэгт 3. Нэгдсэн төсвийн 2024 оны эхний 10 сарын гүйцэтгэлийг өмнөх оны мөн үетэй харьцуулсан харьцуулалт (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.10 гүйц.	2024.10 гүйц.	ӨСӨЛТИЙН ХУВЬ
НИЙТ ОРЛОГО	19,775.4	25,455.6	28.7
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	18,961.9	23,867.0	25.9
НИЙТ ЗАРЛАГА	16,900.4	22,343.9	32.2
Урсгал зарлага	13,380.2	17,381.0	29.9
Хөрөнгийн зарлага	3,317.2	4,657.4	40.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	203.0	305.6	50.5
ТӨСВИЙН ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	2,061.5	1,523.0	-26.1

2.1.1. Төсвийн орлогын гүйцэтгэл, хүлээгдэж байгаа гүйцэтгэл

Монгол Улсын Засгийн газар сүүлийн жилүүдэд эдийн засгийг идэвхжүүлэх, экспортыг дэмжих, иргэдийн орлогыг хамгаалах, төрийн өмчийн хуулийн этгээдийн засаглал, ил тод байдлыг сайжруулах чиглэлээр шат дараалсан бодлогын арга хэмжээг амжилттай авч хэрэгжүүлж байна.

Эдгээр арга хэмжээний үр дүнд 2020 онд 4.6 хувиар агшаад байсан эдийн засаг 2023 онд 7.4 хувийн өсөлттэй гарсан. Нүүрсний экспорт 2021 онд 16 сая тонн болж буураад байсан бол 2023 онд 69.6 сая тоннд хүрч түүхэн дээд амжилт тогтоосон. Ингэснээр төсвийн орлогын төлөвлөгөө сүүлийн 4 жил тасралтгүй давж биеллээ.

Хүснэгт 4. 2024 оны эхний 10 сарын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.10 ГҮЙЦ	2024.10 ГҮЙЦ	ЗӨРҮҮ
Нийт орлого	19,775.4	25,455.6	5,680.3
Тогтворжуулалтын сан	612.8	399.0	-213.8
Ирээдүйн өв сан	200.7	750.6	550.0
Хуримтлалын сан	0.0	439.0	439.0
Тэнцвэржүүлсэн орлого	18,961.9	23,867.0	4,905.1
Татварын орлого	17,634.6	22,280.7	4,646.2
Татварын бус орлого	1,327.3	1,586.2	258.9

Эдийн засаг өсөж, гадаад худалдааны эргэлт сайжирч, уул уурхай, тээвэр болон үйлчилгээний салбарын орлого өссөн нь төсвийн орлого ийнхүү нэмэгдэхэд гол нөлөө үзүүлсэн байна. Нэгдсэн төсвийн нийт орлого 2024 оны эхний 10 сарын байдлаар 25,455.6 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 5,680.3 тэрбум төгрөгөөр буюу 28.7 хувиар өссөн байна. Үүнд, нүүрсний экспорт энэ оны эхний 10 сарын байдлаар 68.5 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 14.1 сая тонноор буюу 25.9 хувиар өссөн нь голлон нөлөөлжээ. Мөн эдийн засаг идэвхжиж, энэ оны эхний 3 дугаар улирлын байдлаар эдийн засгийн өсөлт 5 хувьд хүрч, нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүн 56.2 их наяд төгрөгт хүрсэн нь орлогын өсөлтөд эерэг хувь нэмэр оруулсан байна.

Монгол Улсын 2024 оны нэгдсэн төсвийн орлого 30,639.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны гүйцэтгэлээс 6,252.5 тэрбум төгрөгөөр, тэнцвэржүүлсэн орлого 28,872.5 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны гүйцэтгэлээс 5,577.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэхээр хүлээгдэж байна.

Засгийн газар худалдааны эргэлт, экспортын хэмжээг нэмэгдүүлэх, тогтвортой байлгах бодлогын арга хэмжээг үргэлжлүүлэн авч хэрэгжүүлснээр хилийн боомтын нэвтрэх чадварыг сайжруулах, хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгслийн тоог нэмэгдүүлнэ. Ингэснээр нүүрсний экспортын хэмжээг 78.1 сая тоннд хүрэхээр тооцож байна.

2.1.2. Төсвийн зарлагын гүйцэтгэл, хүлээгдэж байгаа гүйцэтгэл

Төсвийн нийт урсгал зардал 2024 онд 22.4 их наяд төгрөгт хүрэхээр байгаа бөгөөд үүний 59.4 хувийг төрөөс иргэдэд олгодог тэтгэвэр, тэтгэмж, халамж, хүүхдийн мөнгө, болон хуульд заасны дагуу тарифаар гүйцэтгэлд үндэслэн санхүүждэг эрүүл мэнд, боловсролын салбарын цалин хөлс, 16.9 хувийг төсвийн байгууллагын хэвийн үйл ажиллагаатай холбоотой зардал, 14.4 хувийг бусад салбарын цалин хөлс нэмэгдэл, урамшууллын зардал, 5.3 хувийг гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөр 4.0 хувийг төрөөс иргэн, аж ахуй нэгжид олгох хөнгөлөлт татаас тус тус эзэлж байна.

Хүснэгт 5. 2024 оны эхний 10 сарын нэгдсэн төсвийн урсгал зарлагын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2023.10 ГҮЙЦ	2024.10 ГҮЙЦ	ЗӨРҮҮ
Нийт урсгал зарлага	13,380.2	17,381.0	4,000.8
Бараа, ажил үйлчилгээний зардал	3,614.9	6,916.4	3,301.5
<i>Үүнээс Цалин хөлс</i>	<i>1,765.0</i>	<i>4,124.6</i>	<i>2,359.6</i>
Хүү	1,025.4	1,076.5	51.1
Татаас	430.3	731.6	301.3
Урсгал шилжүүлэг	8,309.6	8,656.5	346.9


Нэгдсэн төсвийн урсгал зарлага 2024 оны 10 сарын байдлаар 17,381.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарсан бөгөөд энэ нь өмнөх оны мөн үеэс 4,000.8 тэрбум төгрөгөөр буюу 29.9 хувиар өссөн байна. Үүнд, Монгол Улсын Засгийн газраас нийт төрийн албан хаагчдын цалинг 2023 оны 7 дугаар сарын 1-ээс дунджаар 40.0 хувиар, 2024 оны 4 дүгээр сарын 1-ээс төрийн үйлчилгээний албан хаагчдын цалинг 20.0 хувиар, бусад төрийн албан хаагчдын цалинг 10.0 хувиар нэмэгдүүлсэн, мөн Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр тогтооход баримтлах итгэлцүүрийг 2023 онд шинэчилснээр тэтгэврийн зөрүүг бууруулж, тэтгэврийн зөрүүг бууруулсан сууриас тэтгэврийг 2023 оны 7 дугаар сараас 10 хувь, 2024 оны 4 дүгээр сараас 100.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь голлон нөлөөлжээ.

2.1.3. Улсын төсөв, гадаад зээл, тусламжийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэл


Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2020-2023 онд нийтдээ 8.0 их наяд төгрөгийн санхүүжилт батлагдаж, давхардсан тоогоор 6016 төсөл, арга хэмжээг улсын хэмжээнд хэрэгжүүлж, 7.4 их наяд төгрөгийн санхүүжилт олгосон бол 2024 оны төсвийн хөрөнгө оруулалтаар 3.8 их наяд төгрөгийн санхүүжилт бүхий 1320 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлж байна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 1320 төсөл, арга хэмжээнд 3,828.6 тэрбум төгрөг батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын байдлаар санхүүжилтийн гүйцэтгэл 40.5 хувь буюу 1,560.4 тэрбум төгрөг, гадаад зээл, тусламжаар 130 төсөл, арга хэмжээнд 2,767.0 тэрбум төгрөг батлагдаж санхүүжилтийн гүйцэтгэл 76 хувь буюу 2,100.0 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус олгосон байна.

Зураг 14. Улсын төсвийн 2020-2024 оны хөрөнгө оруулалт, гүйцэтгэл (их наяд төгрөг)



Зураг 15. Гадаад зээл, тусламжийн ашиглалт (их наяд төгрөг)



Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаад зээл, тусламжийн санхүүжилтээр 2024 онд барилга, байгууламжийн нийт 1126 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Үүнээс улсын төсвөөр 1020, гадаад зээл, тусламжаар 106 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна.

Зураг 16. Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй барилга, байгууламжийн төсөл, арга хэмжээ



2.2. Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн төсөл

2.2.1. Татварын бодлогын чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ

Нэг. Бүсчилсэн хөгжлийн зорилттой уялдсан татварын бодлого хэрэгжүүлнэ

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт тусгасан бодлоготой уялдуулан бүсүүдийг төрөлжүүлэн хөгжүүлэхэд чиглэсэн татварын ялгаатай бодлогыг эхлэн хэрэгжүүлж эхэлнэ. Энэ хүрээнд Засгийн газар, аймаг, нийслэлийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал тогтоодог 20 орчим төрлийн татварыг бүсийн онцлогоос хамааран ялгаатай тогтоох боломж бүрдэж, бүс орон нутгийн төсвийн бие даасан байдлыг нэмэгдүүлж, хөрөнгө оруулалт татах, эдийн засгийн бодлого хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн.

Бүсчилсэн хөгжлийн бүтээн байгуулалтын ажлыг зөвхөн улсын төсвийн эх үүсвэрээр хийх боломжгүй тул хувийн хэвшлийг урамшуулан идэвхжүүлэх бодлого баримтлах нь зүйтэй байна. Иймд бүсийн тэргүүлэх чиглэлд нийцсэн томоохон төсөл, арга хэмжээ, хөрөнгө оруулалт хийхийг сэдэлжүүлсэн, урамшуулсан импортын барааны гаалийн болон НӨАТ, аж ахуйн нэгжийн орлогын болон үл хөдлөх эд хөрөнгийн албан татварын багц дэмжлэг үзүүлэх болно.

Хоёр. Боловсруулах үйлдвэрийн тоног төхөөрөмжийн импортын гаалийн татварыг хөнгөлж, нэмүү өртөг шингээн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжүүдийг дэмжинэ.

"Алсын хараа-2050" Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд Засгийн газраас 2030 он гэхэд боловсруулах салбарын бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг дэлхийн брэндийн түвшинд хөгжүүлэн, боловсруулсан бүтээгдэхүүний экспортын хэмжээ нэмэгдүүлэх зорилт тавин ажиллаж байгаа ба өнгөрсөн жилүүдэд хөдөө аж ахуйн гаралтай түүхий эд боловсруулах үйлдвэрлэлийг түлхүү дэмжиж байсан.

Цаашид Шинэ сэргэлтийн бодлогын Аж үйлдвэржилтийн сэргэлтийн зорилтын хүрээнд ирэх оноос дэвшилтэт техник, технологи нэвтрүүлэн бүтээгдэхүүнээ хөгжүүлж байгаа зарим салбарын боловсруулах үйлдвэрүүдийг татварын бодлогоор дэмжинэ.

2.2.2. Төсвийн орлого

Улсын Их Хурлын чуулганы 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон хамт өргөн мэдүүлсэн дагалдах бусад хуулиудыг хэлэлцэн хүчингүй болгосон. Улмаар "Хууль, тогтоол хүчингүй болсонтой холбогдуулан авах арга хэмжээний тухай" Улсын Их Хурлын тогтоол баталж, тус тогтоолоор Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Монгол Улсын Засгийн газарт даалгасан болно.

Энэ хүрээнд ирэх оны нэгдсэн төсвийг алдагдалгүй байлгах зорилгоор төсвийн урсгал зардлыг 796.7 тэрбум төгрөг, улсын төсвийн хөрөнгө оруулалтын зардлыг 838.7 тэрбум төгрөг, гадаад зээлийн ашиглалтыг 666.6 тэрбум төгрөг, нийт зарлагыг 2.3 их наяд төгрөгөөр бууруулахаар төсвийн төсөлд тусгасан. Тус өөрчлөлттэй холбогдуулан

хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан нийт орлогыг 394.7 тэрбум төгрөг бууруулж, 36.4 их наяд төгрөгт хүрэхээр тооцлоо.

Хүснэгт 6. 2025 оны нэгдсэн төсвийн нийт орлого (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2024 ХБГ	2025 Суурь*	2025 Төс.	ЗӨРҮҮ
Нийт орлого ба тусламжийн дүн	30,639.5	36,830.4	36,435.7	-394.7
Тогтворжуулалтын сан	478.6	608.9	608.9	0.0
Ирээдүйн өв сан	789.0	1,849.7	1,849.7	0.0
Хуримтлалын сан	499.5	507.1	507.1	0.0
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	28,872.5	33,864.7	33,470.0	-394.7

*Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан дүн

Монгол Улсын 2025 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн

Монгол Улсын 2025 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого суурь түвшинтэй харьцуулахад 394.7 тэрбум төгрөгөөр буурч, 33.5 их наяд төгрөгт хүрэхээр байна.

Хүснэгт 7. 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2024 ХБГ	2025 Суурь*	2025 Төс.	ЗӨРҮҮ
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	28,872.5	33,864.7	33,470.0	-394.7
1. Татварын орлого	26,939.2	31,939.9	31,553.7	-382.7
1.1 Орлогын албан татвар	7,986.0	10,083.7	10,012.3	-71.4
1.2 Нийгмийн даатгалын орлого	5,064.8	6,030.3	6,005.3	-25.0
1.3 Хөрөнгийн албан татвар	354.8	558.2	558.2	0.0
1.4 Нэмэгдсэн өртгийн албан татвар	6,220.2	7,672.3	7,431.0	-241.3
1.5 Онцгой албан татвар	968.0	1,204.0	1,204.0	0.0
1.6 Тусгай зориулалтын орлого	28.0	31.5	31.5	0.0
1.7 Гадаад үйл ажиллагааны орлого	1,932.5	2,239.0	2,194.0	-45.0
1.8 Бусад татвар	4,384.9	4,120.9	4,120.9	0.0
2. Татварын бус орлого	1,933.3	1,924.8	1,912.8	-12.0
2.1 Нийтлэг татварын бус орлого	1,372.8	1,501.7	1,489.6	-12.0
2.2 Хөрөнгийн орлого	2.5	6.2	6.2	0.0
2.3 Тусламжийн орлого	558.0	417.0	417.0	0.0


*Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан дүн

Үүнд, аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого, импортын татварын орлого, дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар, хувь хүний орлогын албан татварын орлого буурахаар байгаа нь голлон нөлөөлж байна.

Харин ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, хөрөнгийн албан татвар, онцгой албан татвар болон бусад орлогууд суурь түвшинтэй харьцуулахад өөрчлөгдөөгүй болно.

Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого

Зураг 17. Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого, салбараар (тэрбум төгрөг)



Шинээр өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд төсвийн нийт зарлагыг 2.3 их наяд төгрөгөөр бууруулж байгаа нь аж ахуйн нэгж, байгууллагын борлуулалтын орлогыг бууруулах нөлөөтэй байна. Үүнтэй холбоотойгоор аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого суурь түвшнээс буюу хүчингүй болсон 2025 оны төсөвт туссан орлогоос даруй 50.3 тэрбум төгрөгөөр буурахаар байна.

Улмаар ирэх онд аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого 7,485.0 тэрбум төгрөгт хүрэхээр тооцсон бөгөөд үүний 152.8 тэрбум төгрөгийг Төсвийн тогтворжуулалтын санд, үлдэх 7,332.2 тэрбум төгрөгийг улсын болон орон нутгийн төсөвт тус тус төвлөрүүлэхээр тооцлоо.

Импортын татварын орлого

Зураг 18. Импортын гаалийн болон нэмэгдсэн өртгийн албан татварын орлого (тэрбум төгрөг)



Дахин өргөн мэдүүлсэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслөөр хөрөнгө оруулалтын зардлыг бууруулахаар тооцоолсон. Үүнтэй холбоотойгоор нийт импортын хэмжээнд өөрчлөлт орсон тул импортын гаалийн албан татварын орлого 45.0 тэрбум төгрөгөөр буурч 2,200.0 тэрбум төгрөг, импортын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 129.0 тэрбум төгрөгөөр буурч 4,694.0 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.

Дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татвар

Зураг 19. Дотоодын нэмэгдсэн өртгийн албан татварын орлого (тэрбум төгрөг)



Шинэчлэн боловсруулж байгаа төсвийн төсөлд урсгал болон хөрөнгө оруулалтын зардал буурч байгаа нь дотоодын эдийн засгийн идэвхжил, аж ахуйн нэгжүүдийн бараа үйлчилгээний худалдан авалтад нөлөө үзүүлэхээр байна. Улмаар дотоодын барааны нэмэгдсэн өртгийн албан татварын орлого 112.3 тэрбум төгрөгөөр буурч, 3,317.0 тэрбум төгрөгт хүрэхээр байна.

Хувь хүний орлогын албан татварын орлого

Засгийн газар сүүлийн жилүүдэд иргэдийн орлогыг хамгаалах зорилгоор төрийн албан хаагчдын цалинг үнийн өсөлттэй уялдуулан үе шаттайгаар нэмэгдүүлж байна.

Шинээр өргөн мэдүүлж байгаа төсвийн тухай хуулийн төсөлд урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг бууруулж байгаа нь салбаруудын хөдөлмөрийн эрэлт, ажил эрхлэлтэд нөлөөлөхөөр байна. Ирэх онд хувь хүний орлогын албан татварын орлого суурь түвшнээс буюу хүчингүй болсон 2025 оны төсөвт туссан орлогоос 21.0 тэрбум төгрөгөөр буурч, 2,897.3 тэрбум төгрөгт хүрэхээр байна.

Зураг 20. Хувь хүний орлогын албан татварын орлого (тэрбум төгрөг)



Хувьцааны ногдол ашиг

Төрийн болон орон нутгийн өмчит, төрийн болон төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдээс төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлого нь суурь түвшинтэй харьцуулахад өөрчлөгдөөгүй болно. Ирэх онд дээрх аж ахуйн нэгжүүдээс нийт 737.9 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлогыг төсөвт төвлөрүүлэх бөгөөд үүнээс 507.1 тэрбум төгрөгийг Хуримтлалын санд, 130.8 тэрбум төгрөгийг орон нутгийн төсөвт, 100.0 тэрбум төгрөгийг улсын төсөвт тус тус төвлөрүүлэхээр байна.

Татварын зарлага

Татварын хууль тогтоомжийн дагуу татвар төлөгчдөд эдлүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлт нь суурь түвшинтэй харьцуулахад өөрчлөгдөөгүй болно. Энэ онд 1,164.9 тэрбум төгрөгт хүрч, нийт орлогын 3.8 хувьтай тэнцэхээр байна. Харин татварын хууль тогтоомжийн дагуу татвар төлөгчдөд эдлүүлэх татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээ 2025 онд 1,445.1 тэрбум төгрөгт буюу нийт орлогын 4.0 хувь, 2026 онд 1,622.1 тэрбум төгрөг буюу нийт орлогын 4.2 хувьд тус тус хүрэхээр байна. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн хэмжээг хүснэгтлэн харуулбал:

Хүснэгт 8. Татварын зарлагын хэмжээ (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2022	2023	2024 ХБГ	2025 Төс.	2026 Төс.
Нийт орлогод эзлэх хувь	6.5	4.3	3.8	4.0	4.2
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	1,197.7	1,051.2	1,164.9	1,445.1	1,622.1
ААНОАТ	443.3	424.6	450.8	600.8	668.3
НӨАТ	303.5	383.2	410.1	440.2	475.4
Гаалийн татвар	63.5	38.6	85.0	167.5	222.8
ХХОАТ	202.2	204.8	219.1	236.6	255.6

2.2.3. Төсвийн урсгал зардал

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 11 дүгээр сарын 29-ний чуулганы нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль болон түүнтэй хамт баталсан хууль тогтоомжийг хүчингүй болгосон. Хууль, тогтоолыг хүчингүй болгосонтой холбогдуулан “Хууль тогтоомжийг хүчингүй болгосонтой холбогдуулан авах арга

хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолыг баталж, Монгол Улсын 2025 оны төсвийн төслийг 2024 оны 12 дугаар сарын 10-ны дотор Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхийг Засгийн газарт даалгасан. Үүний дагуу хүчингүй болсон 2025 оны төсөвтэй харьцуулахад нэгдсэн төсвийн тэнцлийг алдагдалгүй байхаар тооцож, урсгал зардалд дараах зарчим баримтлан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийг боловсрууллаа.

Нэг. Төрийн албан хаагчдын цалинг 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн 6 хувь нэмэгдүүлнэ

Төрийн албан хаагчдын цалин хөлсийг Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувь нэмэгдүүлэхээр тооцож, шаардагдах зардлыг тусгасан ба Улсын Их Хурлаас тус хуулийг хүчингүй болгож шинээр өргөн мэдүүлэхээр Засгийн газарт үүрэг болгосон. Шинээр өргөн мэдүүлж байгаа Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд төрийн албан хаагчдын цалин хөлсийг 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 6 хувь нэмэгдүүлэх арга хэмжээг хөндөхгүйгээр хэвээр үлдээхээр тооцов.

Хоёр. Хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор зарим салбар, арга хэмжээний зардлыг бууруулахгүй

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлд дараах зардлыг бууруулахгүйгээр тооцов. Үүнд:

1/ Нийгмийн даатгалын сангийн төсөв, Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв, хүүхдийн мөнгөн тэтгэмж, халамжийн тэтгэвэр, амьжиргааг дэмжих мөнгөн тэтгэмж, асаргааны тэтгэмж, зээлийн үйлчилгээний төлбөр, төрийн албан хаагчийн цалин хөлс болон тэтгэвэрт гарахад нэг удаа олгох тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж;

2/ Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 48 дугаар зүйлийн 46.8.2-т “Улсын Их Хурлын Хууль зүйн байнгын хороогоор хянагдсан төсвийн төслийн эцсийн хувилбарыг улсын төсөвт нэгтгүүлэхээр” гэж, 46.8.3-т “Засгийн газар шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж, Монгол Улсын Хүний эрхийн үндэсний комиссын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д “Хууль зүйн байнгын хороогоор зөвшөөрөгдсөн төсвийн төслийг нэгтгүүлэхээр хүргүүлнэ” гэж тус тус заасны дагуу Улсын Их Хурлын Хууль зүйн Байнгын хорооноос төрийн тусгай байгууллагуудын зардлыг хянаж өөрчлөлтгүйгээр жилийн төсвийн төсөлд тусгуулахаар Сангийн яаманд хүргүүлсэн зардлууд.

Гурав. Зарим урсгал зардлыг 50-100 хувь бууруулна

Төсөвт байгууллагын үйл ажиллагааны зарим зардлыг хэсэгчлэн болон бүрэн бууруулна. Үүнд:

1/ Төсөвт байгууллагуудын тавилга, эд хогшил худалдан авах, сургалт, семинар, хурал зөвлөгөөн хийх, биеийн тамирын уралдаан тэмцээн зохион байгуулах, гэрээт ажилтан ажиллуулах, дуудлагын автомашин хөлслөх, зөвлөл, хороо, комиссын гишүүний ажлын хөлс, урамшуулал олгох зардлыг 100 хувь бууруулах;

2/Соёлын эрхийн бичиг, соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих, кино урлагийг дэмжих сан, засаг захиргааны нэгж, төрийн захиргааны байгууллагыг үр дүнгээр шагнах, урамшуулах, эрүүл мэндийн сургалт сурталчилгаа хийх зардлыг 100 хувь бууруулах.

3/ эрүүл мэнд болон тусгай чиг үүргийн байгууллагаас бусад бүх байгууллагын тээвэр шатахууны зардал, төрийн өндөр дээд түвшний айлчлал, өндөр түвшний зочин төлөөлөгч хүлээн авах зардлаас бусад гадаад албан томилолт болон зочин төлөөлөгч хүлээн авах зардал, эрүүл мэнд, боловсрол, батлан хамгаалах, хууль зүй, дотоод хэргийн салбараас бусад салбарын дадлага, бэлтгэл сургуулилт хийх зардал, бүх шатны төсвийн байгууллагын дотоод албан томилолт, бичиг хэргийн зардал, багаж техник хэрэгсэл худалдан авах зардлыг тус тус 50 хувиар бууруулах.

Дөрөв. Бусад урсгал зардлыг 10 хувиар бууруулна

Дээр дурдсан 50-100 хувь бууруулах зардлуудаас гадна байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материал, шуудан холбоо, эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал засвар, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, боловсролын тэтгэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн засвар ашиглалт, нийгмийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний зардлыг 10 хувиар бууруулна.

Тав. Зардал бууруулах бодлогын арга хэмжээг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зарим хуульд холбогдох өөрчлөлтийг тусгана

Төсвийн урсгал зардал бууруулах арга хэмжээг хэрэгжүүлэх зорилгоор Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл хүчингүй болсонд тооцох тухай, Зөрчлийн тухай хуулийн зарим заалт хүчингүй болсонд тооцох тухай, Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай, Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн зарим зүйл, заалт хүчингүй болсонд тооцох тухай, Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд болон “Монгол Улсын 2025 оны төсөв батлагдсантай холбогдуулах авах зарим арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсрууллаа.

Зургаа. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж

Төр зарим төрлийн чиг үүргээ өөрөө гүйцэтгэхгүйгээр гуравдагч этгээдээр гүйцэтгүүлэх замаар иргэдэд төрийн үйлчилгээг хүргэх, төрийн хэвийн үйл ажиллагааг хангах зардлыг тус эдийн засгийн ангилалд төлөвлөдөг болно. Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг 1,765.3 тэрбум төгрөгөөр тусгалаа. Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиас 10 хувиар бууруулан тооцлоо.

Хүснэгт 9. Бусдаар гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний төлбөр хураамжийн зардлын задаргаа /тэрбум ₮/

	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардал	2025 Суурь*	2025 Төс.	Зөрүү	БГАҮТХ эзлэх хувь	ТЕЗ
1	Гадаад зээл, тусламжаар хэрэгжүүлэх ажил үйлчилгээ	270.7	270.5	(0.2)	15.3	СС
2	Аймаг, нийслэлийн хот тохижилт, үйлчилгээний зардал	225.8	218.4	(7.4)	12.4	ОН
3	Ойжуулалт, Байгаль орчин, амьтан, ургамал хамгаалах үйл ажиллагааны зардал	218.9	203.9	(15.0)	11.6	БОУАӨС
4	Төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх	42.2	189.1	147.0	10.7	Бүх ТЕЗ
5	ЭЕШ зохион байгуулах, сурах бичиг, МСҮТ-ын хувьсах зардал	165.7	160.3	(5.4)	9.1	БС
6	Хүүхэд хамгаалал, хүүхдийн нийгмийн ажилтан, хүүхэд харах үйлчилгээ	67.0	68.2	1.2	3.9	ГБХНХС
7	Байр ашиглалтын цэвэрлэгээ, засвар үйлчилгээ	69.9	63.0	(6.9)	3.6	Бүх ТЕЗ
8	Мал, амьтныг халдварт өвчнөөс сэргийлэх, вакцинжуулах зардал	51.7	46.6	(5.1)	2.6	ХХААХҮС
9	Батлан хамгаалах зэвсэгт хүчин, аюулгүй байдлыг хамгаалах зардал	6.3	45.8	39.5	2.6	БХС
10	Аймгийн авто замын сангийн зардал	49.1	45.2	(3.9)	2.6	ОН
11	Хүнсний хангамж, аюулгүй байдлын арга хэмжээний зардал	0.0	40.0	40.0	2.3	ХХААХҮС
12	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зардал	32.0	30.8	(1.2)	1.7	ОН
13	Мэдээлэл, сурталчилгааны зардал	17.8	25.3	7.5	1.4	Бүх ТЕЗ
14	Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	17.4	16.4	(1.0)	0.9	ГХС, УЕП
15	Улс орноо гадаадад сурталчлах зардал	15.5	14.9	(0.6)	0.8	ССАЖЗС
16	Олон Улсын тэмцээн уралдаанд оролцох зардал, Үндэсний шигшээ багийн үйл ажиллагааны зардал	16.1	14.5	(1.6)	0.8	ССАЖЗС
17	Холбооны суваг ашигласны хөлс	15.3	13.8	(1.5)	0.8	Бүх ТЕЗ
18	Статистикийн тооллого, судалгааны зардал	14.5	13.1	(1.4)	0.7	ҮСХ
19	“Эрүүл шүд” хөтөлбөр, халдварт, халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх	17.0	10.9	(6.1)	0.6	ЭМС
20	Газрын хянан баталгааны зардал	11.2	10.0	(1.2)	0.6	ЕС
21	Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх	9.2	10.7	1.6	0.6	МУЕТГ, ЗГХЭГ
22	Алслагдсан орон нутагт хүргэх шуудан, харилцаа холбооны үйлчилгээ	8.0	8.0	-	0.5	ЦХИХХС
23	Гамшиг ослын үр дагаврыг арилгах зардал	8.8	7.9	(0.9)	0.4	ШС
24	Төрийн албан хаагчдыг мэргэшүүлэх	6.8	6.1	(0.7)	0.3	ЗГХЭГ
25	Шинэ технологи нэвтрүүлэх, хөгжүүлэх зардал	6.5	5.8	(0.7)	0.3	ЦХИХХС
26	Иргэний үнэмлэх хэвлэж тараах	5.0	4.5	(0.5)	0.3	ХЗДХС

27	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаа	4.6	4.2	(0.4)	0.2	СС, СЗХ, ХЗДХС
28	Гадаад, дотоодод соёл урлагийн арга хэмжээ зохион байгуулах, соёл урлагийг хөгжүүлэх зардал	12.4	3.9	(8.5)	0.2	ССАЖЗС
29	Бусад зориулалт арга хэмжээ	469.0	213.5	(255.5)	12.1	Бүх ТЕЗ
НИЙТ		1,854.5	1,765.3	(89.0)	100.0%	

*Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан дүн

Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамжийн зардлыг зориулалтаар нь задалж харвал аймаг, нийслэлийн хот тохижилт, үйлчилгээ, ойжуулалт, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, мал, амьтныг халдварт өвчнөөс сэргийлэх, вакцинжуулах, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээний зардал багтдаг.

Улсын хэмжээнд хот тохижилт, зам талбай, ногоон байгууламжийн арчлалт, үйлчилгээний 4.3 мянган ажилтан, авто замын засвар үйлчилгээг хариуцдаг төрийн өмчийн болон хувийн хэвшлийн 30 АЗЗА компанид нийт 1.0 мянга орчим ажилтан, малын вакцинжуулалтын үйлчилгээг улсын хэмжээнд үзүүлдэг 3.0 мянга гаруй малын эмч, байгаль хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаа, ойжуулалт, ойн хортон шавж устгалын үйл ажиллагааг хариуцан ажилладаг 1.1 мянга гаруй ажилтан, хүүхэд, гэр бүлийн нийгмийн ажилтан 927, нийт 9.3 мянган ажилтан гэрээний үндсэн дээр дээрх арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Төрийн зарим чиг үүргийг гэрээний үндсэн дээр гуравдагч этгээдээр гүйцэтгүүлснээр төрийн албан хаагч зайлшгүй ажиллахаас бусад төрийн үйлчилгээний салбарын орон тооны тэлэлтийг хязгаарлаж, төрийн албан хаагчдад хуулийн дагуу олгох зарим төрлийн тэтгэмжийн зардлыг хэмнэх ач холбогдолтой.

Долоо. Бараа үйлчилгээний бусад зардал

Монгол Улсын 2025 оны төсвийн төсөлд Бараа үйлчилгээний бусад зардал эдийн засгийн ангилалд 810.7 тэрбум төгрөгийг төсөвлөлөө. Бараа үйлчилгээний бусад зардлыг Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулиас 10 хувиар бууруулан тооцлоо. Зардлыг зориулалт, арга хэмжээгээр нь задалбал:

Хүснэгт 10. Бараа үйлчилгээний бусад зардлын задаргаа /тэрбум ₮/

Бараа үйлчилгээний бусад зардал	2025 Суурь*	2025 Төс.	Зөрүү	БҮБЗ эзлэх хувь	ТЕЗ
1 Сургууль, цэцэрлэгийн цалингаас бусад зардал	190.6	178.6	(12.0)	22.0	БС
2 Засгийн газрын нөөц хөрөнгө “Элэг бүтэн”, Эрүүл Монгол хүн”	130.	117.0	(13.0)	14.4	СС
3 хөтөлбөр, халдварт болон халдварт бус өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, тандалт	73.3	65.8	(7.5)	8.1	ЭМС
4 Орон нутгийн нөөц хөрөнгө	43.7	42.1	(1.6)	5.2	ОН
5 Цахим шилжилт арга хэмжээний зардал	29.8	26.9	(2.9)	3.3	ЦХИХХС
6 Иргэний үнэмлэх хэвлэж тараах	25.5	22.9	(2.6)	2.8	ХЗДХС

7	Төрийн байгууллага, ажилтны буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлын нөхөн төлбөр	17.2	21.2	4.0	2.6	ХЗДХС
8	Мөрийн хөтөлбөрт тусгагдсан зарим арга хэмжээг хэрэгжүүлэх	14.7	13.3	(1.4)	1.6	МУЕТГ, ЗГХЭГД
9	Улсын их баяр наадам	12.9	12.1	(0.8)	1.5	ОН
10	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, агаарын бохирдлыг бууруулах зардал	12.0	11.6	(0.4)	1.4	ОН
11	Соёлын төв, театр, чуулгад номын сан, музейд олгох гүйцэтгэлийн санхүүжилт	31.6	11.2	(20.4)	1.4	ССАЖЗС
12	Аймгийн авто замын сангийн зардал	12.0	10.8	(1.2)	1.3	ОН
13	Хүнсний хангамж, аюулгүй байдал, хяналтын судалгаа	0.1	6.4	6.3	0.8	ХХААХ ҮС
14	Олимп, параолимпын наапмын үйл ажиллагааг дэмжих болон допингийн эсрэг үйл ажиллагааг дэмжих зардал	10.3	6.1	(4.2)	0.8	ССАЖЗС
15	Эм, эмнэлгийн хэрэгслийн болон өвс тэжээлийн нөөц	4.9	4.4	(0.4)	0.5	ЭМС
16	Нийтийн эзэмшлийн гудамж талбайн гэрэлтүүлэг	3.4	3.4	0	0.4	ОН
17	Нөхөн болон дахин сонгууль	3.3	3.0	(0.3)	0.4	СЕХД
18	Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрийн зардал	3.0	2.7	(0.3)	0.3	ГБХНХС
19	Төрийн шагнал, одон, медаль	2.9	2.6	(0.3)	0.3	МУЕТГ
20	Олон улсын хурал, зөвлөгөөн зохион байгуулах	2.7	2.4	(0.3)	0.3	ЭЗХС, УЕП
21	Бусад зориулалт арга хэмжээ	288.7	246.2	(42.5)	30.4	Бүх ТЕЗ
НИЙТ		912.6	810.7	(101.9)	100.0	

*Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан дүн

Бараа үйлчилгээний бусад зардалд боловсрол, соёлын салбарын гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийн байгууллагуудын цалингаас бусад зардал, засгийн газрын нөөц хөрөнгө, цахим систем, лицензийн төлбөр, төрийн шагнал, одон медаль, эм, эмнэлгийн хэрэгсэл, иргэний үнэмлэх хэвлэх, өвс тэжээлийн нөөц зэрэг төрийн худалдан авалт, үйлчилгээний зардлыг тусгадаг.

2.2.4. Засгийн газрын тусгай сан

Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6.1-т тусгай сангийн төсөв нь улсын төсвийн хөрөнгө, хандив, тусламж, тусгай сангийн үйл ажиллагааны орлого, зээлийн хүүгийн орлогын эх үүсвэрээс бүрдэхээр заасан. Энэ хүрээнд 2025 онд Засгийн газрын тусгай сангуудаар дамжин нийт 11,582.6 тэрбум төгрөгийн зардал санхүүжүүлэх бол үүний 92.4 хувь буюу 10,706.2 тэрбум төгрөг нь Нийгмийн даатгал, Нийгмийн халамж, Эрүүл мэндийн даатгалын сангуудын зарлага, 7.6 хувь буюу 876.4 тэрбум төгрөг нь бусад тусгай сангийн зардалд хамаарч байна.

Хүснэгт 11. Засгийн газрын тусгай сангийн зардлын төсөл /тэрбум ₮/

ЗГ-ын тусгай сан		2025 Суурь*	2025 Төс.	Зөрүү
1	Нийгмийн даатгалын сан	5,882.8	5,882.8	-
2	Нийгмийн халамжийн сан	2,560.9	2,529.5	-31.4
3	Эрүүл мэндийн даатгалын сан	2,293.9	2,293.9	-
4	Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сан	224.3	213.3	-11.0
5	Боловсролын зээлийн сан	175.9	158.4	-17.5

6	Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан	145.9	130.8	-15.1
7	Улсын авто замын сан	131.0	120.9	-10.1
8	Засгийн газрын нөөц сан	130	117.0	-13.0
9	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	49.8	44.8	-5.0
10	Зэвсэгт хүчний хөгжлийн сан	40.0	40.0	-
11	Үндэсний шинжлэх ухаан, технологийн сан	13.9	12.6	-1.3
12	Эрүүл мэндийг дэмжих сан	10.8	9.7	-1.1
13	Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сан	8.3	8.3	-
14	Хүүхдийн төлөө сан	8.3	8.3	-
15	Архидан согтуурахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг дэмжих сан	7.9	7.9	-
16	Өргөн нэвтрүүлэг хөгжүүлэх сан	2.0	1.8	-0.2
17	Спортыг дэмжих сан	1.2	0.7	-0.5
18	Байгаль орчин, уур амьсгалын сан	0.8	0.7	-0.1
19	Гэмт хэргийн хохирогчид нөхөн төлбөр олгох сан	0.6	0.6	-
20	Хилийн чанадад байгаа Монгол улсын иргэдэд туслах сан	0.6	0.6	-
21	Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих сан	0.8	-	-0.8
22	Кино урлагийг дэмжих сан	0.1	-	-0.1
НИЙТ		11,689.8	11,582.6	(107.2)

*Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан дүн

Боловсролын зээлийн сан

Боловсролын зээлийн сангийн 2025 оны нийт зарлагыг 158.4 тэрбум төгрөгөөр төлөвлөлөө. Боловсролын ерөнхий хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.1 дэх заалтад гадаадын болон дотоодын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид Засгийн газраас тогтоосон шалгуур, шаардлагыг хангасан тохиолдолд суралцагчийн тэтгэлэг олгох, тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцагчид сургалтын төлбөрийн хөнгөлөлт, тэтгэлэг, зээл олгох, эргэн төлүүлэх, дэмжлэг үзүүлэх журмыг Засгийн газар батлахаар заасан.

Энэ дагуу батлагдсан Засгийн газрын 2024 оны 102 дугаар тогтоолд туссан Монгол Улсын Ерөнхийлөгчийн тэтгэлэг, Монгол Улсын Засгийн газрын тэтгэлэг, Засгийн газар хоорондын гэрээгээр суралцагчид олгох тэтгэлэг, хөгжлийн бэрхшээлтэй суралцагчид олгох буцалтгүй тусламж, зарим эрэлттэй мэргэжлээр суралцагчид олгох тэтгэлэг, зорилтод бүлгийн суралцагчид олгох буцалтгүй тусламж, орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа төрийн өмчийн сургалтын байгууллагад суралцагчид олгох сургалтын төлбөрийн хөнгөлөлт, дотоод, гадаадад суралцагчдад олгох зээлтэй холбоотой зардлуудыг тус тус тусгалаа. Мөн Засгийн газрын 2024 оны 103 дугаар тогтоолд туссан багш мэргэжлээр суралцагч болон багш, ажилтны хүүхдийг тэргүүлэх, эрэлттэй мэргэжлээр суралцахад төрөөс үзүүлэх дэмжлэгтэй холбоотой зардлыг тус сангийн 2025 оны төсвийн төсөлд тусгалаа.

Нийгмийн халамжийн сан

Нийгмийн халамжийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасны дагуу нийгмийн халамжийн сангаас олгох дараах арга хэмжээнд нийт 2,529.5 тэрбум төгрөг зарцуулахаар тооцож төсөвт тусгалаа.

Хүүхдийн мөнгөн тэтгэмж

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13.1.6-д хүүхдийн мөнгөн тэтгэмжийг нийгмийн халамжийн сангаас олгохоор заасан байдаг. Ирэх онд 0-18 хүртэлх насны нийт 1,338.0 мянган хүүхдэд хүүхдийн мөнгөн тэтгэмж олгоход 1,580.2 тэрбум төгрөг төсөвлөлөө.

Халамжийн тэтгэвэр

Нийгмийн халамжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт заасан 65 насанд хүрсэн иргэн, 16 насанд хүрсэн одой иргэн, хөдөлмөрийн чадвараа 50 ба түүнээс дээш хувиар алдсан 16 насанд хүрсэн хөгжлийн бэрхшээлтэй иргэн, тэжээгч нь нас барсан 18 хүртэлх насны хүүхэд, 18 хүртэлх насны дөрөв ба түүнээс дээш хүүхэдтэй, өрх толгойлсон 45 насанд хүрсэн эх, 50 насанд хүрсэн эцэг нийт 65.7 мянган иргэн нийгмийн халамжийн сангаас тэтгэвэр авч байна. Ирэх онд нийгмийн халамжийн тухай хуулийн дагуу халамжийн тэтгэвэр авагч иргэдийн тэтгэвэрт нийт 296.3 тэрбум төгрөгийн төсөв тусгалаа.

Асаргааны тэтгэмж

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт бүтэн өнчин хүүхдийг үрчлэн авсан болон эрсдэлт нөхцөлд байгаа хүүхдийг асран хамгаалж, харгалзан дэмжиж байгаа, хүүхдийг асарч байгаа асралт гэр бүл, тэжээн тэтгэх хүүхэдгүй, ганц бие ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй ганц бие иргэнийг гэр бүлдээ авч асрамжилж байгаа, эмнэлгийн хяналтад байдаг, байнгын асаргаа шаардлагатай ахмад настан болон хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд ба иргэнийг асарч байгаа иргэдэд тус тус асаргааны тэтгэмж олгохоор заасан байдаг. Асаргааны тэтгэмж авдаг нийт 75.4 мянган иргэнд 271.6 тэрбум төгрөг олгохоор тооцож, төсөвт тусгалаа.

Онцгой тохиолдлын болон амьжиргаа дэмжих мөнгөн тэтгэмж

Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэгт заасан байнгын асаргаа шаардлагатай 16 хүртэлх насны хүүхдэд, байнгын асаргаа шаардлагатай 16 ба түүнээс дээш насны иргэн нийт 67.6 мянган иргэнд 98.1 тэрбум төгрөг олгохоор тооцсон.

Цалинтай ээж

Эх, эцэг, олон хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцэгт тэтгэмж олгох тухай хуулийн 5.1 дэх хэсэгт заасан жирэмсэн эхийн тэтгэмж, 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж, ихэр хүүхдийн тэтгэмж, гурав болон түүнээс дээш хүүхэдтэй өрх толгойлсон эх, эцгийн тэтгэмжийг 268.3 мянган иргэнд олгохоор тооцож 113.1 тэрбум төгрөг тусгасан.

Эхийн алдар одонтой ээжид олгох мөнгөн тусламж

Олон хүүхэд төрүүлж өсгөсөн эхийг урамшуулах тухай хуулийн 4 дүгээр зүйл, Нийгмийн халамжийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.5.9 дэх хэсэгт заасны дагуу “Эхийн алдар” нэгдүгээр зэргийн одон, “Эхийн алдал” хоёрдугаар зэргийн одонтой 264.0 мянган эхэд 59.1 тэрбум төгрөг олгохоор төсөвт тусгалаа.

Насны хишиг

Ахмад настны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.5 дахь заалтад 65 болон түүнээс дээш настай ахмад настанд “насны хишиг” тэтгэмж олгохоор заасны дагуу 194.1 мянган ахмад настанд нийт 26.6 тэрбум төгрөг олгохоор тооцлоо.

Хүнс тэжээлийн дэмжлэг

Нийгмийн халамжийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1 дэх хэсэгт заасан энэ хуулийн 3.1.2-г заасан өрхийн гишүүн-иргэдийн дотроос нийгмийн халамжийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын тодорхойлсон хүнсний хангамж зайлшгүй шаардлагатай өрхийн гишүүн-иргэн, гэр оронгүй, тэнэмэл амьдралтай иргэн нийт 100.6 мянган иргэнд нийт 19.0 тэрбум төгрөг олгохоор төсөвт тусгалаа

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сан

Мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтын тухай хуулийн 29 дүгээр зүйлд мэргэжлийн болон техникийн боловсрол, сургалтыг дэмжих сангийн хөрөнгийг зарцуулах харилцааг зохицуулсны дагуу холбогдох зардлыг тус сангийн 2025 оны төсвийн төсөлд тусгалаа.

Ингэхдээ “Хувьсах зардлын дундаж норматив, итгэлцүүр, журам батлах тухай” Засгийн газрын 2023 оны 466 дугаар тогтоолын дагуу төрийн болон төрийн бус өмчийн мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагуудын төсвийг төлөвлөж, чанар, үр дүнд үндэслэсэн гүйцэтгэлд суурилсан зарчмаар санхүүжүүлэхээр холбогдох зардлыг тусгалаа.

Нийгмийн даатгалын сан

Нийгмийн даатгалын сангийн орлого: Нийгмийн даатгалын сангийн 2025 оны төсвийн шимтгэлийн орлогыг 5,476.2 тэрбум төгрөг байхаар тооцлоо. Улсын төсвөөс тэтгэврийн даатгалын сангийн 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэр, цэргийн албан хаагчдын тэтгэвэр, Зарим иргэний тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлэх тухай хуульд заасан нэмэгдэл болон бусад зориулалтаар нийт 1,452.5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгохоор тооцлоо.

Нийгмийн даатгалын сангийн зарлага: Нийгмийн даатгалын сангийн нийт зарлагыг 2024 оны төсвөөс 694.4 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлж 5,882.8 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн. Ирэх онд тэтгэврийг инфляцын түвшинтэй уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлэх болон тэтгэвэр авагчдын тооны өсөлт, энэ оны 4 дүгээр сараас тэтгэвэр нэмсэн арга хэмжээний оны эхний 3 сарын нөлөөлөлтэй холбоотой зардлыг тус тус тооцож тусгасан.

Нийгмийн даатгалын сангийн Капитал банкнаас авах 67.2 тэрбум төгрөгийн авлагыг тусгав.

Эрүүл мэндийн даатгалын сан


Эрүүл мэндийн даатгалын сангийн орлого: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн нийт орлогыг 2,515.6 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн. Үүний 1,319.4 тэрбум төгрөгийг төр хариуцах эмнэлгийн тусламж, үйлчилгээ, төрөөс эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг нь хариуцан төлөх даатгуулагчдын шимтгэлийн орлого, 1,196.2 тэрбум төгрөг нь ажил олгогч, даатгуулагчийн болон бусад даатгуулагчийн төлөх шимтгэлийн орлогоос тус тус бүрдэхээр байна.

Эрүүл мэндийн даатгалын сангийн зарлага: Эрүүл мэндийн даатгалын сангийн 2025 оны төсвийн нийт зарлагыг 2,293.9 тэрбум төгрөг байхаар төлөвлөсөн. Үүнээс

эрүүл мэндийн байгууллагад олгох тусламж, үйлчилгээний санхүүжилтийг 2,050.8 тэрбум төгрөг, эрсдэлийн санг 53.6 тэрбум төгрөг, төр хариуцах эмийн зардлын хяналт, хүртээмжийг сайжруулах зорилгоор эмийн үнийн хөнгөлөлтөд олгох санхүүжилтийг 171.5 тэрбум төгрөг, үйл ажиллагааны зардлыг 18.0 тэрбум төгрөг байхаар тус тус тооцлоо.

ШИГТГЭЭ: ТӨСВИЙН УРСГАЛ ЗАРДЛУУДЫН ДИНАМИК ХАНДЛАГА

Урсгал зардал болон түүний бүрэлдэхүүн хэсгүүдийн ДНБ-д эзлэх %



Сүүлийн 12 жилийн төсвийн урсгал зардлын ДНБ-д эзлэх дундаж хувь 25.7 байна.

Урсгал зардлын дийлэнх хувийг төрийн албан хаагчдын цалин, тэтгэвэр, тэтгэмж, хүүхдийн мөнгөн тэтгэмж болон зээлийн хүүгийн төлбөр зэрэг хуулиар зохицуулагддаг, өсөн нэмэгдэх зардлууд эзэлдэг.

Тухайлбал, 2025 онд урсгал зардлын ДНБ-д эзлэх хувь 27.4 хувь байх төлөвтэй


байгаагаас цалин, тэтгэвэр зэрэг голлох зардлууд 17.2 хувийг эзэлж байна.

Урсгал зардлын бусад 10.2 хувийг томилолт, зочны зардал, эд хогшил, урсгал засварын зардал, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал болон бараа үйлчилгээний бусад зардлууд гэх зэрэг төрийн үйл ажиллагааг тасралтгүй явуулахад шаардлагатай зардлууд эзэлдэг. Мөн тухайн зардлууд нь эдийн засаг саарах үед буурч, эдийн засаг эрчимжих үед нэмэгдэх хандлагатай байна.

Түүнчлэн, эдгээр зардлуудын нэрлэсэн болон үнийн нөлөөг засварласан бодит дүнг харьцуулан харуулав.



³ ДНБ-ий дефлятор (2015 он суурьтай)-аар засварласан.



2.2.5. Улсын төсвийн хөрөнгө оруулалт болон гадаад зээл, тусламжийн санхүүжилт:

Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн бодлого болон “Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийн зорилго, зорилт, арга хэмжээг хэрэгжүүлэх, 2025 онд төсвийн хөрөнгө оруулалтыг бүсүүдийн авто зам, эрчим хүч, дэд бүтцийг бүрдүүлэх зорилгоор хөгжлийн бүтээн байгуулалтуудыг санхүүжүүлэхэд хөрөнгө оруулалтыг чиглүүлж, мөн бусад салбарт өмнөх онуудад эхлүүлсэн төслүүдийг дуусгаж, шинэ хөрөнгө оруулалтыг түр хойшлуулах үндсэн зарчим, бодлогыг баримталж, энэ хүрээнд 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдөр УИХ-д өргөн мэдүүлсэн төсвийн төсөлд тусгасан төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг дахин эрэмбэлж, дэд бүтэц, бүтээн байгуулалтын төслүүдийг үе шаттайгаар хэрэгжүүлэх, санхүүжүүлэх зарчим баримталлаа.

Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн хувьд дараах эрэмбийг баримталсан бөгөөд дээрх өөрчлөлтөөр эрэмбийг хэвээр хадгалсан болно. Үүнд:

- i. Бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилттой нийцсэн байх;
- ii. Тухайн бүс нутгийн хөгжилд дорвитой нөлөө үзүүлэх буюу эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдолтой байх;
- iii. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр төлөвлөж, ач холбогдлын оноо өгч, эрэмбэлсэн байх;
- iv. Зураг төсөвтэй байх гэсэн үндсэн 4 шалгуур үзүүлэлтээр төслүүдийг төлөвлөсөн болно.

Мөн дээрх шалгуур үзүүлэлтээс гадна дараах өөрчлөлтийг оруулж, төсвийн төсөлд тусгах төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг шинэчлэн боловсруулав. Үүнд:

1. Гэрээ байгуулсан, ажлыг эхлүүлсэн төслүүдийг дуусгах зарчим баримталж, 2025 онд санхүүжих дүнг бууруулаагүй буюу 512 төсөл, арга хэмжээний 2,080.0 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тусгасан.
2. Харин улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд шинээр эхлүүлэн, ирэх онд үргэлжлэн хэрэгжүүлэхээр батлагдсан боловч 2024 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн байдлаар гэрээ байгуулаагүй 32 төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих 117.8 тэрбум төгрөгийг хойшлуулсан.
3. Бүсчилсэн хөгжлийн бодлогын хүрээнд зам тээвэр, эрчим хүч, дэд бүтцийн томоохон 38 төслийг шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөснийг дахин эрэмбэлж бүс нутагт нэн тэргүүний шаардлагатай, богино хугацаанд хэрэгжих боломжтой, дараа онуудад төсөвт учруулах ачаалал үүсгэхгүй байх төслүүдийг 2025 онд хэрэгжүүлэхээр 29 төсөл, арга хэмжээ болгон бууруулж 497.0 тэрбум төгрөгийг тусгасан.
4. Зарим их засвар, ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах 8 төсөл, арга хэмжээний 2025 онд санхүүжих дүнг 62.1 тэрбум төгрөгөөр бууруулсан.
5. Төрийн байгууллагуудын үйл ажиллагааг тасралтгүй, хэвийн үргэлжлүүлэх, иргэдэд үйлчлэх төрийн үйлчилгээг сайжруулахад шаардлагатай тоног төхөөрөмж болон шинээр ашиглалтад орж буй сургууль, цэцэрлэг, эмнэлэг зэрэг нийгмийн салбарын барилгуудын тоног төхөөрөмжийн зардлыг 2025 оны төсвийн төсөлд анх төлөвлөж өргөн барьснаас 20 хувь бууруулсан.
6. Шүүхийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.8.3-т “Засгийн газар Улсын дээд шүүхийн болон бусад шүүхийн төсвийн төслийг бууруулахгүйгээр улсын

төсвийн төсөлд тусгаж, холбогдох дүгнэлтийн хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх” гэж заасны дагуу шүүхийн бие даасан байдлыг хангах, үйл ажиллагааг тогтвортой үргэлжлүүлэх зорилтын хүрээнд 5 төслийн 18.8 тэрбум төгрөгийг тусгасан.

7. Хавдар судлалын үндэсний төвийн одоогийн барилга нь 1981 онд ашиглалтад орсон бөгөөд 228 хэвтэн эмчлүүлэх ортой 11 нарийн мэргэжлийн тасаг, оношилгооны 12 тасаг, 21 амбулатори бүхий 15.0 мянган м² бүхий байгууламж бөгөөд сүүлийн жилүүдэд их засвар хийгдээгүй тул тус эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор их засвар шинэчлэлтэд төсөвт өртөг 5.7 тэрбум төгрөг, үүнээс 2.9 тэрбум төгрөгийг 2025 онд санхүүжүүлэхээр төсвийн төсөлд шинээр тусгалаа.

Дээрх зарчмын хүрээнд улсын төсвийн хөрөнгө оруулалтад 2025 онд нийт 618 төсөл, арга хэмжээнд 3,224.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг тусгахаар төлөвлөсөн бөгөөд 29.7 хувь буюу 959.2 тэрбум төгрөгийг зам тээврийн салбарт, 6.0 хувь буюу 193.2 тэрбум төгрөгийг эрчим хүчний салбарт, 11.0 хувь буюу 354.1 тэрбум төгрөгийг инженерийн дэд бүтцийн чиглэлээр, үлдсэн хөрөнгийг бусад салбарт хэрэгжүүлэхээр өөрчлөлт оруулж тусгалаа.

Хүснэгт 12. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, Төсвийн ерөнхийлөн захирагчаар

№	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ	Төслийн тоо	Төсөвт өртөг	Санхүүжих дүн	Хувь
1	Зам, тээврийн сайд	96	3,656,394.9	959,218.8	29.7%
2	Боловсролын сайд	189	1,324,640.4	472,677.6	14.7%
3	Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд	54	1,137,185.9	354,097.3	11.0%
4	Эрчим хүчний сайд	37	600,425.9	193,193.2	6.0%
5	Эрүүл мэндийн сайд	38	426,704.6	183,332.4	5.7%
6	Монгол Улсын Тэргүүн Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд	6	488,155.1	158,576.9	4.9%
7	Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын сайд	49	454,638.7	145,245.5	4.5%
8	Сангийн сайд	7	141,319.3	126,249.3	3.9%
9	Хууль зүй, дотоод хэргийн сайд	18	148,291.5	108,551.7	3.4%
10	Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайд	12	87,525.4	79,329.8	2.5%
11	Батлан хамгаалахын сайд	4	115,036.0	75,403.8	2.3%
12	Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга	7	144,145.4	62,984.5	2.0%
13	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд	17	143,655.4	58,580.5	1.8%
14	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд	24	140,367.1	52,242.3	1.6%
15	Монгол Улсын Шадар сайд	7	57,232.5	42,477.5	1.3%
16	Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд	7	49,596.0	35,745.0	1.1%
17	Улсын Ерөнхий Прокурор	5	73,150.5	29,849.1	0.9%
18	Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга	17	61,971.8	24,230.6	0.8%
19	Монгол Улсын сайд, 20 минутын хот Үндэсний хорооны дарга	3	48,171.5	15,671.5	0.5%
20	Гадаад харилцааны сайд	2	11,250.4	11,250.4	0.3%
21	Монгол Улсын Их Хурлын дарга	1	8,560.0	8,560.0	0.3%
22	Монгол Улсын сайд, Боомтын сэргэлтийн Үндэсний хорооны дарга	3	8,098.4	8,098.4	0.3%
23	Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч	3	6,545.2	4,628.2	0.1%
24	Хүний эрхийн Үндэсний Комиссын дарга	1	2,712.0	2,712.0	0.1%
25	Монгол Улсын сайд, Хяналт үнэлгээний Үндэсний хорооны дарга	1	2,408.1	2,408.1	0.1%
26	Авлигатай тэмцэх газрын дарга	2	2,360.9	2,360.9	0.1%
27	Үндэсний Статистикийн Хорооны дарга	1	2,000.0	2,000.0	0.1%

28	Монгол Улсын Ерөнхий Сайд	1	1,545.4	1,545.4	0.0%
29	Монгол Улсын Ерөнхий аудитор	1	1,178.8	1,178.8	0.0%
30	Монгол Улсын Ерөнхийлөгч	2	1,000.0	1,000.0	0.0%
31	Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд	1	984.0	984.0	0.0%
32	Шүүхийн сахилгын хорооны дарга	1	300.0	300.0	0.0%
33	Санхүүгийн зохицуулах хорооны дарга	1	250.0	250.0	0.0%
Нийт		618	9,347,801.2	3,224,933.5	100.0%

Түүнчлэн 2025 онд төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэхээр тусгасан төслүүдийн 57.1 хувь нь буюу 353 төсөл 2025 онд, 38.2 хувь нь буюу 237 төсөл 2026 онд, 4.5 хувь буюу 28 төсөл, арга хэмжээг 2027 онд хэрэгжүүлж дуусах бөгөөд нийт 86 сургууль, 59 цэцэрлэг, 29 эмнэлэг, авто зам, гүүрэн байгууламжийн 92 төсөл, цахилгаан, дулаан хангамжийг сайжруулах чиглэлээр 43 төсөл, инженерийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтад 39 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр байна.

Хүснэгт 13. Улсын төсвийн хөрөнгө оруулалт, зориулалтаар

АНГИЛАЛ	ТӨСЛИЙН ТОО	ТӨСӨВТ ӨРТӨГ	САНХҮҮЖИХ ДҮН
Зам, гүүр	92	3,640,955.7	952,016.4
Сургууль	86	823,914.3	270,669.2
Цэцэрлэг	59	225,879.3	86,915.5
Цахилгаан, дулаан хангамж	43	706,896.0	242,080.5
Инженерийн дэд бүтэц	39	888,288.5	251,424.5
Соёлын төв, музей, театр	31	308,384.1	89,526.3
Эмнэлэг	29	320,068.7	96,807.0
Спорт заал, цогцолбор, ордон	24	157,628.2	40,828.4
Дотуур байр	20	98,590.3	36,927.0
Нийгмийн хамгаалал	18	89,060.4	32,872.1

Гадаад зээл, тусламжийн ашиглалтын хувьд Үндэсний хиймэл дагуулын төсөл хэлэлцээрийн шатанд явагдаж байгаатай холбогдуулан 2025 оны төсөвт тусгагдсан байсан нийт 211.6 тэрбум төгрөгийн ашиглалтыг хассан. Мөн зарим зээлийн төслүүдийн санхүүжилтийг 454.9 тэрбум төгрөгөөр бууруулж, нийтдээ 666.6 тэрбум төгрөгийн зээлийн ашиглалтыг буурууллаа.

Ингэснээр гадаад зээл, тусламжийн Олон улсын гэрээ, хэлэлцээрийн дагуу хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээний 2025 оны зээлийн ашиглалтад нийт 89 төслийн 1,542.4 тэрбум төгрөг, тусламжийн 27 төслийн 417.0 тэрбум төгрөгийг төсвийн төсөлд тус тус тусгалаа.

Ирэх онд зээл, тусламжийн санхүүжилтийн 43.7 хувийг олон талт хамтын ажиллагааны хүрээнд, 56.3 хувийг хоёр талт хамтын ажиллагааны эх үүсвэрээс бүрдүүлнэ. Тухайлбал, Азийн хөгжлийн банкны санхүүжилт хамгийн өндөр буюу 27.2 хувийг эзэлж байгаа бол Бүгд Найрамдах Солонгос Улсын санхүүжилт 13.7 хувь, Бүгд Найрамдах Энэтхэг Улс болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын санхүүжилт 11 хувийг тус тус эзэлж байна.

Хүснэгт 14. Гадаад зээл, тусламжийн 2025 оны ашиглалт, тэрбум төгрөг

№	ХӨГЖЛИЙН ТҮНШ	2025 СУУРЬ*	2025 ТӨС.	ЗӨРҮҮ
1	Азийн хөгжлийн банк	605.0	532.6	72.4
2	Бүгд Найрамдах Солонгос Улс	337.7	267.7	70.0

3	Бүгд Найрамдах Хятад Ард Улс	255.3	225.3	30.0
4	Бүгд Найрамдах Энэтхэг Улс	460.4	220.4	240.0
5	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк	208.9	208.9	-
6	Америкийн Нэгдсэн Улс	202.4	202.4	-
7	Дэлхийн банк	126.0	101.0	25.0
8	Бүгд Найрамдах Франц Улс	271.8	60.2	211.6
9	Холбооны Бүгд Найрамдах Герман Улс	46.1	46.1	-
10	Австри Улс	30.9	30.9	-
11	Польш Улс	23.6	23.6	-
12	Япон Улс	23.1	23.1	-
13	Боловсролын Дэлхийн Түншлэл	8.2	8.2	-
14	Европын Хөрөнгө Оруулалтын Банк	23.2	5.7	17.5
15	Люксембург Улс	2.2	2.2	-
16	Кувейт Улс	1.0	1.0	-
17	Унгар Улс	0.0	0.0	-
18	Хөдөө Аж Ахуйн Хөгжлийн Олон Улсын Сан	0.0	0.0	-
НИЙТ		2,626.0	1,959.4	666.6

**Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан дүн*

Засгийн газрын 2025 оны гадаад зээл, тусламжийн ашиглалтыг бүтцийн хувьд авч үзвэл 1,473.3 тэрбум төгрөг буюу 75.2 хувийг хөрөнгө оруулалтын зардалд, 259.0 тэрбум төгрөг буюу 13.2 хувийг урсгал зардалд, 227.1 тэрбум төгрөг буюу 11.6 хувийг дамжуулан зээлдүүлэх зардлын санхүүжилтээр тус тус ашиглахаар төлөвлөсөн.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хэрэгжилт

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 12 дугаар сарын 09-ний өдөр Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийг баталж, 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс дагаж мөрдөж эхэлсэн.

Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль нь 9 бүлэг, 60 зүйлтэй бөгөөд Хууль тогтоомжийн тухай хуулийн 24 дүгээр зүйлд заасны дагуу анхдагч хуулийн төсөл хэлбэрээр боловсруулсан байдаг. Энэ хуулийн зорилт нь нийтийн зориулалттай дэд бүтэц, төрийн үйлчилгээний салбарт төр, хувийн хэвшлийн түншлэлийн төслийг хэрэгжүүлэх, хувийн хэвшлийн оролцоо, хөрөнгө оруулалтыг дэмжих, төр, хувийн хэвшил эрсдэлийн оновчтой удирдлагад суурилан түншлэлийн гэрээний дагуу урт хугацаанд үр ашигтай хамтран ажиллах болон санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбогдуулан эрх зүйн таатай орчныг бүрдүүлэхэд чиглэсэн.

Тус хууль хэрэгжиж эхлэхтэй холбогдуулан Засгийн газраас нийт 9 журмыг батлаад байна. Үүнээс гадна 2024 оны 05 дугаар сарын 05-ны өдөр оруулсан нэмэлт, өөрчлөлтөөр Нийслэл болон улсын төсвөөс сүүлийн 3 жил дараалан санхүүгийн дэмжлэг аваагүй, эсхүл 100 000, түүнээс дээш хүн амтай аймгуудыг хуульд заасан тодорхой

салбаруудад түншлэлийн төслийг бие даан хэрэгжүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлсэн. Одоо тус хуулийн нэмэлт, өөрчлөлттэй холбоотой Нийслэл, аймгуудад хэрэгжүүлэх түншлэлийн төслийг боловсруулах, үнэлэх, түншлэгчийг сонгон шалгаруулахтай холбоотой журмуудыг боловсруулан Засгийн газраар хэлэлцүүлэхээр бэлтгэж байна.

Түүнчлэн уг хуулийн хүрээнд хэрэгжүүлэх төр, хувийн хэвшлийн түншлэлээр гэрээ байгуулсан төсөл байхгүй бөгөөд одоогийн байдлаар төсөвт учруулах эрсдэл үүсээгүй байна.

2.2.6. Орон нутгийн төсөв

Хувь хүний орлогын албан татвар болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын орлого буурч байгаатай холбогдуулан орон нутгийн төсвийн нийт орлого хүчингүй болсон 2025 оны төсвийн тухай хуулиар баталсан орлогоос нийт 38.6 тэрбум төгрөгөөр буурч, 6,590.7 тэрбум төгрөгт хүрэхээр байна.

Орон нутгийн суурь зарлагыг хянахдаа төсөвт байгууллагын зарим үйл ажиллагааг нэг удаа хойшлуулахаар тооцож холбогдох зардлыг хэсэгчлэн болон бүрэн хаслаа. Үүнд тавилга, эд хогшил худалдан авах, шинэчлэх зардлыг 100 хувь, гадаад томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг 50 хувь, бичиг хэргийн зардал, дотоод албан томилолт, багаж, техник, хэрэгсэл худалдан авах зардал, тээвэр, шатахууны зардал, хичээл үйлдвэрлэлийн дадлагын зардлыг 50 хувь тус тус буурууллаа. Мөн дээрх хасалт хийсэн зардлуудаас гадна байр ашиглалттай холбоотой тогтмол зардал, хангамж, бараа материал, шуудан холбоо, эм бэлдмэл, нормын хувцас, хоол, урсгал болон их засвар, төрийн болон хувийн хэвшлийн байгууллагад олгох татаас, шилжүүлэг, эргэж төлөгдөх зээл, бараа үйлчилгээний бусад зардал, төрийн зарим чиг үүргийг хувийн хэвшлээр гүйцэтгүүлэх арга хэмжээ, авто зам, гүүрэн байгууламжийн засвар ашиглалт зэргийг нийтлэг байдлаар 10 хувиар буурууллаа.

Орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагыг төлөвлөж, аймгуудад олгох санхүүгийн дэмжлэг 2025 онд 445.3 тэрбум төгрөг, дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ 2025 онд 1.9 их наяд төгрөг байхаар тооцлоо.

Хүснэгт 15. Аймгуудын санхүүгийн дэмжлэг (сая төгрөг)

САНХҮҮГИЙН ДЭМЖЛЭГ	2025 Суурь*	2025 Төс.	Зөрүү
Архангай	52,186.4	46,462.2	-5,724.2
Баян-Өлгий	34,200.2	29,659.7	-4,540.5
Баянхонгор	41,955.9	37,765.3	-4,190.6
Булган	24,117.3	17,895.3	-6,222.1
Говь-Алтай	34,310.4	29,685.2	-4,625.2
Дундговь	24,007.4	19,308.7	-4,698.7
Завхан	53,371.4	47,684.4	-5,698.7
Өвөрхангай	42,994.9	36,362.0	-6,632.9
Сүхбаатар	28,334.3	22,417.2	-5,917.1
Төв	9,001.9	2,154.0	-6,847.9
Увс	42,073.9	39,573.0	-2,500.9
Ховд	19,295.9	14,041.6	-5,254.3
Хөвсгөл	60,435.3	52,173.4	-8,261.9
Хэнтий	47,348.3	40,849.4	-6,498.9

Говь-Сүмбэр	11,725.4	9,282.0	-2,443.5
Дорнод	2,424.5	0.0	-2,424.5
НИЙТ	527,783.5	445,313.4	-82,470.1

*Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан дүн

Хүснэгт 16. Дээд шатны төсөвт төвлөрүүлэх дүн (сая төгрөг)

ТӨВЛӨРҮҮЛЭХ	2025 Суурь*	2025 Төс.	Зөрүү
Дорноговь	10,478.0	11,755.7	1,277.7
Дорнод	0.0	448.0	448.0
Өмнөговь	1,754,708.7	1,769,143.3	14,434.5
Сэлэнгэ	94.8	2,187.4	2,092.6
Дархан-Уул	1,362.8	2,981.1	1,618.3
Орхон	136,487.8	145,266.8	8,779.0
ДҮН	1,903,132.1	1,931,782.2	28,650.1

*Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан дүн

Орон нутгийн хөгжлийн сан

Аймаг, нийслэлийн Орон нутгийн хөгжлийн санд шилжүүлдэг орлогын шилжүүлгийн эх үүсвэр нь Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэр болох ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр, газрын тосны нөөц ашигласны төлбөр болон улсын төсвийн эх үүсвэр болох хайгуулын тусгай зөвшөөрлийн төлбөр, ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөрөөс бүрддэг. Тус эх үүсвэрүүдийн олгох орлогын шилжүүлгийн хэмжээ, эх үүсвэрүүдийн нэмэгдлээс шалтгаалж, 2025 онд 599.1 тэрбум төгрөг байхаар төлөвлөлөө.

Иргэдийн ая тухтай амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн, уул уурхайн орлогоос бүрдэж, тухайн орон нутгийн иргэдийн санал, санаачилга дээр тулгуурлан зарцуулагддаг ОНХС-гийн хуваарилалтаас уул уурхайн олборлолт хийгдэж буй аймаг, сумдад түлхүү хуваарилах бодлогыг баримталж байна.

Хүснэгт 17. Орон нутгийн хөгжлийн сан

Аймаг	2025 Суурь*	2025 Төс.	Зөрүү
Архангай	14,505.7	14,505.7	0.0
Баян-Өлгий	14,026.3	14,026.3	0.0
Баянхонгор	23,502.4	23,502.4	0.0
Булган	15,258.1	15,258.1	0.0
Говь-Алтай	24,990.2	24,990.2	0.0
Дорноговь	55,686.9	55,686.9	0.0
Дорнод	30,428.3	30,428.3	0.0
Дундговь	18,250.4	18,250.4	0.0
Завхан	17,294.9	17,294.9	0.0
Өвөрхангай	17,299.9	17,299.9	0.0
Өмнөговь	60,770.5	60,770.5	0.0
Сүхбаатар	26,562.7	26,562.7	0.0
Сэлэнгэ	31,299.0	31,299.0	0.0
Төв	28,947.2	28,947.2	0.0
Увс	16,422.8	16,422.8	0.0

Ховд	30,475.8	30,475.8	0.0
Хөвсгөл	20,848.6	20,848.6	0.0
Хэнтий	23,761.1	23,761.1	0.0
Дархан-Уул	21,288.8	21,288.8	0.0
Улаанбаатар	60,333.0	60,333.0	0.0
Орхон	38,727.7	38,727.7	0.0
Говьсүмбэр	8,374.3	8,374.3	0.0
НИЙТ	599,054.5	599,054.5	0.0

*Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан дүн

2.2.7. Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн үлдэгдэл 2024 оны жилийн эцсийн хүлээгдэж буй гүйцэтгэлээр 35.2 их наяд төгрөг, ДНБ-ний 44.4 хувьтай тэнцэж байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлага болох 2024 онд 60.0 хувиас хэтрэхгүй байх гэсэн заалтыг хангахаар байна.

Хүснэгт 18. Засгийн газрын өрийн бүтэц /тэрбум ₮/

Өрийн хэрэгсэл	2024 ХБГ	2025 Суурь*	2025 Төс.	Зөрүү
Засгийн газрын дотоод өр	437.3	426.7	426.7	0.0
Дотоод үнэт цаас	437.3	426.7	426.7	0.0
Засгийн газрын гадаад өр	31,465.3	33,463.1	32,777.6	-685.6
Гадаад үнэт цаас	9,086.1	8,998.3	8,998.3	0.0
Гадаад зээл	22,686.3	24,464.8	23,779.2	-685.6
Засгийн газрын бусад өр	2,996.4	6,603.2	6,603.2	0.0
Засгийн газрын өрийн баталгаа	1,985.4	5,792.2	5,792.2	0.0
Орон нутгийн өр	1,011.0	811.0	811.0	0.0
ЗАСГИЙН ГАЗРЫН НИЙТ ӨР	35,206.2	40,493.0	39,807.5	-685.6
Хуулиар тогтоосон өрийн хязгаар	60.0%	60.0%	60.0%	
Засгийн газрын өр / ДНБ	44.4%	42.6%	41.9%	-0.7%

*Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан дүн

Түүнчлэн, Засгийн газрын өрийн үлдэгдэл 2025 оны төсөөллөөр ДНБ-ний 41.9 хувьтай тэнцэхээр байгаа нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан Засгийн газрын өрийн тусгай шаардлага 60 хувиас хэтрэхгүй байх шаардлагыг хангахаар байна.

Засгийн газрын зүгээс 2025 онд төв Засгийн газрын өрийн үндсэн төлбөрт 1,554.9 тэрбум төгрөг, орон нутгийн өрийн үндсэн төлбөрт 114.8 тэрбум төгрөг, нийт 1,669.7 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлөх хуваарьтай байна. Харин улсын төсвөөс төв Засгийн газрын өрийн хүүгийн төлбөрт 1,297.1 тэрбум төгрөгийг, орон нутгийн төсвөөс орон нутгийн өрийн хүүгийн төлбөрт 192.4 тэрбум төгрөг тус тус төлөхөөр байна.

Улсын Их Хурлаас 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр баталсан Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан Засгийн газрын гадаад зээлийн ашиглалтыг 666.6 тэрбум төгрөгөөр бууруулахаар төсвийн төсөлд тусгасны дагуу Засгийн газрын өрийн төсөөлөл 2025 онд 685.6 тэрбум төгрөгөөр, гадаад зээлийн хүүгийн төлбөр 6.3 тэрбум төгрөгөөр тус тус буурахаар байна.

Төсвийн суурь тэнцлийн ашгаар Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийг төлж барагдуулахдаа хуваарьт төлбөрийг тэргүүн ээлжид төлөх бөгөөд суурь тэнцлийн ашиг хуваарьт төлбөрөөс илүү гарсан тохиолдолд гадаад валютын улсын нөөцтэй уялдуулан өрийг хугацаанаас нь өмнө буцаан худалдан авах үйл ажиллагааг авч хэрэгжүүлж болно.

Хүснэгт 19. Засгийн газрын өрийн хүүгийн төлбөр /тэрбум ₮/

Засгийн газрын өрийн үйлчилгээ	2024	2025 Суурь*	2025 Төс.	Зөрүү
Хүүгийн төлбөр	1,173.6	1,303.4	1,297.1	-6.3
Гадаад бонд	556.2	576.8	576.8	0.0
Гадаад зээл	610.0	681.4	675.1	-6.3
Дотоод бонд	7.5	45.2	45.2	0.0

*Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан дүн

Засгийн газрын гадаад зээл

Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар 6,101.7 сая ам.доллар буюу 20,630.2 тэрбум төгрөгтэй тэнцэж байна.

Хүснэгт 20. Засгийн газрын гадаад зээл, зээлдүүлэгчээр, тэрбум төгрөг

ЗЭЭЛДЭГЧЭЭР	2023.12.31	2024.06.30
Олон талт	11,369.0	11,336.0
Азийн хөгжлийн банк	7,092.9	7,128.4
Дэлхийн банк	2,784.0	2,752.6
Азийн дэд бүтцийн хөрөнгө оруулалтын банк	704.8	685.7
Европын сэргээн босголт, хөгжлийн банк	274	332.9
Олон улсын валютын сан	248.1	160.6
Бусад	265.2	275.8
Хоёр талт	9,533.9	9,294.2
Бүгд Найрамдах Хятад Ард улс	3,539.5	3,547.1
Япон улс	3,362.3	2,864.7
Бүгд Найрамдах Солонгос улс	775.0	924.9
Бүгд Найрамдах Энэтхэг улс	780.2	862.4
Бүгд Найрамдах Австри улс	304.7	352.2
Бусад	772.2	742.9
НИЙТ	20,902.9	20,630.2

Засгийн газрын гадаад зээлийг зээлдүүлэгчээр ангилбал олон талт зээлдүүлэгчийн зээлийн үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар 11,336.0 тэрбум төгрөг, үүнээс Азийн хөгжлийн банк 62.9 хувийг, Дэлхийн банк 24.3 хувийг тус тус эзэлж байгаа бол хоёр талт зээлдүүлэгч улсаас авсан зээлийн үлдэгдэл 9,294.2 тэрбум төгрөг, үүнээс БНХАУ-аас 31.3 хувийг, Япон улсаас 25.3 хувийг тус тус авсан байна.

Засгийн газрын гадаад үнэт цаас

Засгийн газраас олон улсын зах зээлд арилжаалсан гадаад үнэт цаасны үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар 8,716.3 тэрбум төгрөг буюу 2,578.0 сая ам.доллартой тэнцэж байна.

Хүснэгт 21. Гадаад үнэт цаас, 2024.06.30 /тэрбум ₮/

№	Гадаад үнэт цаас	Хүү	Хугацаа	Үлдэгдэл
1	Номад	5.125%	5.5 жил	1,954.2
2	Сенчири-2027	3.500%	6 жил	1,690.5
3	Сенчири-2028	8.650%	5 жил	2,197.7
4	Сенчири-2029	7.785%	5.5 жил	1,183.4
5	Сенчири-2031	4.450%	10 жил	1,690.5
НИЙТ				8,716.3

Засгийн газрын өрийн удирдлагын 2023-2025 оны стратегийн баримт бичигт заасны дагуу шинээр гадаад үнэт цаас гаргасан тохиолдолд зөвхөн дахин санхүүжилт буюу өрийн зохицуулалтын хүрээнд гаргах бөгөөд төсөл хөтөлбөр санхүүжүүлэх, төсвийн алдагдал санхүүжүүлэх зорилгоор гадаад үнэт цаас гаргахгүй байхаар заасан.

Засгийн газраас 2021 онд авч хэрэгжүүлсэн Сенчири-1 төслийн хүрээнд Монгол Улс түүхэндээ хамгийн бага хүүтэйгээр өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн бол 2023 оны 1 дүгээр сард авч хэрэгжүүлсэн Сенчири-2 төслийн хүрээнд хөгжиж буй орнуудад хаалттай байсан зах зээлд өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсэн анхны орон болж, дефолтын эрсдэлээс бүрэн сэргийлж чадсан.

Засгийн газраас 2023 оны 12 дугаар сард хугацаа нь тулаад байсан “Хуралдай” бондын үлдэгдэл төлбөрийг дахин санхүүжилт хийх өрийн зохицуулалтын арга хэмжээг Сенчири-3 төслийн хүрээнд 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр амжилттай авч хэрэгжүүлсэн. Энэ хүрээнд 350.0 сая ам.долларын Сенчири-3 бондыг 7.875 хувийн хүүтэй 5.5 жилийн хугацаатайгаар 2023 оны 12 дугаар сарын 05-ны өдөр олон улсын санхүүгийн зах зээл дээр арилжаалж, 2024 оны 3 дугаар сард эргэн төлөгдөх хуваарьтай “Хуралдай” бондын үлдэгдэл 339.5 сая ам.долларыг дахин санхүүжүүлж, үлдсэн хэсгийг төрийн сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдлээс төлж барагдуулсан.

Түүнчлэн Сенчири-3 бондын хүүгийн түвшин дэх Монгол Улсын Засгийн газрын эрсдэлийн түвшин буюу “spread” мөн түүхэндээ хамгийн бага буюу 2.3 хувь болсон нь Засгийн газрын өмнө гарган арилжаалж байсан гадаад бондуудын эрсдэлийн дундаж түвшин болох 5.5 хувиас 2 дахин багассан үзүүлэлт юм.

Сенчири-1, 2, 3 өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлснээр 2022-2024 онд төлөгдөх хуваарьтай байсан Чингис, Гэрэгэ, Хуралдай бондуудын нийт 2,000.0 сая ам.долларын төлбөрийг төлбөрийн тэнцэл, улсын төсөвт дарамт үүсгэхгүйгээр шийдвэрлэсэн бөгөөд үүнээс 280.5 сая ам.долларын төлбөрийг төрийн сангийн мөнгөн хөрөнгөөс төлж барагдуулсан. Ийнхүү өрийн зохицуулалтын арга хэмжээг авч хэрэгжүүлсний үр дүнд 2026 он хүртэл томоохон гадаад үнэт цаасны эргэн төлөлтүүдийг шийдвэрлээд байна.

Засгийн газрын дотоод өр

Дотоод үнэт цаасны үлдэгдэл 2024 оны эхний хагас жилийн байдлаар 141.6 тэрбум төгрөг байгаа бөгөөд үүнээс 45.0 тэрбум төгрөг төсвийн алдагдал санхүүжүүлэх, 96.6

тэрбум төгрөг нь “Сайн хувьцаа” хөтөлбөрийг санхүүжүүлэх зориулалтаар арилжаалсан үнэт цаас байна. Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг 2017 оноос зогсоогоод байгаа бөгөөд дотоод үнэт цаасны үлдэгдэл 2017 оны түвшнээс 14.8 дахин буураад байна.

Санхүүгийн зохицуулах хорооны судалгаагаар 2024 нэгдүгээр улирлын байдлаар үнэт цаасны зах зээлд нийт 600 зохицуулалттай этгээд, хувьцаат компани үйл ажиллагаа явуулж байгаа нь 2017 оны мөн үеэс 2 дахин нэмэгдсэн, 204.9 тэрбум төгрөгийн үнэт цаас зах зээлд арилжаалагдсан нь 2018 оны мөн үеэс 4.9 дахин өссөн үзүүлэлттэй байна. Мөн үнэт цаасны данстай 2.58 сая хүн байгаа нь нийт хүн амын 73 хувь буюу 2017 оны мөн үеэс 2.8 дахин өссөн байна. Үнэт цаасны зах зээлийн арилжаанд оролцогчдын 99 хувь нь дотоодын иргэн, аж ахуйн нэгж байгаа нь дотоод үнэт цаасны арилжаа зогссон 2017 онтой харьцуулахад үнэт цаасны зах зээл харьцангуй өсөлттэй буюу хөрөнгө оруулагчдын тоо нэмэгдсэн эерэг үзүүлэлттэй байгаа нь дотоод үнэт цаас гаргахад таатай нөхцөл байдлыг үүсгээд байна.

Иймд эрсдэлгүй хөрөнгө оруулалтын жишиг хүүг тогтоох, дотоодын хөрөнгийн зах зээлийг дэмжих зорилгоор Засгийн газрын дотоод үнэт цаасны арилжааг эхлүүлэхээр төлөвлөж байна.

Орон нутгийн өр

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 4.1.8.а-д зааснаар өрийн хэрэгслээр үүсгэж, аймаг нийслэлээс бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүрэг нь Засгийн газрын өрд тооцогддог. Аймаг, нийслэлээс хувийн хэвшилд төлөх өр төлбөр 2024 оны эхний хагас жилийн байдлаар 504.5 тэрбум төгрөгтэй тэнцэж байгаа бөгөөд энэ нь дараах зээллэгүүдээс бүрдэж байна. Үүнд:

- Нийслэл нь Монгол Улсын хөгжийн банкнаас “Автобусны парк шинэчлэлийн төсөл”-ийг хэрэгжүүлэх зорилгоор 21.0 тэрбум төгрөгтэй тэнцэх хэмжээний зээлийг 2021 онд авч ашигласнаас нийт 16.5 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийж 4.5 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна;
- Нийслэлийн Засаг даргын Тамгын газраас Засгийн газрын 2024 оны 05 дугаар сарын 08-ны өдрийн 201 дугаар тогтоолын дагуу дотоодын зах зээлд 2024 оны 06 дугаар сарын 25-ны өдөр 500.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг 12-14 хувийн хүүтэйгээр арилжаалаад байна.

Түүнчлэн, Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 17 дугаар тогтоолын дагуу 500.0 сая ам.долларын Нийслэлийн үнэт цаасыг 2024 оны 11 дүгээр сарын 21-ний өдөр олон улсын зах зээлд Засгийн газрын өрийн баталгаатайгаар арилжаалсан. Мөн Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 05-ны өдрийн 264 дүгээр тогтоолын дагуу Нийслэлээс 2024 онд 500.0 тэрбум төгрөгийн үнэт цаасыг дотоодын зах зээлд гаргах зөвшөөрлийг олгосон. Ингэснээр 2025 онд Нийслэлийн үнэт цаасанд 114.8 тэрбум төгрөгийн үндсэн төлбөр төлөх төсөөлөлтэй байна.

Засгийн газрын болзошгүй өр төлбөр

Засгийн газрын өрийн баталгаа

“Засгийн газрын өрийн баталгаа” нь баталгаа гаргуулагч зээллэгийн төлбөрийн үүргээ гүйцэтгэж чадахгүй болсон тохиолдолд төлбөрийг баталгаа гаргуулагчийн

өмнөөс төлж барагдуулахаар Засгийн газрын хүлээсэн үүрэг бөгөөд улсын төсөвт учирч болзошгүй өр төлбөрт хамаарна.

Засгийн газрын зүгээс Өрийн удирдлагын тухай хуулийн дагуу гаргасан Засгийн газрын өрийн баталгаатай зээллэгийн үлдэгдэл дараах байдалтай байна. Үүнд:

1. “Эрдэнэс монгол” ХХК-д гаргасан Засгийн газрын өрийн баталгаа. “Эрдэнэс Монгол” ХК 2016 оны 4 дүгээр сарын 1-ний өдөр 35.0 сая ам.долларын ЛИБОР (6 сар) +0.6 хувийн хүүтэй, 15 жилийн хугацаатай зээлийг Азийн хөгжлийн банкнаас авсан бөгөөд Засгийн газрын 2016 оны 138 дугаар тогтоолоор Засгийн газрын баталгаа гаргасан. Энэхүү зээлийг 2024 онд төлж дуусгасан болно.

2. Монгол Улсын Хөгжлийн банкинд гаргасан Засгийн газрын өрийн баталгаа. Улсын Их Хурлын 2023 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн 90 дүгээр тогтоол, Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 133 дугаар тогтоолын дагуу БНХАУ-ын Хөгжлийн банкны 420 сая юанийн зээлийн эх үүсвэрээр хэрэгжиж буй “Чойбалсан ДЦС-ыг 50 МВт-аар өргөтгөх төсөл”-ийн санхүүжилтэд зориулж Монгол Улсын Хөгжлийн банканд 2024 оны 05 дугаар сарын 06-ны өдөр Засгийн газрын өрийн баталгааг гаргасан бөгөөд тус дулааны цахилгаан станцын өргөтгөл нь 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдөр ашиглалтад орсон. Уг зээл 2031 онд төлөгдөж дуусах хуваарьтай байна.

3. Нийслэлийн Засаг даргын Тамгын газарт гаргасан Засгийн газрын өрийн баталгаа. Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 17 дугаар тогтоол, Засгийн газрын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 265 дугаар тогтоолын дагуу “Сэлбэ” дэд төвийн бүтээн байгуулалтыг Нийслэлийн гадаад үнэт цаас гарган санхүүжүүлэхэд Засгийн газрын өрийн баталгаа гаргасан. Энэхүү үнэт цаас нь 500 сая ам.долларын хэмжээтэй, 2.75 жилийн хугацаатай, 7.75 хувийн хүүтэй бөгөөд 2027 оны 08 дугаар сард төлөгдөх хуваарьтай байна.

2.3. Төсвийн болзошгүй эрсдэлийн тойм

Нэг. Эрчим хүчний тасалдал: Манай улсын өнөөгийн эрчим хүчний хангамж, хүртээмж нь өсөн нэмэгдэж буй эрэлт, хэрэгцээг хангаж чадахааргүй нөхцөл байдалтай байна. Эрчим хүчний үнэ нь үйлдвэрлэлийн бодит өртгөөс доогуур байгаа нь үр ашгийг бууруулж, эрчим хүчний салбар алдагдалтай ажиллаж байна. Үүний зэрэгцээ манай улсын эрчим хүчний хангамж нь нэг төвлөрсөн системтэй ба станцуудын насжилт өндөр, дамжуулалт, түгээлтийн шугам, тоног төхөөрөмжийн дийлэнх нь хуучирч, элэгдсэн буюу эрчим хүчний тасалдал үүсэх эрсдэлтэй нөхцөл байдалд байна. Эрчим хүчний нийлүүлэлт тасалдах нь бодит салбаруудын үйл ажиллагаа, нийт эдийн засгийн бүтээмжийг хязгаарлах эрсдэлтэй. Эрсдэлийг бууруулах хүрээнд Засгийн газрын зүгээс эрчим хүчний салбарын реформын ажлыг эхлүүлээд байна.

Хоёр. Зуд, ган, мал, амьтны өвчин: Байгалийн гамшигт үзэгдлийн давтамж нэмэгдэж, хөдөө аж ахуйн салбарын үйлдвэрлэл буурах, үүнийг даган малчин, тариаланч аж ахуйн нэгж, өрхүүдийн орлого, хэрэглээ хумигдах, хөдөө аж ахуйн гаралтай бүтээгдэхүүний үнэ өсөх, малын халдварт өвчин тархах эрсдэл өндөр байна. Хоёр жил дараалсан өвөлжилт, хаваржилтын хүндрэл, зудын улмаас ирэх онуудад махны нийлүүлэлт буурч, хүнсний инфляц нэмэгдэх, мөн хөдөө аж ахуйн үйлдвэрлэл багасаж, малчдын амьжиргаа дордон хэрэглээ хумигдах, цаашлаад эдийн засаг дахь хөрөнгийн хуримтлалд сөрөг нөлөө үзүүлж, өсөлтийг сааруулах эрсдэлтэй байна.

Гурав. Экспортын түүхий эдийн үнийн бууралт: Экспортын голлох бүтээгдэхүүнүүдийн гадаад зах зээл дээрх үнийн бууралт манай улсын экспортын орлогод сөргөөр нөлөөлж болзошгүй байна. Мөн түүхий эдийн дэлхийн зах зээлд өндөр нөлөө бүхий БНХАУ-ын үл хөдлөх хөрөнгийн салбарын уналт үргэлжилж, тус улсын эдийн засгийн өсөлт хүлээлтээс доогуур байх нь манай улсын экспортын түүхий эдийн эрэлт, үнийг бууруулах замаар эдийн засгийн өсөлтийг хязгаарлах эрсдэлтэй байна.

Дөрөв. Геополитикийн тогтворгүй байдал: ОХУ-Украины нөхцөл байдал даамжрах, Газын зурвас, Израйл орчмын бүс нутгийн мөргөлдөөн хурцдах, Улаан тэнгист халдлага үргэлжлэх зэрэг эрсдэлүүд авто бензин, улаан буудай, хүнс, эрчим хүч зэрэг манай улсын импортын голлох бараа бүтээгдэхүүний үнийг өсгөж болзошгүй байна. Мөн томоохон эдийн засаг хоорондын худалдааны дайн дэлхийн худалдааны эргэлтэд сөргөөр нөлөөлж болзошгүй байна.

Тав. Нийлүүлэлтийн тасалдал: Монгол Улсын нийт импортын 80 орчим хувь нь Тяньжин боомтоор дамжин, төмөр замаар тээвэрлэгдэн Замын-Үүд боомтоор орж ирдэг. КОВИД-19 цар тахлын үед Тяньжин боомтод 9,000 гаруй чингэлэг бөөгнөрч, импортын бүтээгдэхүүний нийлүүлэлт тасалдал үүссэнээс шалтгаалан инфляц 16.9 хувьд хүрсний 8.9 нэгж хувь буюу 55 гаруй хувийг импортын инфляц бүрдүүлж байв. Тяньжин боомтоос өдөрт гарах галт тэрэгний тоо буурсантай холбоотойгоор тус боомт дээрх чингэлгийн тоо энгийн үеэс өндөр хэвээр байгаа нь нийлүүлэлтийн хугацааг уртасгаж, бараа бүтээгдэхүүний үнэ өсөх эрсдэлийг дагуулж байна.

ГУРАВДУГААР БҮЛЭГ: НЭГДСЭН ТӨСВИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

3.1. Төсвийн үр дүнгийн үзүүлэлтүүд

Төсвийн төсөлд Монгол Улсын 2025 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээг 33.5 их наяд төгрөг буюу ДНБ-ий 35.2 хувь, нийт зарлагын хэмжээг 33.5 их наяд төгрөг буюу 35.2 хувь, төсвийн суурь тэнцлийг 3.2 их наяд төгрөг буюу ДНБ-ий 3.3 хувьтай тэнцүү ашигтай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 22. Нэгдсэн төсвийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2024 БАТ	2025 Суурь*	2025 Төс.	Зөрүү
НИЙТ ОРЛОГО	30,639.5	36,830.5	36,435.7	-394.7
Тогтворжуулалтын сан	478.6	608.9	608.9	0.0
Үндэсний баялгийн сан	1,288.5	2,356.8	2,356.8	0.0
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО	28,872.5	33,864.7	33,470.0	-394.7
НИЙТ ЗАРЛАГА	30,487.9	35,771.9	33,470.0	-2,301.9
Урсгал зардал	22,470.8	26,034.6	25,308.6	-726.0
Хөрөнгийн зардал	8,066.2	9,782.4	8,334.1	-1,448.3
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-49.1	45.0	-172.7	-127.6
ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ТЭНЦЭЛ	-1,615.4	-1,907.2	0.0	1,907.2
ДНБ-д эзлэх хувь	-2.0	-2.0	0.0	2.0
СУУРЬ ЗАРЛАГА	27,269.0	31,931.9	30,296.5	-1,635.4
ДНБ-д эзлэх хувь	34.4	33.6	31.7	1.9
СУУРЬ ТЭНЦЭЛ	1,603.5	1,932.8	3,173.4	1,240.6
ДНБ-д эзлэх хувь	2.0	2.0	3.3	1.3

*Монгол Улсын Их Хурлын нэгдсэн чуулганаар 2024 оны 11 дүгээр сарын 08-ны өдөр батлагдаж, 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдөр хүчингүй болсон Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуульд туссан дүн

3.2. Төсвийн тусгай шаардлага

Улсын Их Хурлаас 2024 оны 8 дугаар сарын 27 өдөр баталсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуульд заасны дагуу Монгол Улсын 2025 төсвийн үндсэн үзүүлэлтүүдийг бүрэн нийцүүлж хуулийн төслийг боловсрууллаа.

Нэгдсэн төсвийн орлогыг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.3.а-д заасан шаардлагын дагуу зэс, нүүрсний үнийг тэнцвэржүүлсэн журмаар тооцсон бөгөөд 2025 онд зэсийн тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 7,491.7 ам.доллар, нүүрсний тэнцвэржүүлсэн үнийг тонн тутамд 129.0 ам.доллар байхаар тооцлоо.

Нэгдсэн төсвийн суурь тэнцэл нь тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний хоёр буюу түүнээс дээш хувийн ашигтай байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.2-т заасны дагуу нэгдсэн төсвийн суурь тэнцэл ДНБ-ий 2 хувиас дээш ашигтай байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 23. Нэгдсэн төсвийн суурь тэнцлийн ДНБ-д эзлэх хувь

	2025
Хуулийн хязгаар	2.0%
Төсөөлөл	3.3%

Тухайн жилийн нэгдсэн төсвийн урсгал зарлагын хэмжээ тухайн жилийн дотоодын нийт бүтээгдэхүүний 30 хувиас хэтрэхгүй байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.3-т заасны дагуу урсгал зарлагыг ДНБ-ий 30.0 хувиас хэтрэхгүй байхаар төлөвлөлөө.

Хүснэгт 24. Нэгдсэн төсвийн урсгал зарлагын ДНБ-д эзлэх хувь

	2025
Хуулийн хязгаар	30.0%
Төсөөлөл	26.6%

Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлэгдсэн үлдэгдэл нь тухайн жилийн оны үнээр тооцсон дотоодын нийт бүтээгдэхүүний 60 хувиас хэтрэхгүй байх: Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6.1.4-д заасны дагуу Засгийн газрын өрийн нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн үлдэгдэл 2023-2025 онд хуульд заасан хязгаарт байхаар байна.

Хүснэгт 25. Засгийн газрын өрийн төсөөлөл, нэрлэсэн дүнгээр (ДНБ-д эзлэх хувь)

	2025
Хуулийн хязгаар	60.0%
Төсөөлөл	41.9%

3.3. Сангийн үлдэгдлүүд

Төсвийн тогтворжуулалтын сангийн үлдэгдэл 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 1,596,178.2 сая төгрөг, Ирээдүйн өв сангийн үлдэгдэл 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн байдлаар 3,645,940.4 сая төгрөг байна.

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ: ТӨСВИЙН ТӨСЛИЙН ХАВСРАЛТ

4.1. Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төслийн тайлбар

1 дүгээр бүлэг – Нийтлэг үндэслэл

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн зорилт болон бусад хууль тогтоомжтой нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг дурдсан. Хуулийн зорилтын талаар тус танилцуулгын Хоёрдугаар бүлэгт дэлгэрэнгүй тусгасан.

2 дугаар бүлэг – Монгол Улсын 2025 оны төсвийн орлого, зарлага болон хөрөнгө, өрийн удирдлага

Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч, түүний харьяа болон бусад байгууллагын төсөвт төвлөрүүлэх дүн болон 2025 оны төсвийн жилд төвлөрүүлэх нийт тэнцвэржүүлсэн орлогын дүнг тусгасан. Орлогын дэлгэрэнгүй тайлбарыг Хоёрдугаар бүлэг “Төсвийн орлого” хэсэгт тусгасан.

Монгол Улсын төсөвт 2025 оны төсвийн жилд төсвийн ерөнхийлөн захирагч нарийн эргэн төлөх үндсэн төлбөрийн дүн болон зарцуулах төсвийн дүнг тусгасан бөгөөд урсгал зардлын дэлгэрэнгүй тайлбарыг Хоёрдугаар бүлэг “Төсвийн урсгал зардал” хэсэгт тусгасан.

Улсын төсвийн хөрөнгөөр болон “Барих-Шилжүүлэх” концессын төрлөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн төсвийн дүнг тусгасан. Үүний талаар дэлгэрэнгүй тайлбарыг Хоёрдугаар бүлэг “Төсвийн хөрөнгө оруулалт” хэсэгт оруулсан.

Төсвийн тогтворжуулалтын санд хуримтлуулах дүн, Ирээдүйн өв санд хуримтлуулах дүнг тусгасан. Үүний дэлгэрэнгүй тайлбарыг Хоёрдугаар бүлгийн “Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого” хэсэгт оруулсан.

Түүнчлэн, Тухайн төсвийн жилд эргэн төлөгдөх нөхцөлтэй гаргасан зээллэг болон өрийн зохицуулалтын арга хэмжээнээс бусад 2025 оны төсвийн жилд төлөх Засгийн газрын өрийн үндсэн төлбөрийн хэмжээ, Засгийн газрын гаргах өрийн баталгааны дээд хэмжээг тус тус тусгасан. Дэлгэрэнгүй тайлбарыг Хоёрдугаар бүлэг “Засгийн газрын өр” хэсэгт оруулсан.

3 дугаар бүлэг – Орон нутгийн төсөвт олгох санхүүгийн дэмжлэг, орон нутгийн төсвөөс төвлөрүүлэх орлого, орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлэг

Орон нутагт 2025 оны төсвийн жилд олгох санхүүгийн дэмжлэгийн хэмжээ, орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хэмжээ болон 2025 оны төсвийн жилд Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон улсын төсвөөс Орон нутгийн хөгжлийн санд олгох орлогын шилжүүлгийн хэмжээг заасан.

4 дүгээр бүлэг – Бусад зүйл

Хуулийн төслийн хавсралтаар батлах “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2025 онд хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо

хэмжээний үзүүлэлт”, “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд эргэн төлөлт хийх концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”, “Монгол Улсын төсвийн хөрөнгөөр 2025 онд эргэн төлөлт хийх концессын “Барих-Шилжүүлэх” төрлөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ, барилга байгууламжийн жагсаалт”-ыг тус тус оруулсан. Түүнчлэн хуулийн дагаж мөрдөх хугацааг тусгасан.

4.2. Олон нийтийн хэлэлцүүлэг

Нэг. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын цахим системээр дамжуулан зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг

Сангийн яамны “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем”-ийн нээлттэй вэб сайт болон App Store, Google play зэрэг гаднын сайтад байршуулсан “Төсвийн хөрөнгө оруулалт”, “Public Investment” нэртэй гар утасны аппликэйшнээр дамжуулж, 2024 оны 03-р сарын 1-нээс 2024 оны 03 сарын 31-нийг дуустал хугацаанд улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтөд орон нутгийн 10,851 иргэнээс давхардсан тоогоор нийт 1135 төслийн санал ирүүлсэн байна.

Төслийн саналыг салбараар нь ангилж харуулбал:

Хүснэгт 26. Хэлэлцүүлгийн үр дүн

№	Салбар	Төслийн тоо	Хувь
1	Аялал жуулчлал	11	1.0
2	Барилга	142	12.5
3	Боловсрол	318	28.0
4	Зам, тээвэр	110	9.7
5	Мэдээллийн технологи	2	0.2
6	Соёл, спорт	156	13.7
7	Төрийн үйлчилгээ, бусад	102	9.0
8	Уул уурхай, хүнд үйлдвэрлэл	3	0.3
9	ХАА, хөнгөн үйлдвэрлэл	31	2.7
10	Харилцаа холбоо	20	1.8
11	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	14	1.2
12	Хүрээлэн буй орчин	34	3.0
13	Шинжлэх ухаан	1	0.1
14	Эрүүл мэнд	126	11.1
15	Эрчим хүч	65	5.7
НИЙТ		1135	100.0

Төслийн саналыг эдийн засгийн ангиллаар харуулбал:

Хүснэгт 27. Хэлэлцүүлгийн үр дүн

№	Эдийн засгийн ангилал	Төслийн тоо	Хувь
1	Тоног төхөөрөмж	87	7.7
2	Их засвар	228	20.1
3	Барилга байгууламж	820	72.2
НИЙТ		1135	100.0

Олон нийтээс цахим системд илгээсэн дээрх 1135 төслөөс Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлд заасан цаглабар болон 29¹ дүгээр зүйлд заасан төсвийн хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд тавигдах шаардлагын дагуу орон нутаг, төсвийн ерөнхийлөн захирагчаас 7 төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгуулахаар цахим системээр баталгаажуулсан боловч хуульд заасан зураг төсөвтэй байх, газартай байх, үр ашигтай байх зэрэг үндсэн шаардлагыг бүрэн хангаагүй 5 төсөл, арга хэмжээ төсвийн төсөлд тусгагдаагүй. Харин Орхон голын төмөр бетон гүүрний дуусгал /Сэлэнгэ, Орхонтуул сум/, Баруунбүрэн-Амарбаясгалант хийд чиглэлийн хатуу хучилттай авто зам, 33.4 км

/Төвийн бүс/ төсөл, арга хэмжээг дээрх шалгуур үзүүлэлтийг хангасан тул төсвийн төсөлд тусгасан болно.

Хоёр: Салбар бүрээр зохион байгуулсан олон нийтийн хэлэлцүүлэг

Төсвийн тухай хуулийн 28¹ дүгээр зүйлд төсвийн төслийн үйл явцад олон нийтийн хэлэлцүүлгийг салбар бүрээр зохион байгуулахаар заасан. Үүний дагуу дараах салбарууд Сангийн яаманд хэлэлцүүлгийн үр дүнг ирүүлээд байна.

№	Салбар	Хэлэлцүүлгийн хэлбэр, Цахим холбоос	Хэлэлцүүлгээс гарсан үр дүн
1	Боловсрол	Цахимаар https://ebudget.edu.mn/	Санал асуулгыг урсгал төсөв болон хөрөнгө оруулалт төрлөөр зохион байгуулж нийт 70,802 иргэн санал өгч оролцсон байна. Нийт санал өгсөн иргэдийн 53 хувь нь боловсролын салбарын багш, ажилтан, 37 хувь нь эцэг, эх, асран хамгаалагчийн төлөөлөл, 6 хувь нь суралцагч, 2 хувь нь иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл, 2 хувь нь бусад гэсэн ангиллаар оролцсон байна. Газар зүйн байршлаар авч үзвэл нийслэлээс 18,336 иргэн, аймгуудаас Баянхонгор аймаг 7,503 иргэн, Сэлэнгэ аймаг 3,368 иргэд санал өгч цахим хэлэлцүүлэгт оролцсон байна. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих “Багш бүрд компьютер” /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээ 2,423 санал, Боловсролын салбарын тоног төхөөрөмж /Улсын хэмжээнд/ төсөл арга хэмжээнд 1,815 саналыг тус тус авч хамгийн өндөрт эрэмбэлэгдсэн байна. Урсгал төсвийн талаар авсан санал асуулгад ерөнхий боловсролын сургуулийн дотуур байрны хүүхдийн хоол, үдийн хоолны норматив, цэцэрлэгийн хүүхдийн хоолны норматив зардлуудыг нэмэгдүүлэх зардлыг хамгийн ихээр ирүүлсэн бол ЗГ-н 2024 оны 39 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан хувьсах зардал түүний бүрэлдэхүүнийг өөрчлөх шаардлагагүй гэсэн саналыг нийт хэлэлцүүлэгт оролцогчдын 54 хувь нь ирүүлсэн байна.
2	Байгаль орчин	Цахимаар https://met.gov.mn/posts/baigal-orcin-uur-amsgalyn-oorcloltiin-saidyn-2025-ony-tosviin-tosold-sanalaa-ogno-uu#	Урсгал төсвийн төсөлд 112 , хөрөнгө оруулалтын төсөлд 65 иргэн саналаа өгсөн байна.
3	Хөдөлмөр, нийгмийн хамгаалал	Цахимаар https://mlsp.gov.mn/content/detail/3360	Нийт 68 санал ирүүлснээс 40 хувь нь “Хөдөлмөр, халамжийн үйлчилгээний төвийн барилга” /Хөвсгөл, Мөрөн сум/, 10 хувь нь “Гэр бүл, хүүхэд хөгжлийн төв” /Хөвсгөл, Цагаан Уул сум/, 10 хувь нь “Найрамдал-2” олон улсын хүүхэд, өсвөр үе, амралт залуучуудын хөгжлийн цогцолборын өвлийн амралтын байрны барилгын угсралт, 7 хувь нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга” /Орхон аймаг, Баян-Өндөр сум/, 3 хувь нь “Хөгжлийн бэрхшээлтэй хүний хөгжлийн төвийн барилга” /Сүхбаатар аймаг/ болон бусад саналууд ирсэн байна.
4	Цахим хөгжил	Цахимаар https://mddc.gov.mn/mn/	Нийт 254 иргэн санал ирүүлсэн. Улсын төсвийн хөрөнгө оруулалтын саналд 2025 онд шинээр хэрэгжүүлэхээр нийт 27 төсөл, арга хэмжээ төлөвлөснөөс иргэдээс 22 төсөл, арга хэмжээг дэмжсэн санал ирүүлсэн. Үүнээс дурдвал:

№	Салбар	Хэлэлцүүлгийн хэлбэр, Цахим холбоос	Хэлэлцүүлгээс гарсан үр дүн
			<ol style="list-style-type: none"> 1. Хонхорын радио нэвтрүүлэх төв станцыг тоон радиод шилжүүлэх -56 санал 2. Сэлгэн ажиллах дата төвийн тоног төхөөрөмжийн нөөцийг бий болгох -47 санал 3. Системийн тооцоолох сервер болон мэдээлэл хадгалах сторэйж агуулсан багц төхөөрөмж /2 төрөл/ -38 санал 4. Next generation firewall системийн аюулгүй байдлыг ханган төрөл бүрийн хандалтын дүрмийг шалгах боломжтой 2-с дээш хослон кластер байдлаар ажиллах аюулгүй байдлын төхөөрөмж -29 санал 5. Мэдээллийн технологийн бүтээгдэхүүн, үйлчилгээг хүн, хуулийн этгээдээс худалдан авах нэг цонхны бүртгэлийн систем хөгжүүлэх -16 санал 6. Мэдээлэл, технологийн үндэсний паркийн барилгын их засвар - 20 санал 7. Мэдээллийн технологийн үйлдвэрлэлийг дэмжих виртуал бүсийн ажлын албаны үйл ажиллагааны платформ хөгжүүлэх- 17 санал 8. Бусад 14 төсөлд - 31 санал тус тус ирүүлсэн байна
5	Эрүүл мэнд	Цахимаар https://s.surveyplant.com/7yebrofm/	Хэлэлцүүлэгт нийт 311 санал ирүүлсэн байна. Ирүүлсэн саналыг нэгтгэн дүгнэвэл: <ol style="list-style-type: none"> 1. Эрүүл мэндийн сайдын багц <ol style="list-style-type: none"> 1.1. Эмч эмнэлгийн ажилчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх- 6 арга хэмжээ 1.2. Эмч, эмнэлгийн мэргэжлийн чадавхжуулах- 4 арга хэмжээ 1.3. Эрүүл мэндийн бодлого удирдлагын арга хэмжээ- 4 арга хэмжээ 1.4. Цахим бодлого- 2 арга хэмжээ 2. Эрүүл мэндийн даатгалын сан – 5 арга хэмжээ 3. Хөрөнгө оруулалт: нийт 272 санал дараах 3 ангиллын дагуу ирүүлсэн байна. <ol style="list-style-type: none"> 3.1. Барилга 3.2. Их засвар 3.3. Тоног төхөөрөмж
6	Хууль зүй	Цахимаар https://mojha.gov.mn/content/66bab5ca9fea4ca6d50af832 https://www.facebook.com/mojha.gov.mn https://news.mn/r/2744685/	Саналын хугацаанд 8 иргэн, 14 арга хэмжээнд давхардсан тоогоор нийт 30 санал өгсөн байна. Үүнд: Дэмжсэн-24 Дэмжээгүй-2 Санал зөвлөмж- 4
7	Барилга	Цахимаар https://s.surveyplanet.com/jwz985a0	Төсвийн ерөнхийлөн захирагчийн багцад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 380 төсөл, арга хэмжээний саналыг бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын хүрээнд 7 бүсээр хуваарилан нэн шаардлагатай төсөл, арга хэмжээнүүдийг сонгох байдлаар явуулсан бөгөөд 2024 оны 08 дугаар сарын 15-ны байдлаар нийт 1128 хүн санал асуулгад оролцон 7260 санал, нэмэлтээр 252 санал хүсэлт өгсөн байна. Давхардсан тоогоор хамгийн олон санал авсан төсөл, арга хэмжээнүүдийг жагсаавал:

№	Салбар	Хэлэлцүүлгийн хэлбэр, Цахим холбоос	Хэлэлцүүлгээс гарсан үр дүн
			-“Алсын хараа-2050”, “Шинэ сэргэлтийн бодлого”, “Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал”-ын хүрээнд хэрэгжүүлэх аймаг, сумдын инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлт /Улсын хэмжээнд/ -Төв, суурин газрын ундны усны чанарын судалгаанд суурилсан авч хэрэгжүүлэх ажлын “Дунд хугацааны хөтөлбөр” боловсруулах /Улсын хэмжээнд/ -“Шинэ Хархорум” хотын зураг төслүүд; -40, 60, 80, 100 айлын түрээсийн орон сууцны нэг маягийн барилгын зураг төсөл боловсруулах /Улсын хэмжээнд/ -Цэвэрлэх байгууламжийн засвар шинэчлэлийн зураг төсөл боловсруулах /Орхон, Жаргалант/ г.м
8	Соёл	Цахимаар	Нийт -70 төсөл арга хэмжээний санал ирүүлсэн байна.
9	Спорт	Цахимаар	Нийт- 84 төсөл арга хэмжээний санал ирүүлсэн байна.
10	Аялал жуулчлал	Цахимаар	Нийт- 11 төсөл арга хэмжээний санал ирүүлсэн байна.
11	Залуучууд	Цахимаар	Нийт- 7 төсөл арга хэмжээний санал ирүүлсэн байна.
12	Хөдөө аж ахуй	https://www.mofa.gov.mn/news/HEWLEL/66b4411149f00f22aed6f545/	Салбарын 2025 оны төсөвт 5 чиглэлд нийт 17 санал ирүүлсэн байна.
13	Эрчим хүч	Цахимаар https://energy.gov.mn	-Цахилгааны чиглэлээр: 88 санал -Дулааны чиглэлээр: 67санал -ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах чиглэлээр: 43 санал
14	Уул уурхай	Танхимаар	Аж үйлдвэр, эрдэс баялгийн салбарын хүрээнд 2025 оны төсвийн төслийн саналыг боловсруулж, хэлэлцүүлэг зохион байгуулсан. Хэлэлцүүлгээс гарсан тодорхой арга хэмжээг хэрэгжүүлэхээр төсвийн төсөлд тусгасан.
15	Зам тээвэр	Цахимаар	Хэлэлцүүлэгт оролцож, саналаа ирүүлсэн иргэдийн 87 хувь нь төсвийн төслийг дэмжсэн байна. Мөн авто замын төлбөр авах цэгийн цахимжуулалт, авто замын засвар арчлалтын санхүүжилтийг нэмэгдүүлэх тухай саналуудыг ирүүлснийг холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэн ажилласан байна.

Олон нийтийн хэлэлцүүлгийн үр дүнд ирүүлсэн төсөл, хөтөлбөрийн саналууд Төсвийн тухай хуулийн 28¹.2.3 дахь заалт болон Монгол Улсын Засгийн газрын 2024 оны 03 дугаар сарын 06-ны өдрийн 93-р тогтоолоор батлагдсан “Төсвийн төсөл, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаарх олон нийтийн хэлэлцүүлэг зохион байгуулах журам”-ын 2.9-д заасан шаардлагуудыг хангасан зарим төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд тусгалаа.

4.3. Хамт өргөн мэдүүлсэн хууль тогтоомжийн төсөл

Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй холбогдуулан 14 хуулийн төсөл, 4 Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулсан. Үүнд:

1. Хуулийн төсөл:

- Үндэсний баялгийн сангийн тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

- Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Хууль хүчингүй болсонд тооцох тухай
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай
- Соёлын бүтээлч үйлдвэрлэлийг дэмжих тухай хуулийн зарим зүйл, хэсэг хүчингүй болсонд тооцох тухай
- Зөрчлийн тухай хуулийн зарим хэсэг хүчингүй болсонд тооцох тухай
- Соёлын тухай хуулийн зарим хэсэг, заалт хүчингүй болсонд тооцох тухай
- Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- Кино урлагийг дэмжих тухай хуульд өөрчлөлт оруулах тухай
- Төрийн хэмнэлтийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

2. Улсын Их Хурлын тогтоолын төсөл:

- Засгийн газрын үнэт цаас гаргах эрх олгох тухай
- Засгийн газарт чиглэл өгөх тухай
- Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай
- Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хууль батлагдсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай

4.4. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр арга хэмжээний талаарх товч танилцуулга

Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн “22.6.4.төсөв батлах эрх бүхий байгууллага нь төсвийг шатлал бүрээр, түүнд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагч, тэдгээрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүн, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ, тусгай сан, орлого, санхүүжүүлэх эх үүсвэр бүрээр нь батлах;”, мөн хуулийн 6 дугаар зүйлийн “6.2.7.төсвийн төлөвлөлтийг дунд хугацааны хөгжлийн бодлоготой уялдсан хөтөлбөрөөр төлөвлөн, хөтөлбөрийн үр дүн болон гарцыг шалгуур үзүүлэлтийн хамт тодорхойлж баталж, хэрэгжүүлэх.” гэсэн заалт, холбогдох Төсвийн Ерөнхийлөн Захирагч бүрийн ирүүлсэн санал дээр үндэслэн Монгол Улсын 2025 оны төсвийн тухай хуулийн хавсралт 1-ийг боловсрууллаа.

Монгол улсын Засгийн газрын тухай хуульд 2024 онд орсон өөрчлөлтөөр Монгол Улсын Шадар сайд нэгээр нэмэгдэж нийт 39 ТЕЗ байгаа бөгөөд үүнээс Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга-1, Улсын Их Хурлын дарга-1, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга-14, Ерөнхий сайд-1, Монгол Улсын тэргүүн шадар-1, Монгол Улсын шадар сайд-2, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга-1, салбар хариуцсан сайд нар-18 гэсэн ТЕЗ бүрийн хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг боловсруулсан болно.

Тус хавсралтаар Төсвийн Ерөнхийлөн захирагч бүрийн хөтөлбөрийн зорилт, хүрэх үр дүн, түүний шалгуур үзүүлэлтийг суурь он болон түвшин, 2025 оны зорилтот түвшнийг батлуулахаар өргөн барьсан болно.

Төсвийн Ерөнхийлөн захирагч бүрээр авч үзвэл төсвийн хөтөлбөр 103, хөтөлбөрийн үр дүн 234, үр дүнд хүрэх 481 шалгуур үзүүлэлт болон түүний 2025 онд хүрэх зорилтот түвшнийг тус бүр тодорхойлсныг хүснэгтээр харуулав.

Хүснэгт 28. ТЕЗ-ийн хавсралт-1. 2025 он

№	ТӨСЛИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАР	Хөтөлбөр	Үр дүн	Шалгуур үзүүлэлт	Зорилтот түвшин
1	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	2	4	5	5
2	МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	1	3	11	11
3	МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	1	1	3	3
4	УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	1	1	1	1
5	ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	1	1	1	1
6	ШҮҮХИЙН САХИЛГЫН ХОРООНЫ ДАРГА	1	1	1	1
7	ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	1	8	8	8
8	УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	1	3	3	3
9	МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	1	1	3	3
10	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР	1	2	9	9
11	АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	1	4	8	8
12	САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	1	4	4	4
13	ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	1	10	32	32
14	ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	1	6	11	11
15	СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	1	4	6	6
16	ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ КОМИССЫН ДАРГА	1	3	5	5
17	МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	3	15	22	22
18	МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД БӨГӨӨД ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН САЙД	3	4	8	8
19	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД /ОНЦГОЙ БАЙДЛЫН АЛБА ХАРИУЦСАН/	4	5	18	18
20	МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД /ХА, ХО, ӨРСӨЛДӨӨН ХАРИУЦСАН/	1	3	3	3
21	ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	2	2	2	2
22	БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН САЙД	7	17	52	52
23	ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	4	5	8	8
24	САНГИЙН САЙД	1	2	9	9
25	ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	14	26	58	58
26	ЗАМ ТЭЭВРИЙН САЙД	4	10	20	20
27	БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	1	1	1	1
28	БОЛОВСРОЛЫН САЙД	7	11	25	25
29	АЖ ҮЙЛДВЭР, ЭРДЭС БАЯЛГИЙН САЙД	1	6	15	15
30	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	8	12	22	22
31	ГЭР БҮЛ, ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН САЙД	6	13	21	21
32	ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	4	7	15	15

33	ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	1	5	5	5
34	ХОТ БАЙГУУЛАЛТ, БАРИЛГА, ОРОН СУУЦЖУУЛАЛТЫН САЙД	2	6	9	9
35	СОЁЛ, СПОРТ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, ЗАЛУУЧУУДЫН САЙД	7	13	19	19
36	ЦАХИМ ХӨГЖИЛ, ИННОВАЦ, ХАРИЛЦАА ХОЛБООНЫ САЙД	1	4	11	11
37	МОНГОЛ УЛСЫН САЙД, БООМТЫН СЭРГЭЛТИЙН ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	1	3	5	5
38	МОНГОЛ УЛСЫН САЙД, 20 МИНУТЫН ХОТ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	3	4	7	7
39	МОНГОЛ УЛСЫН САЙД, ХЯНАЛТ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСНИЙ ХОРООНЫ ДАРГА	1	4	15	15
НИЙТ		103	234	481	481



**МОНГОЛ УЛСЫН ДУНД
ХУГАЦААНЫ ТӨСВИЙН
ТААМАГЛАЛЫН
ТАЙЛАН
2025-2027 он**

**Дунд хугацааны төсвийн хүрээний
мэдэгдлийн төслийг боловсруулахад
баримтлах макро эдийн засгийн
үндсэн үзүүлэлт, төлөв байдлын
таамаглал боловсруулах ажлын
хүрээнд бэлтгэв**

**Төсвийн тогтвортой байдлын
зөвлөл**

2024 оны 3 дугаар сарын 15-ны өдөр

АГУУЛГА

УДИРТГАЛ	4
НЭГ. ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН НӨХЦӨЛ, ТӨЛӨВ	6
1.1. Дэлхийн улс төр, геополитикийн өнөөгийн нөхцөл байдал.....	6
1.2. Олон улсын геополитикийн нөхцөл байдлаас үүдсэн Монгол Улсын гадаад эдийн засгийн орчин нөхцөл	7
1.3. Дунд хугацаанд БНХАУ болон ОХУ-ын эдийн засаг, зах зээлд гарч болзошгүй өөрчлөлтүүд	9
1.4. Уур амьсгалын өөрчлөлтийн хандлага, түүнээс үүдэн Евроазийн бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлт, сөрөг үр дагавар	10
1.5. Монгол Улсын гадаад худалдаа, макро эдийн засагт дунд хугацаанд үзүүлж болзошгүй нөлөөлөл.....	14
ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ	15
2.1. Макро эдийн засгийн нөхцөл байдал.....	15
2.2. Нэгдсэн төсвийн төлөв байдал	20
2.3. Мөнгөний сектор буюу мөнгөний бодлого.....	23
ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЦААШДЫН ТӨЛӨВ, УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛ.....	25
3.1. Эдийн засгийн өсөлтийн тогтворгүй байдал	25
3.2. Эдийн засгийн бүтэц	26
3.3. Гадаад худалдаа, эрдсийн бүтээгдэхүүний үнэ	27
3.4. Төсвийн голлох эрсдэл.....	31
ДӨРӨВ. ЭДИЙН ЗАСГИЙН ТААМАГЛАЛ, ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ	35
4.1. Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд.....	35
4.2. Таамаглал боловсруулсан аргачлал	36
4.3. DIGNAR загварын тохируулга ба экзоген хувьсагчдын төсөөлөл	44
4.4. NRG1-FSC24 загварт ашигласан уул уурхайн салбараас төвлөрөх төсвийн орлогын төсөөлөл	51
4.5. Макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, 2025-2027 оны таамаглал	52
ЭХ СУРВАЛЖ	56
ХАВСРАЛТ	58

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Монгол Улсын 2023 оны эдийн засгийн өсөлт, ДНБ-д салбаруудын эзлэх хувь, оролцоо	10
Зураг 2. Дэлхийн дундаж температурын өөрчлөлт (1850-1900 оны дундажтай харьцуулсан) ...	11
Зураг 3. Дэлхийн гадаргын температурын өөрчлөлт (1991-2020 оны дундаж температурт орсон өөрчлөлт)	11
Зураг 4. Эх газар, далай тэнгисийн температур, 2024 оны 1 дүгээр сарын дунджаар	12
Зураг 5. 2024 оны 1 дүгээр сарын хуурай газрын хур тунадасны хувь	12
Зураг 6. Эдийн засгийн бодит өсөлт, хувиар	15
Зураг 7. ДНБ эцсийн ашиглалтын аргаар, жилээр, сая төгрөгөөр	16
Зураг 8. ДНБ-ний өсөлт ба уул уурхайн болон уул уурхайн бус салбарын ДНБ-д эзлэх хувийн жин, 2019-2023 оны жилийн эцсийн байдлаар	16
Зураг 9. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлийн хэмжээ, тэрбум төгрөгөөр, 2021-2023 оны байдлаар	17
Зураг 10. Дэлхийн банкны атлас аргаар тооцсон нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээ (ам.доллар), ДНБ-ийн бодит өсөлтийн хэмжээ (хувиар).....	17
Зураг 11. Гадаад худалдааны 2021-2023 оны нийт эргэлт, тэнцэл, сая ам.доллараар	18
Зураг 12. Экспортын хэмжээ (сая ам.доллар), экспортын жилийн өөрчлөлт (хувиар)	18
Зураг 13. Экспортын хэмжээнд гадаад худалдааны түншлэгч орнуудын эзлэх хувь	19
Зураг 14. Импортын хэмжээ, сая ам.доллараар	19
Зураг 15. Импортын хэмжээнд гадаад худалдааны түншлэгч орнуудын эзлэх хувь	20
Зураг 16. Улсын нэгдсэн төсвийн 2020-2023 оны тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлага, тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төгрөгөөр	20
Зураг 17. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021-2023 оны тэнцвэржүүлсэн орлого, татварын болон татварын бус орлого, тэрбум төгрөгөөр.....	21
Зураг 18. Нэгдсэн төсөвт 2021-2023 онд төвлөрсөн татварын орлого, нэр төрлөөр, тэрбум төгрөгөөр.....	21
Зураг 19. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019-2023 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүн, тэрбум төгрөг.....	22
Зураг 20. Монгол Улсын нийт болон Засгийн газрын гадаад өр (2017-2023 оноор), сая ам.доллараар	23
Зураг 21. Мөнгөний нийлүүлэлт (2019-2023 он), сая төгрөг	23
Зураг 22. ДНБ-ий өсөлт, Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн өсөлт, Уул уурхайн салбарт оруулсан ГШХО	25
Зураг 23. Эдийн засагт голлох салбаруудын эзлэх хувь.....	26
Зураг 24. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, уул уурхайн олборлолт, оны үнээр	27
Зураг 25. БНХАУ-ын нүүрсний импорт, улсаар	28
Зураг 26. Хятадын нүүрсний импортод 2023 онд сар бүр гарсан өөрчлөлт, гарал үүслээр.....	28
Зураг 27. Нүүрсний экспортын өсөлтийн шалтгаан.....	29
Зураг 28. Коксжих нүүрсний 2023-2027 оны таамаглал, төрлөөр	29
Зураг 29. Дэлхийн банкнаас гаргасан зэсийн үнийн таамаглал	30
Зураг 30. Коксжих нүүрсний хэрэглээний 2023-2026 оны өөрчлөлт, бүс нутгаар	30
Зураг 31. Дэлхийн эрчим хүчний эрэлт, эх үүсвэрийн өөрчлөлт, 2022-2026 он	31
Зураг 32. Төсвийн орлогод уул уурхайн салбарын орлогын эзлэх хувь	32
Зураг 33. Төсвийн зарлага, орлого, тэнцэл	32
Зураг 34. Төсвийн тэнцлийн бодлогын хэрэгжилт.....	33
Зураг 35. Эдийн засаг дахь төрийн оролцоо, хувиар	33
Зураг 36. Зэсийн баяжмал, мян.тн	41
Зураг 37. Төмрийн хүдэр, мян.тн	41

Зураг 38. Алт, тн.....	41
Зураг 39. Нүүрс, мян.тн	42
Зураг 40. Нүүрсний үнэ, ам.доллар/тн	42
Зураг 41. Зэсийн үнэ, ам.доллар/тн.....	43
Зураг 42. Төмрийн хүдрийн үнэ, ам.доллар/тн	43
Зураг 43. Алтны үнэ, ам.доллар/тн	43
Зураг 44. Засгийн газрын хөрөнгө оруулалтын төсөөлөл (2024-2026).....	47
Зураг 45. Засгийн газрын хэрэглээний төсөөлөл (2024-2026).....	48
Зураг 46. Засгийн газрын шилжүүлэг (халамж зардал)-ийн төсөөлөл (2024-2026)	48
Зураг 47. Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн төсөөлөл (2024-2026)	49
Зураг 48. Ажилчдад олгох мөнгөн гуйвуулгын төсөөлөл (2024-2026)	49
Зураг 49. Экспортын төсөөлөл (2024-2026), улирлаар	50
Зураг 50. Ажиллах хүчний оролцооны түвшний төсөөлөл (2024-2026)	50

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. ОХУ-ын 2024-2026 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл.....	7
Хүснэгт 2. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас Азийн бүс нутгийн орнуудын газар тариалангийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн таамаглал, таримал ургамлын төрөл зүйлээр, улс орноор.....	13
Хүснэгт 3 Эрчим хүчний импорт.....	27
Хүснэгт 4. Нүүрсний олборлолтын хэмжээ, мянган тонн	28
Хүснэгт 5. Төсөвт 2014-2023 онд төвлөрүүлсэн уул уурхайн салбарын татварын орлого, тэрбум төгрөгөөр (татварын төрлөөр).....	31
Хүснэгт 6. Сонгосон загваруудын мэдээлэл.....	37
Хүснэгт 7. Зэсийн баяжмалын олборлолт: ARIMA (3, 4).....	39
Хүснэгт 8. Алтны олборлолт: ARIMA (3, 2).....	39
Хүснэгт 9. Төмрийн хүдрийн олборлолт: ARIMA (4, 4)	40
Хүснэгт 10. Нүүрсний олборлолт: ARIMA (3, 3)	40
Хүснэгт 11. Гардинерийн жагсаалт болон ТТБЗ-ийн таамаглал	44
Хүснэгт 12. Үндэсний тооцооны хэсгийн тохируулга.....	45
Хүснэгт 13. Бодит хүүгийн хэсгийн тохируулга	45
Хүснэгт 14. Бүтцийн параметрийн хэсгийн тохируулга.....	46
Хүснэгт 15. Төсвийн болон байгалийн нөөцийн салбарын хэсгийн тохируулга	46
Хүснэгт 16. Уул, уурхайн салбар орлого, татварын төрлөөр.....	51
Хүснэгт 17. DIGNAR загварын төсөөлөл.....	52
Хүснэгт 18. NRG1-FSC24 загварын тооцоолол	53

ХАВСРАЛТ

Хавсралт 1. ДНБ, эдийн засгийн салбарын ангиллаар (2022, 2023 он).....	58
--	----

УДИРТГАЛ

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 8.1.2 дахь заалт, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 12.4, 16 1.1 дэх заалтын дагуу Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөл төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалыг боловсрууллаа.

Макро эдийн засгийн DIGNAR-19 загвар, Байгалийн нөөцийн Засаглалын хүрээлэнгийн боловсруулсан NRG1 загварыг ашиглан тооцооллыг 2 хувилбараар гаргасан. Харьцангуй богино цаг хугацаанд тооцооллыг хийсэн тул загварт ашиглах тоон мэдээллийг хангалттай хэмжээнд бүрэн цуглуулах боломж хязгаарлагдмал байсан гэдгийг тэмдэглэх хэрэгтэй.

Монгол Улсын гадаад худалдааны эргэлт болон эдийн засгийн өсөлт сүүлийн 3 жилийн туршид харьцангуй өндөр өсөлттэй байгаа тул загвараар тооцоолол хийхэд энэхүү хандлага нөлөө үзүүлж, загварын үр дүнгээр илүү өөдрөг үр дүн гарах магадлалтай байна. Харин бодит байдал дээр олон улсын түвшинд улс төр, геополитикийн нөхцөл байдал хурдтай өөрчлөгдөж байгаа, улс орнуудын талцал хуваагдал нэмэгдэж байгаа, уур амьсгалын өөрчлөлтийн улмаас байгалийн гамшигт болон аюулт үзэгдлийн тоо, давтамж нэмэгдэж, учирч буй хохирол нэмэгдэж байгаа, манай худалдааны гол түнш БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн хурд саарч байгаа зэрэг бодит хүчин зүйлсийн нөлөөлөл, эрсдэл оршиж байгаа нь тодорхой байгаа тул шууд загвараас гарсан үр дүнг оновчтой таамаглал гэж үзэх нь ерөөсгөл болно.

Иймээс Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн харилцааг зохицуулж байгаа хууль тогтоомжийн заалтууд, дээр дурдсан бодит эрсдэлүүдийг тооцон үзсэний үндсэн дээр 2025-2027 оны макро эдийн засгийн үзүүлэлтүүдийн дээд хязгаарыг боловсруулан үүгээр хүргүүлж байна.

Өнгөрсөн жилүүдэд төрөөс эдийн засгийн өсөлт, гадаад худалдааны өндөр зорилтууд тавьж хэрэгжүүлж ирсэн, бодит байдал дээр урьдчилан таамаглах боломжгүй, биднээс үл хамаарах ковидын цар тахал, геополитикийн огцом өөрчлөлт, ОХУ-ын эсрэг тогтоосон эдийн засгийн хориг арга хэмжээ, хилийн боомтууд дээр үүсч байсан тасалдал, саатал, өвөлжилтийн хүндрэл, ган зуд зэрэг олон талын эрсдэлт хүчин зүйлийн улмаас тэдгээр зорилтод хүрэх боломжгүйд хүрч байсан. Иймээс бид ойрын хугацааны бус, дунд хугацааны эдийн засгийн өсөлтийн төсөөллийг боловсруулахдаа бусад улс орнуудын сайн туршлага, жишгээр өөдрөг ба суурь хувилбар гэсэн хувилбартай байдлаар боловсруулах шаардлагатай гэж үзлээ.

Монгол Улсын хувьд 2023 онд эдийн засгийн өсөлт 7 хувьд, экспорт 15.0 тэрбум ам.долларт хүрч, гадаад худалдааны тэнцэл 5.9 тэрбум ам.долларын ашигтай, төлбөрийн тэнцлийн урсгал данс ашигтай, улсын төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан зэрэг харьцангуй тааламжтай жил байлаа. Харин энэ таатай нөхцөл байдал, хандлага ирэх жилүүдэд хэвээр хадгалагдана гэж төсөөлөх, найдах аргагүй юм.

Хэдийгээр Монгол Улсын хувьд олборлож буй түүхий эдийн биет хэмжээг нэмэгдүүлэх боломжтой хэдий ч экспортыг өсгөн нэмэгдүүлэхэд зөвхөн нийлүүлэлт бус, түүхий эдийн гол худалдан авагч болох БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл байдал, эрэлт, тус улсын зах зээлд ижил төрлийн түүхий эдийг нийлүүлж буй улс орнуудын өрсөлдөөн, дэлхийн зах зээл дэх түүхий эдийн үнэ, ханшийн өөрчлөлт зэрэг олон талын хүчин зүйл нөлөөлөх болно.

Иймд ирэх жилүүдэд улс төр, эдийн засаг, гадаад орчны ямар нэгэн эрсдэл тулгарсан ч гэсэн эдийн засгийн өсөлт болон бусад үзүүлэлтийн хувьд 2023 оны хүрсэн түвшингээс бууруулахгүй байх эдийн засгийн бодлогыг УИХ, Засгийн газрын зүгээс бодож, төлөвлөх, эрсдэл үүссэн нөхцөлд түүнд хэрхэн шуурхай хариу үзүүлэх, ямар арга замаар эрсдэлийг бага хохиролтой, богино хугацаанд даван туулах төлөвлөгөөтэй байх шаардлагатай.

Дэлхийн зах зээлд болон байгаль орчинд урьдчилан төсөөлөөгүй өөрчлөлт гарсан тохиолдолд Монгол Улсын эдийн засгийг хүндрэл, хямралд хүргэхгүй байх, эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогыг төрөөс баримталж, хэрэгжүүлэх үүрэгтэй. Ийм ч учраас Монгол Улсын Үндсэн хуулийн 25.1.7-д Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлт тогтвортой байх, Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлд төсвийн тусгай шаардлага, хуулийн 19.3, 19.9 дэх заалтад улсын төсвийн үзүүлэлтийн дээд хязгааруудыг тодорхой зааж өгсөн байдаг.

Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөл нь холбогдох хуулиар хүлээсэн үүргийн дагуу дээрх хуулиудад заасан тусгай шаардлага, хязгаарын хүрээнд Монгол улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл болон төсвийн хязгаарын төсөөллийг боловсруулсан байх ёстой гэж үзэж байна.

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТ, ТӨЛӨВ БАЙДЛЫН ТААМАГЛАЛ

№	Макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүд	Дээд, доод утга	Төлөв байдлын таамаглал		
			2025 он	2026 он	2027 он
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	Дээд	6.71	7.69	7.61
		Доод	3.07	4.05	3.97
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	Дээд	8.00	8.00	8.00
		Доод	6.95	6.39	6.33
3	Нэгдсэн төсвийн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	Дээд	26,170.20	28,360.00	31,123.20
		Доод	24,323.05	26,624.14	29,220.38
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Дээд	25.91	24.45	23.40
		Доод	24.08	22.95	21.97
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	Дээд	27,774.00	30,946.30	34,353.50
		Доод	25,814.58	29,054.49	32,253.56
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Дээд	27.50	26.68	25.83
		Доод	25.56	25.05	24.25
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	Дээд	413.50	3,172.30	3,407.20
		Доод	384.31	2,978.13	3,198.89
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Дээд	0.41	2.73	2.56
		Доод	0.38	2.57	2.41
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	Дээд	-2,020.00	-2,320.00	-2,660.00
		Доод	-2,020.00	-1,740.00	-1,330.00
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Дээд	(2.00)	(2.00)	(2.00)
		Доод	(2.00)	(1.50)	(1.00)
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	Дээд	4,999.82	6,805.67	8,764.44
		Доод	4,646.92	6,389.11	8,228.59
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Дээд	4.95	5.87	6.59
		Доод	4.60	5.51	6.19
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	Дээд	60,600.00	69,600.00	79,800.00
		Доод	55,550.00	60,900.00	66,500.00
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Дээд	60.00	60.00	60.00
		Доод	55.00	52.50	50.00
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	Дээд	2,727.00	3,132.00	3,591.00
		Доод	2,525.00	2,668.00	2,793.00
	Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	Дээд	2.70	2.70	2.70
		Доод	2.50	2.30	2.10

НЭГ. ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН НӨХЦӨЛ, ТӨЛӨВ

Гадаад эдийн засаг, геополитик, геоздийн засгийн орчин, өнөөгийн нөхцөл, 2024-2025 оны төлөв байдлыг дараах чиглэлээр тоймлов. Үүнд:

- Дэлхийн улс төр, геополитикийн өнөөгийн нөхцөл байдал
- Олон улсын геополитикийн нөхцөл байдлаас үүдсэн Монгол Улсын гадаад эдийн засгийн орчин нөхцөл
- Дунд хугацаанд БНХАУ болон ОХУ-ын эдийн засаг, зах зээлд гарч болзошгүй өөрчлөлтүүд
- Уур амьсгалын өөрчлөлтийн хандлага, түүнээс үүдэн Евроазийн бүс нутагт гарч болзошгүй өөрчлөлт, түүний сөрөг үр дагавар
- Монгол Улсын гадаад худалдаа, макро эдийн засагт үзүүлж болзошгүй нөлөөлөл

1.1. ДЭЛХИЙН УЛС ТӨР, ГЕОПОЛИТИКИЙН ӨНӨӨГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Орос-Украины дайн

2022 оны 2 дугаар сараас хойш өнөөг хүртэл үргэлжилж буй Орос-Украины дайны улмаас дэлхий дахины улс төр, геополитик, худалдаа, эдийн засгийн харилцаанд томоохон өөрчлөлт гарч байна. Энэхүү дайнаас шалтгаалан зөвхөн ОХУ төдийгүй АНУ, НАТО-гийн гишүүн орнууд, Австрали, Япон, Өмнөд Солонгос, БНХАУ зэрэг хүчирхэг арми бүхий олон улс орон батлан хамгаалах зардлаа ихээхэн хэмжээгээр нэмэгдүүлж байна.

Өрнөдийн орнуудын зүгээс ОХУ, Беларусь улсын эсрэг тогтоосон олон удаагийн эдийн засгийн хориг арга хэмжээний улмаас Европ болон ОХУ-ын хоорондын худалдаа, зорчигч болон ачаа тээврийн харилцаа бүхэлдээ тасалдсан юм. Олон улсын цэрэг, улс төрийн шинжээчдийн үзэж буйгаар Орос-Украины дайн цаашид 1-2 жилийн хугацаанд үргэлжлэх өндөр магадлалтай гэж таамаглаж байна.

Израиль-Хамасын мөргөлдөөн, Улаан тэнгист болж буй халдлага худалдааны логистикт үзүүлж буй нөлөөлөл

Израиль улс болон Хамасын бүлэглэлийн хооронд олон сарын туршид үргэлжилж буй мөргөлдөөн, Улаан тэнгисээр зорчиж буй олон улсын ачаа тээврийн хөлөг онгоцууд руу Хуситын дээрэмчдийн бүлэглэлийн зүгээс удаа дараа халдаж байгаагийн улмаас Ази-Европын хоорондын олон улсын далайн тээврийн үйл ажиллагаа тасалдаж, доголдон тээвэрлэлтийн өртөг, зардал ихээхэн нэмэгдэж байна.

ОХУ-ын эсрэг АНУ, Европын Холбооны зүгээс тогтоосон хориг, НАТО-гийн өргөжин тэлэлт

Өнгөрсөн хоёр 2 жилийн хугацаанд Скандинавын хойгт орших Финланд, Швед улс Умард Атлантын Цэргийн Эвсэлийн гишүүнээр элсэн орсноор тус Эвсэлийн гишүүдийн тоо 32 улс болж өргөжин НАТО-гийн гишүүн орнууд ОХУ-ын хоорондын хилийн урт ихээхэн хэмжээгээр нэмэгдлээ. Энэ бүхэн нь Европ тивд сөргөлдөөнт байдлыг улам бүр хурцатгах, дээрх хилийн зурвасын дагуу цэрэг, армийн төвлөрлийг бий болгох, цаашдын сөргөлдөөний нэг эрсдэлтэй бүс нутаг болж хувирах магадлалыг улам бүр нэмэгдүүлж байна. Өөрөөр хэлбэл, дэлхий дахинд үүсээд буй талцал хуваагдмал байдал цаашид улам бүр гүнзгийрэх магадлалтай гэж олон улсын шинжээчид үзэж байна.

ОХУ болон БНХАУ-ын түншлэл, нягт харилцаа

Дээр дурдсан шалтгаануудын улмаас ОХУ болон БНХАУ-ын хоорондын харилцаа улам бүр ойртон нягтарч худалдаа, эдийн засгийн төдийгүй цэрэг, улс төрийн хувьд ч харилцаагаа гүнзгийрүүлж байна. ОХУ-ын зүгээс Европын зах зээлд гаргах боломжгүй

болсон газрын тос, шатдаг хий, нүүрс зэрэг түүхий эдийг Азийн зах зээлд чиглүүлж БНХАУ, Энэтхэг улсад их хэмжээгээр нийлүүлэх болсон юм. Өнгөрсөн 2023 оны байдлаар ОХУ болон БНХАУ-ын хоорондын гадаад худалдааны эргэлт 220.0 тэрбум ам.долларт хүрчээ. ОХУ-ын зүгээс Эрхүү, Өвөр Байгал, Буриад, Саха улсын нутаг дахь ашигт малтмалын орд газруудаас олборлож буй шатдаг хий, газрын тос, нүүрсний олборлолт, экспортыг ихээхэн нэмэгдүүлж, цаашид Хятад улсын зах зээлд улам ихээр нийлүүлэх яриа хэлэлцээ хийж байна.

АНУ болон БНХАУ-ын хоорондын харилцаа, олон талын өрсөлдөөн

Эдийн засгийн цар хэмжээгээр дэлхийд тэргүүлж байгаа АНУ болон хоёрдугаарт жагсаж буй БНХАУ-ын хоорондын харилцаа, өрсөлдөөн нь дэлхийн эдийн засагт хүчтэй нөлөө үзүүлж ирсэн юм. Улс төр, геополитик, гадаад худалдаа зэрэг олон талын шалтгааны улмаас АНУ болон БНХАУ-ын хооронд тодорхой зөрчил, өрсөлдөөн өрнөсөөр байгаа билээ. Өнгөрсөн жилүүдэд эдгээр хоёр улсын хоорондох худалдааны дайн намжсан боловч сүүлийн жилүүдэд технологийн өрсөлдөөн улам бүр ширүүсч байна.

Өнгөрсөн 2022 онд АНУ-ын Конгрессоос “Хагас дамжуулагчийн тухай 2022 оны хууль”-ийг батлан гаргасан. Энэ хуулийн дагуу АНУ-ын технологийн компаниуд БНХАУ-ын технологийн салбарт хөрөнгө оруулалт хийхийг хориглож, хагас дамжуулагч үйлдвэрлэх өндөр хүчин чадлын хэвлэгч машиныг БНХАУ-д нийлүүлэхийг зогсоожээ. Энэ хуультай мөн адил утга агуулга бүхий хуулийг Европын Парламентаас баталсан юм. Эдгээр хуульд нийцүүлэн Нидерланд улсын Парламентаас хагас дамжуулагч хэвлэгч машиныг үйлдвэрлэдэг цорын ганц гэж хэлж болох AMSL компанид үйлдвэрлэж буй өндөр технологийн лазераар хэвлэгч машиныг БНХАУ-д нийлүүлэхийг хоригложээ.

Саяхан АНУ-ын Конгрессын зүгээс АНУ-ын компаниудыг Хятадын биотехнологийн салбарт хөрөнгө оруулалт хийх, хамтран ажиллахыг хориглосон хуулийг хэлэлцэн батлаад байна. АНУ болон БНХАУ-ын хооронд өрнөж байгаа олон талын сөргөлдөөн, зөрчлийн улмаас дэлхийн худалдаа, эдийн засгийн эргэлт удааших, БНХАУ-ын экспорт буурах, улмаар тус улсын эдийн засгийн өсөлт саарах ч нөлөө үзүүлж болзошгүй гэж судлаачид үзэж байна.

1.2. ОЛОН УЛСЫН ГЕОПОЛИТИКИЙН НӨХЦӨЛ БАЙДЛААС ҮҮДСЭН МОНГОЛ УЛСЫН ГАДААД ЭДИЙН ЗАСГИЙН ОРЧИН НӨХЦӨЛ

Энэ хүрээнд ОХУ-ын Ази-Номхон далайн бүсэд чиглэсэн геоэдийн засгийн бодлого, ОХУ-ын түүхий эдийн экспорт, дэд бүтцийн цаашдын хөгжил, БНХАУ ба Австрали, БНХАУ ба АСЕАН-ны худалдаа, эдийн засгийн харилцааны талаар авч үзлээ.

Хүснэгт 1. ОХУ-ын 2024-2026 оны төсвийн үндсэн үзүүлэлтүүдийн төсөөлөл

	Хэмжих нэгж	2024 оны төсөл	2025 оны төсөл	2026 оны төсөл
1. Төсвийн нийт орлого	тэрбум рубль	36,065.0	33,552.3	34,050.9
2. Төсвийн нийт зарлага	тэрбум рубль	36,660.7	34,382.8	35,587.4
3. Төсвийн нийт тэнцэл	тэрбум рубль	1,595.4	830.5	1,536.4
4. Нийт дотоод өрийн дээд хязгаар	тэрбум рубль	26,637.4	30,159.3	34,356.5
5. Нийт гадаад өрийн дээд хязгаар	тэрбум ам. доллар	\$64.0	\$63.1	\$61.2
6. ДНБ-ийн хэмжээ	их наяд рубль	171,956	190,637	202,304
7. ДНБ-ийн өсөлтийн хувь	хувь	2.3	2.3	2.2
8. Төсвийн алдагдлын ДНБ-д эзлэх хувь хэмжээ	хувь	0.93	0.43	0.76

Жич: ОХУ-ын ДНБ 2023 онд 3.6 хувиар өсч 171,041.0 тэрбум рубльд хүрсэн.

Эх сурвалж: ОХУ-ын Сангийн Яам, ЭЗХЯ, www.minfin.gov.ru, www.economy.gov.ru

Өрнөдийн орнуудын зүгээс ОХУ-ын эсрэг тогтоосон олон удаагийн хориг арга хэмжээний улмаас тус улсын экспортын орлого буурч, гадаадын хөрөнгө оруулалт эрс татарсан. Дайны үйл ажиллагаа хоёр жилийн туршид үргэлжилж байгаа тул ОХУ батлан хамгаалах салбарын зардлыг ихээхэн нэмэгдүүлснээс шалтгаалан өнгөрсөн жилүүдэд ашигтай гарч байсан тус улсын төсвийн тэнцэл 2024 онд 1,595.0 тэрбум рубльд хүрч нэмэгдэхээр байна.

Тус улс төсвийн алдагдлаа нөхөх зорилгоор ашигт малтмалын салбарын бүх төрлийн татварыг нэмэгдүүлж байгаа бөгөөд энэ оны 3 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн экспортод гаргаж буй нүүрсний татварыг сэргээн мөрдүүлэхээр болсон. Нүүрсний экспортын татвар нь рубль ба ам.долларын ханшийн өөрчлөлтөөс хамаарч 4-7 хүртэл хувийн татварыг ногдуулахаар шийдвэрлэжээ.

Энэ оны 3 дугаар сарын 15-17-ны өдрүүдэд болох ОХУ-ын Ерөнхийлөгчийн сонгуулийн дараа ОХУ-ын Засгийн газраас аж ахуйн нэгж, байгууллагын болон хүн амын орлогын албан татварыг шатлалтайгаар өсгөн нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа талаар олон улсын болон Оросын хэвлэл мэдээлэлд нийтэлж байна.

Ийнхүү ОХУ-д энэ оноос мөрдүүлж буй болон мөрдүүлэх татварын өөрчлөлтийн үр дүнд ОХУ-ын эдийн засаг, экспортод ямар өөрчлөлт гарах талаар илүү нарийвчлан судалж үзэх шаардлагатай. ОХУ-аас Хятад улсад 2023 онд гаргасан 100.0 сая тонн нүүрсний 60 орчим хувийг металлургийн нүүрс эзэлж байгаа тул энэ онд ОХУ-аас нийлүүлэх нүүрсний хэмжээ, үнэ зэргээс хамаарч Монгол Улсаас Хятадад нийлүүлэх нүүрсний эрэлтэд тодорхой хэмжээний өөрчлөлт гарч болзошгүй тул бид анхааралтай ажиглаж, судалж байх шаардлагатай.

ОХУ-д төв Засгийн газрын төсвийн алдагдлаас гадна холбооны субъектуудын төсвийн алдагдал ихээхэн нэмэгдэж байна. Нийт муж улсуудын төсвийн алдагдлын нийлбэр дүн 2023 онд 200.0 тэрбум рубльд хүрсэн бол 2024 онд 400.0 тэрбум рубльд хүрч болзошгүй гэж тус улсын судлаачид үзжээ. ОХУ-ын төрийн өмчит үйлдвэрийн газруудын ногдол ашгийн дүн 2022 онд 753.0 тэрбум рубльд хүрсэн бол 2023 онд 282.5 тэрбум рубль болж 62 хувиар буурчээ.

ОХУ-ын зүгээс Хятад улсад удаа дараа өндөр түвшний айлчлал хийж, газрын тос, шатдаг хий, нүүрсний нийлүүлэлтийн гэрээг нэг болон хэд хэдэн жилээр байгуулж байгаа тул ОХУ-ын экспортлогч компаниуд Хятадын зах зээлд илүү давуу талтай байна. ОХУ-ын “ЭЛСИ” групп Саха улсын нутагт орших Эльгийнскийн коксжих нүүрсний томоохон орд газрыг эзэмшиж байгаа бөгөөд тус ордоос жилдээ 20.0-25.0 сая тонн нүүрс олборлож, экспортолж байна. 2022 оноос эхлэн тус компани Эльгийнскийн орд газраас Номхон далайн Агнуурын тэнгис тийш дөт замаар далайн гарцтай болох зорилгоор 514 км урттай шинэ төмөр зам, Агнуурын тэнгист Чумикан гэсэн томоохон хүчин чадал бүхий далайн боомтыг байгуулж эхэлжээ.

Эдгээр төмөр зам, далайн боомтыг 2025 оны 1 дүгээр улиралд ашиглалтад оруулах төлөвлөгөөтэй, ажлын явц хурдацтай байна. Энэ төмөр зам, боомтыг ашиглалтад оруулснаар Эльгийнскийн ордоос экспортод гаргах нүүрсний хэмжээ 2025 оноос эхлэн жилдээ 30.0 сая тонноос дээш өсөх, төмөр замын тээвэрлэлтийн өртөг зардал, зарцуулах цаг хугацаа буурах төлөвтэй байна.

Орос-Украины дайн, Өрнөдийн орнуудын хориглоос үүдэн эдийн засгийн хүндрэлтэй тулгарч байгаа ОХУ-ын хувьд БНХАУ, Энэтхэг улсад гаргах түүхий эдийн экспортыг нэмэгдүүлэхийн тулд төр, засгаас нь бүхий л талаар хүчин чармайлт тавьж, ихээхэн хүч, хөрөнгө зарцуулж байгаа гэдгийг бид анхаарах шаардлагатай.

1.3. ДУНД ХУГАЦААНД БНХАУ БОЛОН ОХУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ, ЗАХ ЗЭЭЛД ГАРЧ БОЛЗОШГҮЙ ӨӨРЧЛӨЛТҮҮД

Энэ хэсэгт БНХАУ-д тулгарч байгаа эдийн засаг, санхүүгийн хүндрэл, Хятадын хоёр Их хурлаас дэвшүүлсэн Хятад улсын хөгжлийн бодлого, зорилтууд, ОХУ-ын эдийн засгийн 2024-2026 оны төлөв, уур амьсгалын өөрчлөлттэй тэмцэх талаарх Хятад улсын зорилт, арга хэмжээг тоймлон авч үзэв.

1990-ээд оноос хойш 30 гаруй жилийн туршид тасралтгүй өндөр өсөлттэй явж ирсэн БНХАУ-ын эдийн засгийн өсөлт сүүлийн хоёр жилд эрс саарч байна. Өнгөрсөн 2023 онд Хятад улсын эдийн засаг 5 хувиар өссөн бол 2024 онд 5 хувийн өсөлтөд хүрэх зорилтыг дэвшүүлсэн. Гэвч Хятад улсын санхүүгийн салбар, үл хөдлөх хөрөнгийн зах зээлд тулгарч буй бэрхшээлүүд улам бүр гүнзгийрч байна. Өнгөрсөн хоёр жилийн хугацаанд Хятадын үл хөдлөх хөрөнгийн томоохон компаниуд болох Евергранд (Evergrande), Коунтри Гарден (Country Garden) компаниуд дампуурлын шатандаа орсон, мөн Ванке компани (VANKE) ч дампуурах эрсдэлд ойрхон байна.

Энэ сарын 5-9-ний өдрүүдэд Бээжин хотод болсон Бүх Хятадын Ардын Төлөөлөгчдийн Их хурал, Бүх Хятадын Ардын Улс Төрийн Зөвлөлдөх Зөвлөл буюу БНХАУ-ын хоёр их хурлаар Засгийн газрын илтгэлийг сонсож, тус улсын 2024 оны хөгжлийн зорилтуудыг хэлэлцэн баталсан. Эдгээр зорилтын хүрээнд эдийн засгийн өсөлтийг 5 хувьд хүргэх, үүний дотор шинжлэх ухаан, технологийн ололт амжилт, инновац, бүтээмжид тулгуурласан эдийн засгийн өсөлтийг бий болгох, дотоодын хэрэглээг урамшуулах зэрэг зорилт дэвшүүлжээ. Тус улсын дэвшүүлэн тавьж буй эдгээр зорилт хэрхэн хэрэгжих, амжилтад хүрч чадах эсэхээс хамаарч Хятад улсын дотоодын эрэлт, хэрэглэгчдийн худалдан авалт сэргэх эсэх нь хамаарах болно.

Мөн АНУ-ын зүгээс БНХАУ-ын технологийн салбарын өсөлт, өрсөлдөөнийг хязгаарлах бодлого баримталж, АНУ-ын хөрөнгө оруулагчид болон компаниудыг Хятадын өндөр технологийн болон биотехнологийн салбарт хөрөнгө оруулалт хийхийг хориглосон, мөн Хятад улсад өндөр хүчин чадал бүхий хагас дамжуулагч, хагас дамжуулагч үйлдвэрлэх лазер хэвлэлтийн маш өндөр хүчин чадал бүхий хэвлэлтийн машиныг нийлүүлэхийг хориглосон хуулийг батлан мөрдүүлж байна. Үүний зэрэгцээ ОХУ-ын эсрэг тогтоосон АНУ, Европын Холбооны хоригийн жагсаалтад Хятадын цэрэг, аж үйлдвэрийн болон өндөр технологийн олон компани, судалгааны хүрээлэн ч хамрагдсан юм.

Энэ бүхний улмаас Хятадын Засгийн газраас дэвшүүлж буй эдийн засгийн өсөлтийн зорилт амжилтад хүрэхэд ихээхэн саад бэрхшээл учрах, үүсээд буй хүндрэлтэй асуудлууд цаашид гүнзгийрэх эрсдэл өдрөөс өдөрт нэмэгдсээр байна.

Хятад улсын байгаль орчныг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг бодлогын хэрэгжилт: Хятад улсын нүүрс хүчлийн хийн ялгаруулалт 2020-2023 онд 4.6 хувьд хүрч буурсан, зорилтот түвшинд хүрэхийн тулд 2024 онд нүүрс хүчлийн ялгаруулалтыг 7 хувиар бууруулах шаардлагатай. Анх дэвшүүлсэн зорилтоор 2021-2025 онд эрчим хүчний хэрэглээг 13.5 хувиар, нүүрсхүчлийн хийн ялгаруулалтыг 18 хувиар тус тус бууруулах ёстой.

Хятад улсын эрчим хүчний хэрэглээг 2024 болон 2025 онд тус тус 6 хувиар багасгаж бууруулж байж 2021-2025 онд 2.5 хувиас доош бууруулах зорилтдоо хүрэх боломжтой. 2023 онд хоёр хувиар бууруулах зорилт тавьсан боловч гүйцэтгэлээр дөнгөж 0.5 хувиар бууруулж чадсан байна.


1.4. УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ХАНДЛАГА, ТҮҮНЭЭС ҮҮДЭН ЕВРОАЗИЙН БҮС НУТАГТ ГАРЧ БОЛЗОШГҮЙ ӨӨРЧЛӨЛТ, СӨРӨГ ҮР ДАГАВАР

Дэлхийн цаг уурын байгууллага болон уур амьсгалын судалгаа хийж буй бусад олон улсын болон төрөлжсөн байгууллагуудын олон жилийн туршид хийсэн ажиглалт, судалгааны үр дүнд дэлхийн уур амьсгал дулаарч байна гэсэн дүгнэлт хийжээ. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас дэлхийн олон бүс нутагт хэт халалт, хэт хүйтрэлт, хүчтэй хар шуурга, аадар бороо, үер, хөрсний гулгалт зэрэг байгаль цаг уурын гаралтай гамшигт болон аюулт үзэгдлийн тоо, давтамж ихээхэн нэмэгдэж байгааг удаа дараа анхааруулсаар байна.

Уур амьсгалын өөрчлөлт нь Монгол орны цаг агаар, бэлчээр, ургамлын гарцад ч хүчтэй нөлөөлж буйг манай мэргэжлийн байгууллагууд, цаг уур, хөдөө аж ахуйн салбарын эрдэмтэд, судлаачид удаа дараагийн судалгааны үр дүн, дүгнэлтдээ тусгаж, энэ талаар анхааруулж, сэрэмжлүүлж ирсэн билээ. Өнгөрсөн 2023 оны зун Улаанбаатар хот, Төв, Сэлэнгэ, Өвөрхангай аймгийн нутгаар удаа дараа орсон аадар бороо, тохиосон үер, 2023-2024 оны өвлийн улиралд нийт нутгаар орсон ахиу цас, огцом хүйтрэлт нь 12-14 жилд нэг удаа тохиож буй байгалийн гамшигт үзэгдэл юм. Олон улсын байгууллагууд, судлаачдын гаргаж буй таамаглалаас үзвэл өвлийн улиралд хэт хүйтрэх, зуны улиралд зарим бүс нутгаар хэт халалт тохиох, үүний улмаас огцом хүчтэй аадар бороо орж, үер буух эрсдэл нэмэгдсээр байна.

Өнгөрсөн өвөл, хаврын улиралд тохиож буй зудын улмаас 2024 оны 3 дугаар сарын 10-ны өдрийн байдлаар 4.0 сая орчим толгой мал хорогдсон гэж ОБЕГ-аас мэдээлж байна. Ирэх 4-5 дугаар сард тохиох хаврын салхи шуурганы улмаас турж эцсэн мал сүрэг нэмж хорогдох магадлал маш өндөр байдаг. Иймээс өвөл, хаврын улирал өндөрлөсний дараа 2024 оны эцэст нийт малын хорогдлын тоо 2009-2010 оны зудын хохирлын хэмжээтэй дүйцэж ч болзошгүй байна. Үүнээс үүдэн өнгөрсөн онд 8.9 хувийн бууралттай гарсан хөдөө аж ахуйн салбар 2024 онд ч мөн адил ихээхэн бууралттай гарч, нийт эдийн засгийн өсөлтөд таагүй нөлөө үзүүлэх магадлал өндөр боллоо.

Зураг 1. Монгол Улсын 2023 оны эдийн засгийн өсөлт, ДНБ-д салбаруудын эзлэх хувь, оролцоо




Эх сурвалж: Үндэсний Статистикийн хороо, Нийгэм, эдийн засгийн 2023 оны урьдчилсан гүйцэтгэл

Сүүлийн 20 гаруй жилийн хугацаанд Монгол орны нутгаар олон аймаг, сумдын нутгийг хамарсан гурван ч удаагийн зуд тохиож, олон тооны мал сүрэг хорогдсон, тухайлбал, 2003-2023 оны хооронд хорогдсон нийт малын зүй бусын хорогдол 36.4 сая толгойд хүрсэн байна.

Мал аж ахуйн салбарыг цаашид байгаль цаг уурын өөрчлөлт, эрсдэлийг даван туулах чадвартай, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицсон, бэлчээрийн даацдаа тохирсон аж ахуй болгон хөгжүүлэхгүй бол жил тутамд учирч буй өвөлжилтийн хүндрэл, тодорхой давтамжтай тохиож буй зудын улмаас малчин өрхийн амьжиргаа доройтож, улмаар хөдөөгийн ядуурлыг үүсгэх гол хүчин зүйл болж байна.


Иймээс УИХ-ын сонгуулийн дараа эмхлэн байгуулагдах Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт дээрх асуудлаар тодорхой зорилтуудыг тусган хэрэгжүүлэх, малын индексжүүлсэн даатгалын хамрах хүрээг өргөжүүлэх зэрэг бодлогын олон талын арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай.

Зураг 2. Дэлхийн дундаж температурын өөрчлөлт (1850-1900 оны дундажтай харьцуулсан)



Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас дэлхийн агаарын дундаж температур улам бүр нэмэгдэж байна.


Зураг 3. Дэлхийн гадаргын температурын өөрчлөлт (1991-2020 оны дундаж температурт орсон өөрчлөлт)



Эх сурвалж: WMO Provisional State of Global Climate Report 2023.

2023 он нь сүүлийн жилүүдэд тохиосон хамгийн халуун жилүүдийн нэг болсон. 2023 оны тодорхой саруудын дэлхийн агаарын дундаж температур олон жилийн рекордыг эвдэж байгааг Дэлхийн цаг уурын байгууллагаас мэдээлж байна. 2024 оны 1 дүгээр сарын хувьд ч зарим бүс нутагт хэт халалт тохиосоор байна.


Зураг 4. Эх газар, далай тэнгисийн температур, 2024 оны 1 дүгээр сарын дунджаар



Эх сурвалж: NOAA GlobalTemp v6.0.0-20240208

2024 оны 1 дүгээр сарын байдлаар Азийн бүс нутаг, үүний дотор Монгол орны нутгаар олон жилийн дунджаас ахиу хур тунадас, цас оржээ.

Зураг 5. 2024 оны 1 дүгээр сарын хуурай газрын хур тунадасны хувь



Эх сурвалж: www.ncei.noaa.gov/access/monitoring/ghcn-gridded-products/#global-maps-select

Хүснэгт 2. Уур амьсгалын өөрчлөлтийн улмаас Азийн бүс нутгийн орнуудын газар тариалангийн салбарт учирч болзошгүй эрсдэлийн таамаглал, таримал ургамлын төрөл зүйлээр, улс орноор

Projected impacts of climate change to agriculture and food systems in sub-regions of Asia IPCC-AR5 studies



Эх сурвалж: https://www.ipcc.ch/report/ar6_wg2/chapter/chapter-10/

1.5. МОНГОЛ УЛСЫН ГАДААД ХУДАЛДАА, МАКРО ЭДИЙН ЗАСАГТ ДУНД ХУГАЦААНД ҮЗҮҮЛЖ БОЛЗОШГҮЙ НӨЛӨӨЛӨЛ

Хэдийгээр бид макро эдийн засгийн загвар ашиглан өнгөрсөн жилүүдийн тоо мэдээлэлд тулгуурлан таамаглал боловсруулж байгаа хэдий ч макро эдийн засгийн загварт үл тооцогдож буй гадаад, дотоод хүчин зүйл, эрсдэлээс хамаарч бодит үр дүн төсөөллөөс өөр үр дүнд хүрэх боломжтой. Ийнхүү нөлөөлж болзошгүй үндсэн хүчин зүйлс нь:

- Олон улсын улс төр, геополитикт гарч буй томоохон өөрчлөлт, хуваагдлын сөрөг үр дагавар;
- БНХАУ-д тулгарч байгаа эдийн засгийн хүндрэлүүд, АНУ болон Өрнөдийн орнуудын зүгээс Хятад улсын технологийн салбарт тавьж байгаа хориг хязгаарлалтуудын улмаас Хятад улсын аж үйлдвэр, технологийн салбарт өсөлт удаашрах эрсдэл;
- Уур амьсгалын өөрчлөлт, дулаарлын улмаас Монгол орны нутагт цаашид тохиох байгаль цаг уурын гамшигт болон аюулт үзэгдлийн тоо, давтамж улам бүр нэмэгдэх;
- Манай улсад хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэхээр төлөвлөж буй эрчим хүч, төмөр зам, хилийн боомтын томоохон төслүүд дотоод, гадаадын ямар нэгэн шалтгаанаар удаашрах, тасалдах эрсдэл оршиж байна.

Үүний улмаас төрөөс тавьж буй дунд, урт хугацааны хөгжлийн зорилтуудын хэрэгжилт хойшлох, удаашрах эрсдэлтэй.

Монгол Улсын макро эдийн засгийн өнгөрсөн 30 жилийн түүх, албан ёсны статистикийн тоо баримтуудаас авч үзэхэд, энэ талаар судалгаа хийсэн гадаад, дотоодын эрдэмтэд судлаачдын олон удаагийн судалгаа, шинжилгээний үр дүн, дүгнэлтээс үзэхэд Монгол Улсын эдийн засаг нь:

- Уул уурхайн салбарын үйлдвэрлэл, экспортоос хэт өндөр хамааралтай;
- Түүхий эдийн үнэ, ханшийн савалгаанаас ихээхэн хамааралтай;
- БНХАУ, үүний дотор Өвөр Монголын Өөртөө Засах орны эдийн засгийн өсөлт, түүхий эдийн эрэлтээс өндөр хамааралтай;
- Байгаль цаг уурын нөхцөл байдал, уур амьсгалын өөрчлөлтөөс мал аж ахуй, газар тариалангийн салбар хамааралтай, нэн эмзэг;
- Хөрш орнуудтай холбогдож буй дэд бүтцийн хөгжил сул зэрэг олон талын эрсдэл, сул талуудтай байна.

Иймээс бид макро эдийн засгийн дунд хугацааны төсөөллийг боловсруулахдаа зөвхөн макро эдийн засгийн загвараас гарсан үр дүнг шууд авч ашиглах нь учир дутагдалтай, өнөөгийн гадаад эдийн засаг, геополитикийн, өөрчлөгдөж буй байгаль цаг уурын нөхцөл байдал зэрэг олон талын үзүүлэлтийг харгалзан үзэж байж макро эдийн засгийн таамаглалыг хэд хэдэн хувилбараар боловсруулах шаардлагатай байна.

ХОЁР. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

2.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдал сүүлийн хоёр жилийн хугацаанд дэлхийн нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын дараа сэргэсэн хэдий боловч бодит эдийн засагт уул уурхайн салбарын эзлэх хувийн жин өндөр хэвээр, эдийн засгийн өсөлт уул уурхайн бүтээгдэхүүний экспортын өсөлтөөс хамааралтай, дэлхийн зах зээлийн гол түүхий эдийн бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлтийн нөлөөлөл хүчтэй, мөчлөг дагасан эдийн засгийн бодлого хэрэгжүүлж ирсэн байна.

Бодит сектор, эдийн засгийн өсөлт

Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт Ковид-19 цар тахлын үед буюу 2020 онд 4.4 хувиар унаж байсан бол 2021 онд 1.6 хувь, 2022 онд 5 хувь, 2023 онд 7.1 хувийн өсөлттэй болж аажмаар сэргэж (Зураг 6) эхэлжээ.


Зураг 6. Эдийн засгийн бодит өсөлт, хувиар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

ДНБ-ийг эцсийн хэрэглээний аргаар тооцож үзэхэд 2023 оны байдлаар 70,444 тэрбум төгрөг болж, үүнээс 42,087 тэрбум төгрөг нь эцсийн хэрэглээ буюу нийт зардал, 22,384 тэрбум төгрөг нь хөрөнгийн хуримтлал, 53,730 тэрбум төгрөг нь бараа, үйлчилгээний экспорт, 47,678 тэрбум төгрөг нь бараа, үйлчилгээний импортоос бүрдэж байна. Эдийн засгийн бодит өсөлт 7.0 хувьтай гарсан нь цэвэр экспорт 6,051 тэрбум төгрөг болсонтой холбоотой байна.

Зураг 7. ДНБ эцсийн ашиглалтын аргаар, жилээр, сая төгрөгөөр




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

2022, 2023 оны эдийн засгийн өсөлтийг ДНБ-ийн салбар бүрээр харьцуулж үзэхэд (Хавсралт 1) уул уурхайн салбарын олборлолт 2.6 хувиар, тээвэр болон агуулахын үйл ажиллагаа 1.8 хувиар тус тус өссөн нь голлох нөлөө үзүүлсэн байна. Манай улсын эдийн засгийн бүтцэд уул уурхайн салбарын эзлэх хувь өндөр, харин бусад салбарын эзлэх хувийн жин харьцангуй бага бөгөөд энэ нь эдийн засгийн өсөлтийг хангахад уул уурхайн бус салбарын нөлөөлөл сул хэвээр байгааг харуулж байна.

ДНБ-ийн бүтцэд уул уурхайн салбарын эзлэх хувийн жин өнгөрсөн 2019-2023 онд 11.0-14.6 хувь байсан бол уул уурхайн бус салбарын эзлэх хувийн жин 85.4 хувиас 89.0 хувь хооронд хэлбэлзэж байна. Эндээс харахад цар тахлын жилүүдийн үед уул уурхайн салбарын үйлдвэрлэл бага зэрэг буурсан боловч сүүлийн жилүүдэд идэвхжих хандлагатай байна. Энэ нь Оюу толгойн далд уурхайн үйлдвэрлэл эхэлсэн, хил гааль, боомтын үйл ажиллагаа сэргээнтэй холбоотой байна.

Зураг 8. ДНБ-ний өсөлт ба уул уурхайн болон уул уурхайн бус салбарын ДНБ-д эзлэх хувийн жин, 2019-2023 оны жилийн эцсийн байдлаар




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Эдийн засгийн бүтцэд уул уурхайн салбарын эзлэх хувийн жин хэвээрээ байгаа нь цаашид бүтцийн өөрчлөлтийн бодлогыг улам эрчимжүүлэх, ингэснээр уул уурхайн бус салбаруудыг хөгжүүлэх, тухайлбал, хөдөө аж ахуй, аялал жуулчлал, аж үйлдвэрийн салбарыг хөгжүүлэхэд анхаарч, эдийн засгийг төрөлжүүлэн солонгоруулах бодлогын чиглэлийг урт хугацаанд эрчимтэй авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа нь харагдаж байна. Энэ нь макро эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахын тулд гадаад зах зээлээс хараат бус байх, үндэсний орлого нь зөвхөн газрын доорх эрдэс баялаг, ашигт малтмалын олборлолт болон тэдгээр бүтээгдэхүүний дэлхийн зах зээлийн үнийн өсөлтөөс хэт хараат

байдлаас гарахад чухал ач холбогдолтой болно. Нөгөө талаар Үндэсний хуримтлалыг эрчимтэй бий болгох, цаашид нэмүү өртөг бий болгоход чиглэсэн аж үйлдвэрийн салбаруудыг хөгжүүлэхэд бодлогын хувьд анхаарах хэрэгтэйг харуулна.

Аж үйлдвэрийн салбарын нийт бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2021 оны байдлаар 17,956.7 тэрбум төгрөгтэй тэнцэж байсан бол 2022 онд өмнөх оноос 16.9 хувиар өсөж 20,985 тэрбум төгрөг, 2023 онд өмнөх оноосоо 45.2 хувиар өсөж 30,459.8 төгрөг (Зураг 9) тус тус болсон байна. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэлийн өсөлтөд нөлөөлсөн гол хүчин зүйл бол уул уурхайн салбарын олборлолтын үйлдвэрлэл бөгөөд 2021 онд 12,274.1 тэрбум төгрөг, 2022 онд өмнөх оноос 16.8 хувиар өсөж 14,331 тэрбум төгрөг, 2023 онд өмнөх оноос 50.2 хувиар өсөж 21,531.2 тэрбум төгрөг тус тус болсон байна.


Зураг 9. Аж үйлдвэрийн салбарын бүтээгдэхүүний нийт үйлдвэрлэлийн хэмжээ, тэрбум төгрөгөөр, 2021-2023 оны байдлаар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Дэлхийн банкны аргачлалаар тооцсон нэг хүнд ногдох үндэсний нийт орлого (ҮНО)-ын хэмжээ манай улсын хувьд сүүлийн жилүүдэд ойролцоогоор 4,200 ам.доллар орчим байгаа нь дунд, гэхдээ дундаас доогуур орлоготой ангиллаас дээгүүр орлоготой ангилалд багтаж байна. Нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээ 5,000 ам.доллар хүрэхгүй байгаа нь иргэдийн орлогын түвшин бага байгааг харуулж буй бөгөөд эдийн засаг өссөн ч иргэдийн орлогод нөлөө багатайг илтгэж байна.

Зураг 10. Дэлхийн банкны атлас аргаар тооцсон нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээ (ам.доллар), ДНБ-ийн бодит өсөлтийн хэмжээ (хувиар)




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Монгол Улсын хувьд нэг хүнд ногдох ҮНО нь урт хугацаанд тогтвортой хадгалагдаж байгаа нь гол анхаарах асуудлын нэг болж байна.

Төлбөрийн тэнцэл, гадаад худалдаа

Манай улсын гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр өмнөх оны мөн үеэс 3,192 сая ам.доллараар өсөж 24,437 сая ам.долларт хүрсэн байна.

Зураг 11. Гадаад худалдааны 2021-2023 оны нийт эргэлт, тэнцэл, сая ам.доллараар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Үүнд экспорт 21 хувиар буюу 2,644 сая ам.доллар, импорт 6 хувиар буюу 548 сая ам.доллараар өссөн нь нөлөөлж, худалдааны тэнцэл 5,932 сая ам.долларын ашигтай гарчээ.

Төлбөрийн урсгал тэнцэл

Манай улсын нийт экспортын хэмжээ 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр өнгөрсөн оны мөн үеэс 21 хувиар буюу 2,646 сая ам.доллараар өсөж 15,184 сая ам.долларт хүрсэн бөгөөд уул уурхайн бүтээгдэхүүний экспорт нь нийт экспортын 93 хувийг бүрдүүлж байна. Экспортын хэмжээ мөнгөн дүнгээр өссөн боловч өмнөх онуудтай харьцуулахад жилийн өсөлтийн хэмжээ өмнөх жилүүдээс буурчээ. Өмнөх онтой харьцуулахад экспортын жилийн өсөлт 2022 онд 35.6 хувь гарч байсан бол 2023 онд 21.1 хувийн өсөлттэй байна.


Зураг 12. Экспортын хэмжээ (сая ам.доллар), экспортын жилийн өөрчлөлт (хувиар)



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Энэ нь 2020, 2021 онд гарсан цар тахлын нөлөөлөл, бодит хэмжээний өсөлтөөс хамаарсан динамик нөлөөлөл зэргээс шалтгаалсан гэж үзэж байна.


Зураг 13. Экспортын хэмжээнд гадаад худалдааны түншлэгч орнуудын эзлэх хувь



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Нийт экспортын хэмжээг гадаад худалдааны түнш орнуудаар задалж үзвэл дийлэнх хувь нь хөрш орнууд буюу ОХУ, БНХАУ-д ногдож байгаа бөгөөд тэр дундаа нийт экспортын 92 хувийг БНХАУ эзэлж байна.


Зураг 14. Импортын хэмжээ, сая ам.доллараар



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Гадаад худалдааны энэхүү бүтцийн гажуудал болон нэг улсаас ихээхэн хамааралтай байдал олон жил үргэлжилж байна. 2023 оны байдлаар 9,253 сая ам.долларын барааг гадаад орнуудаас импортолсон бөгөөд цар тахлаас хойш сүүлийн хоёр жилийн хугацаанд мөнгөн дүнгээр өссөн боловч өмнөх жилтэй харьцуулахад өсөлтийн хувь нь буурсан байна. Цаашид импортын нийт хэмжээ 10 тэрбум ам.доллараас давах хандлага ажиглагдаж байна.

Зураг 15. Импортын хэмжээнд гадаад худалдааны түншлэгч орнуудын эзлэх хувь




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Импортын хэмжээг улс орнуудаар авч үзвэл 25 гаруй хувийг ОХУ, 30-40 гаруй хувийг БНХАУ, 35-45 гаруй хувийг Европын улс орнууд болон бусад улс орнууд эзэлж байна. Харин 2023 оны байдлаар нийт импортын 25.8 хувийг ОХУ, 40.5 хувийг БНХАУ, 33.7 хувийг Европын улс орнууд болон бусад улс эзэлж байна.

2.2. НЭГДСЭН ТӨСВИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламжийн хэмжээ 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 24.3 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 31.3 хувь буюу 5.8 их наяд төгрөг, тэнцвэржүүлсэн орлого, тусламжийн хэмжээ 23.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 35.6 хувь буюу 6.1 их наяд төгрөгөөр тус тус нэмэгдсэн байна.

Зураг 16. Улсын нэгдсэн төсвийн 2020-2023 оны тэнцвэржүүлсэн орлого, нийт зарлага, тэнцвэржүүлсэн тэнцэл, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

2023 оны хувьд тэнцэл ашигтай гарсан нь сүүлийн дөрвөн жилд анх удаагийн тохиолдол юм. Цаашид энэ үзүүлэлт хэвээр хадгалагдах боломж бага байгаа нь төсвийн тогтвортой байдлын хүрээний гол асуудал гэж үзэж болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого, тусламж

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого 2021 онд 12,711.4 тэрбум төгрөг, 2022 онд 17,126.9 тэрбум төгрөг, 2023 онд 23,217.9 тэрбум төгрөг болсон байна.


Зураг 17. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021-2023 оны тэнцвэржүүлсэн орлого, татварын болон татварын бус орлого, тэрбум төгрөгөөр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Нийт орлогод эзлэх татварын орлогын хэмжээ 90.0-92.3 хувь байна.

Зураг 18. Нэгдсэн төсөвт 2021-2023 онд төвлөрсөн татварын орлого, нэр төрлөөр, тэрбум төгрөгөөр




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Татварын нийт орлого 2023 оны урьдчилсан гүйцэтгэлээр 21.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оноос 6.0 их наяд төгрөгөөр буюу 38.8 хувиар өсөхөд орлогын албан татварын орлого 2.0 их наяд төгрөг буюу 51.6 хувиар, ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 1.8 их наяд төгрөгөөр буюу 2.0 дахин, нийгмийн даатгалын орлого 904.6 тэрбум төгрөгөөр буюу 29.8 хувиар, нэмэгдсэн өртгийн албан татвар 827.2 тэрбум төгрөг буюу 21.0 хувиар тус тус өссөн нь голлон нөлөөлжээ. Харин онцгой албан татвар 57.8 тэрбум төгрөг буюу 6.8 хувиар буурсан байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн зарлага, цэвэр зээлийн дүн

Монгол Улсын төсвийн орлого нэмэгдэж байгаа, гадаад орчны таатай зурвас үе таарч байгаа зэрэг нь төсвийн зарлагын тэлэх бодлого хэрэгжүүлэх нөхцөл байдлыг бий болгохоор байгаа юм.

Зураг 19. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2019-2023 оны нийт зарлага ба цэвэр зээлийн дүн, тэрбум төгрөг



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Төсвийн нийт зарлага, эргэж төлөгдөх цэвэр зээлийн хэмжээ 2023 онд 22.5 их наяд төгрөгт хүрч, тэнцвэржүүлсэн тэнцэл 763.4 тэрбум төгрөгийн ашигтай гарсан. Гэхдээ сүүлийн 5 жилд төсвийн зарлага бараг хоёр дахин өссөнийг дээрх зургаас харж болно. Энэ нь бид өмнөх байдлаараа эрдэс бүтээгдэхүүний үнээс хамаарсан өсөлтийг шууд дагаж төсвийн зарлагыг нэмэгдүүлдэг, мөн цар тахал гэх мэт хямралаас шалтгаалан төсвийг дураараа өсгөх хандлагатай хэвээр байгааг харуулж байгаа юм.


Ийнхүү төсвийн зарлага нэмэгдсэн нь 2023 онд Засгийн газрын зүгээс төсвийн орлого өссөнөөс үүдэн төсвийн зарлагыг тэлэх бодлого хэрэгжүүлж, төсвийн нэмэгдсэн орлогыг төрийн албан хаагчдын цалинг нэмэх, дуусаагүй хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж дуусгах арга хэмжээг авсантай холбоотой гэж үзэж байна. Энэ нь эдийн засгийн бодлогын хувьд Засгийн газрын хэрэглээг нэмэгдүүлж эрэлтийг дэмжиж байгаа хэдий боловч инфляцыг өсгөх сөрөг нөлөөллийг бий болгосон гэж үзэж байна.

Засгийн газрын өр

Монгол Улсын Засгийн газрын гадаад өрийн хэмжээ 2020 онд 8.6 тэрбум ам.доллартай тэнцэж байсан бол 2020-2021 онд буурч 2023 оны жилийн эцсийн байдлаар 7.9 тэрбум ам.долларт хүрсэн байна. Үүнд нөлөөлсөн хүчин зүйл нь өндөр дүнтэй Засгийн газрын гадаад үнэт цаасны төлбөрийг төлж барагдуулсан явдал юм.

ДНБ-д эзлэх улсын өр болон Засгийн газрын өрийн хувь хэмжээ өмнөх жилүүдтэй харьцуулахад буурч байгаа боловч өндөр дүнтэй богино хугацаатай гадаад үнэт цаасны өрийн үлдэгдэл төсвийн төлбөрийн чадварт голлон сөргөөр нөлөөлж байгаа нь ажиглагдаж байна. Зарим тохиолдолд, тухайлбал төсвийн орлого өндөр байх үед их дүнтэй гадаад үнэт цаасны төлбөрийг барагдуулах арга хэмжээ авбал эдийн засагт эерэг нөлөө бий болгох боломж бүрдэнэ.

Зураг 20. Монгол Улсын нийт болон Засгийн газрын гадаад өр (2017-2023 оноор), сая ам.доллараар




Эх сурвалж: Монголбанк (2024)

Эдийн засагт дэлхийн зах зээлийн гол бүтээгдэхүүний үнийн өсөлтийн хэлбэлзэл болон олон улсын хөрөнгийн зах зээл дэх хүүгийн түвшин, гадаад зээлийн эх үүсвэр нэн шаардлагатай хэвээр байгаа тохиолдолд манай улсын гадаад өрийн дарамт үргэлжлэх хандлага байсаар байна.

2.3. МӨНГӨНИЙ СЕКТОР БУЮУ МӨНГӨНИЙ БОДЛОГО

Мөнгөний нийлүүлэлт буюу M2 мөнгө өмнөх оны мөн үеэс 26.8 хувиар өсөж 37.6 их наяд төгрөгт хүрчээ. Тодруулбал, жилийн өөрчлөлтийн 15.2 нэгж хувийг төгрөгийн хадгаламж, 8.7 нэгж хувийг төгрөгийн харилцах, 2.4 нэгж хувийг гадаад валютын харилцах, 0.3 нэгж хувийг гадаад валютын хадгаламж, 0.3 нэгж хувийг хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгөний өсөлт тус тус бүрдүүлж байна.

Зураг 21. Мөнгөний нийлүүлэлт (2019-2023 он), сая төгрөг



Өмнөх сартай харьцуулахад M2 мөнгө 6.3 хувиар өссөн нь иргэдийн төгрөгийн хадгаламж, хувийн байгууллагын төгрөгийн болон гадаад валютын хадгаламж нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ. Улсын байгууллага болон хувийн байгууллагын гадаад валютын харилцах буурсан байна.

Нийт хадгаламжийн хэмжээ 22.1 их наяд төгрөг байгаагаас 81.6 хувь буюу 18.0 их наяд төгрөг нь иргэдийн, 18.4 хувь буюу 4.1 их наяд төгрөг нь байгууллагын хадгаламж байна. Мөн нийт хадгаламжийн 22.6 хувь нь гадаад валютын хадгаламж байгаа бөгөөд байгууллагын хадгаламжийн 31.7 хувийг, иргэдийн хадгаламжийн 20.5 хувийг гадаад валютын хадгаламж бүрдүүлжээ (Монголбанкны мэдээлэл, 2024).

Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас нь авч үзвэл, Төв банк болон хадгаламжийн байгууллагуудын дотоод цэвэр активын дүн 28.7 их наяд төгрөг, гадаад цэвэр активын дүн 8.9 их наяд төгрөгтэй тус тус тэнцэж байна. М2 мөнгөний жилийн өсөлтийн 21.7 нэгж хувийг гадаад цэвэр актив, 5.1 нэгж хувийг дотоод цэвэр актив эзэлж байна.

Банкуудын зээл өмнөх оны мөн үеэс 23.3 хувиар өсөж 27.1 их наяд төгрөгт хүрчээ. Тодруулбал, жилийн өсөлтийн 11.2 нэгж хувийг хэрэглээний болон хадгаламж барьцаалсан, 3.1 нэгж хувийг худалдааны, 3.1 нэгж хувийг бусад, 2.3 нэгж хувийг ипотекийн, 2.2 нэгж хувийг боловсруулах үйлдвэрлэлийн, 1.1 нэгж хувийг уул уурхай, олборлолтын, 0.6 нэгж хувийг тээвэр, агуулахын, 0.3 нэгж хувийг барилгын, 0.3 нэгж хувийг санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа салбарын зээл бүрдүүлж байна. Мөн зээлийн үлдэгдлийн 6.1 хувь нь гадаад валютаар олгосон зээл байна. Тайлант сард банкууд 4,416.6 тэрбум төгрөгийн зээл олгосон ба 3,525.7 тэрбум төгрөгийн зээл эргэн төлөгдөж, өмнөх сараас зээлийн үлдэгдэл 505.7 тэрбум төгрөг буюу 1.9 хувиар өсжээ.

Нийт зээлийн 4.7 хувь буюу 1,264.0 тэрбум төгрөг анхаарал хандуулах, 7.5 хувь буюу 2,032.1 тэрбум төгрөг чанаргүй зээл байна. Чанаргүй зээлийн 17.9 хувийг барилгын, 17.2 хувийг уул уурхай, олборлолтын, 16.8 хувийг боловсруулах, 14.0 хувийг худалдааны, 7.5 хувийг цалингийн зээл тус тус эзэлж байгаа бөгөөд нийт чанаргүй зээлийн 9.0 хувь нь гадаад валютаар олгосон зээл байгаа юм.

ГУРАВ. МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСГИЙН ЦААШДЫН ТӨЛӨВ, УЧИРЧ БОЛОХ ЭРСДЭЛ

Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2023 онд өндөр, макро эдийн засгийн гол үзүүлэлтүүд ихээхэн зөрөг гарсан. Гэхдээ энэ нь эдийн засгийн нөхцөл байдал бүрэн сайжирсан гэсэн үг биш юм. Энэ нь хүн амын амьжиргаа, ядуурал, хөдөлмөрийн зах зээл, банкны салбар дахь чанаргүй зээл, бизнесийн зээлийн өсөлт гэх мэт олон үзүүлэлтээр илэрч байна. Нөгөө талаас энэ өсөлт нь баталгаатай, тогтвортой өсөлт бас биш юм. Иймд бидний зүгээс Монгол Улсын эдийн засгийн цаашдын төлөв байдалд анхаарахын зэрэгцээ учирч болох дараах эрсдэлүүдийг онцолж байна.

3.1. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙН ТОГТВОРГУЙ БАЙДАЛ

Сүүлийн 30 гаруй жилийн эдийн засгийн өсөлтийн хандлага нь ерөнхийдөө тогтворгүй гэсэн төлөв байдлыг харуулдаг. Энэ хугацаанд бидний бий болгож чадаагүй зүйл нь тогтвортой өндөр өсөлтийн асуудал юм. 2023 оны эдийн засгийн өсөлт 7.0 хувьтай гарахад уул уурхай, тээвэр, үйлчилгээ гэсэн хэдхэн салбар голлох нөлөө үзүүлсэн байна. Сүүлийн 10 жилийн эдийн засгийн өсөлт, бууралт нь уул уурхайн салбарын гарц, бүтээгдэхүүний үнээс ихээхэн хамааралтай болсон нь гол эрсдэл юм.

Зураг 22. ДНБ-ий өсөлт, Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн өсөлт, Уул уурхайн салбарт оруулсан ГШХО



Эх сурвалж: СЭЗИС (2024). Уул уурхайн салбар, түүнд оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө. Судалгааны тайлан.

Энэхүү эрдсийн бүтээгдэхүүн, гадаадын шууд хөрөнгө оруулалтаас хамаарсан өсөлт нь сүүлийн 10 гаруй жилд хэрхэн өөрчлөгдөж байсан нь эрсдэл ямар их болохыг харуулна. Монгол Улсын хувьд тогтвортой эдийн засгийн өсөлт хэмээх ойлголт бий болж чадаагүй, урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгох нөхцөл ийг бүрдээгүй байгаа нь манай эдийн засгийн гол хэв шинж, төлөв байдлын илэрхийлэл болж байна.

Тиймээс Дэлхийн банкны зүгээс Монгол Улсыг “эрчимтэй боловч тэнцвэргүй өсөлттэй” хэмээн тодотгож, “Монгол Улсын эдийн засгийн өсөлт эрчимжиж буй хэдий ч жигд бус, уул уурхайн салбарт голлон түшиглэсэн бөгөөд уул уурхайн бус салбарын идэвхжил сул байна” гэж тодорхойлжээ. (Дэлхийн банк, 2023/11, хууд. 10). Дэлхийн банкнаас 2022 онд биднийг тодорхойлж байсан “Шуурган дунд зүг чигээ олохуй” (Дэлхийн банк, 2022/4) гэсэн

хандлага өөрчлөгдөж буй ч эдийн засгийн өсөлт тэнцвэртэй бус, эмзэг байгааг анхаарах шаардлагатай.

Монгол Улсын эдийн засгийн өнөөгийн байдал нь тодорхой хугацааны сэргэлт бөгөөд нийт иргэд, аж ахуйн нэгжийн хувьд хүртээмжтэй өсөлт болж чадаагүй, энэ нь цаашид хадгалагдах эсэх нь эргэлзээтэй байна. Иймд бидний ойрын жилүүдийн зорилт нь 2023 оны хүрсэн түвшнийг алдахгүй байх явдал юм. Ингэснээр тогтвортой өсөлтийн суурийг бий болгож, цаашид хүртээмжтэй өсөлтийн нөхцөлийг хангах боломжтой.

3.2. ЭДИЙН ЗАСГИЙН БҮТЭЦ

Эдийн засаг тогтворгүй бөгөөд эмзэг байгаагийн длы нэг гол шалтгаан нь эдийн засгийн бүтцийн асуудал юм. 1990 оноос хойш эдийн засгийн нөхцөл байдал бүтцийн хувьд ихээхэн сул болсон бөгөөд цөөн салбараас хамаарал өндөртэй эдийн засаг болж хувирсан.

Зураг 23. Эдийн засагт голлох салбаруудын эзлэх хувь




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

2023 оны байдлаар эдгээр салбар нь нийт эдийн засгийн 48.1 хувийг эзэлж байна. Үүн дээр үйлчилгээний бусад салбар нэмэгдвэл эдийн засгийн дийлэнх хувийг олборлолт, үйлчилгээний салбар эзлэх болов.

Эдийн засгийн 50 хувийг гурван салбар бүрдүүлж байгаа бөгөөд эдгээр салбарын эрсдэл өндөр, нэгнээсээ хамаарах хамаарал өндөртэй юм. 2023 оны эдийн засгийн өсөлтийн урьдчилсан гүйцэтгэл 7.0 хувь гарсныг салбарын бүтцээр авч үзвэл, ХАА 1.3 хувь, уул уурхай, олборлолт 2.6 хувь, үйлчилгээний салбар 4.3 хувь, үүний дотор тээвэр, агуулах 1.8 хувийг эзэлж байгаа нь эдийн засгийн өсөлтийг уул уурхайн салбар тодорхойлж байгааг илтгэнэ. Үүнээс гадна эдийн засгийн бүтцийн дараагийн нэг гажуудал нь аж үйлдвэрийн салбарын бүтэц юм. Энэ салбарт уул уурхайн салбарын эзлэх хувийн жин жил ирэх бүр нэмэгдэж байгаа нь салбарын нөлөөллийн түвшнийг илэрхийлэх бас нэг үзүүлэлт юм.

Зураг 24. Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, уул уурхайн олборлолт, оны үнээр



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл, уул уурхайн олборлолт жилээс жилд өсөх хандлагатай байгаа бөгөөд аж үйлдвэрийн салбарт уул уурхайн салбарын эзлэх хувь 2021-2023 онд 72.2-77.5 хувь болж өссөн. 2024 он болон дунд хугацааны эдийн засгийн төлөв байдалд уул уурхайн салбарын өнөөгийн нөхцөл байдал хадгалагдах эсэх болон ХАА-н салбар, ялангуяа мал аж ахуйн салбарт хоёр жил дараалан тохиож буй хүндрэлийг сайтар харгалзан үзэх шаардлагатай. Эдийн засгийн өсөлтөд учирдаг бас нэг эрсдэл нь эрчим хүчний эх үүсвэр, хангамжийн асуудал юм.

Хүснэгт 3. Эрчим хүчний импорт

Үзүүлэлт	2021		2022		2023	
	Тоо хэмжээ	Үнийн дүн /сая \$/	Тоо хэмжээ	Үнийн дүн /сая \$/	Тоо хэмжээ	Үнийн дүн /сая \$/
Цахилгаан эрчим хүч, сая кв.цаг	1823.1	160.2	2107.4	182.3	2426.9	189.4

Өнөөдөр Монгол Улс ОХУ-аас эрчим хүч импортлолж байгаагийн дээр энэ нь эдийн засгийн өсөлтийг хязгаарлах нэг гол хүчин зүйл болж байгаа нь анхаарах шалтгаан юм.

3.3. ГАДААД ХУДАЛДАА, ЭРДСИЙН БҮТЭЭГДЭХҮҮНИЙ ҮНЭ

Эрдсийн бүтээгдэхүүний олборлолт, экспорт нь манай эдийн засгийн өсөлт, валютын нөөц, төлбөрийн тэнцэл, төсвийн орлого, гэх мэт бүхий л хүчин зүйлсийн шалтгаан болж байгааг бид харлаа. Иймд гадаад худалдааны асуудлыг хөндөх нь зүйн хэрэг юм.

Монгол Улсын гадаад худалдаа

2023 онд макро эдийн засгийн нөхцөл ихээхэн эерэг болсон нь уул уурхайн салбар, нүүрсний экспорттой шууд хамааралтай. Үүнээс шалтгаалж гадаад худалдааны нийт эргэлт 24.4 тэрбум ам.доллар, экспорт 15.2 тэрбум ам.доллар, импорт 9.3 тэрбум ам.доллар болж, төлбөрийн тэнцэл 5.9 тэрбум ам.долларын ашигтай гарчээ.

Хүснэгт 4. Нүүрсний олборлолтын хэмжээ, мянган тонн


Бүтээгдэхүүн	2022		2023		Өөрчлөлт	
	XII	I-XII	XII	I-XII	Дүн	Хувь
Чулуун нүүрс	5,271.0	29,672.0	7,181.0	69,586.0	39,914.0	2.3 дахин
Хүрэн нүүрс	935.0	7,536.0	1,230.0	11,606.0	4,070.0	54.0
Баяжуулсан нүүрс	490.0	3,405.0	444.0	6,979.0	3,578.0	2 дахин

Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо (2024)

Харин өмнөх хэсэгт дурдсан уул уурхайн салбарын өсөлт, нөлөөлөл болон дээрх хүснэгт дэх үйлдвэрлэлийн хэмжээ хэр тогтвортой, юунаас шалтгаалж энэхүү өсөлт гарсан гэдэг нь эдийн засгийн эрсдэлийг тодорхойлох гол үзүүлэлт юм.

Энэ нь БНХАУ-ын хувьд 2019 оноос хойш нүүрсний дотоодын үйлдвэрлэл нь буурсан, импорт дээд хэмжээндээ хүрсэн таатай нөхцөл байдалтай холбоотой юм.

Зураг 25. БНХАУ-ын нүүрсний импорт, улсаар




Эх сурвалж: S&P Global (2024). Global Market Intelligence.

<https://www.spglobal.com/marketintelligence/en/news-insights/latest-news-headlines/china-s-coal-imports-to-stay-high-in-2024-after-record-breaking-q4-2023-80251799>

Дээрх зургаас харахад энэ нөхцөл байдалтай давхцаж Монгол Улсаас импортлох нүүрсний хэмжээ өссөн нь харагдаж байна. Олон Улсын Эрчим хүчний агентлагаас гаргасан тайланд Монгол Улсын эдийн засгийн өсөлтийг тодорхойлж буй гол эрдэс болон түүний эрэлтийн хандлагын талаарх мэдээллийг мөн дээрхтэй ойролцоо байдлаар харуулсныг дараах зурагт харуулав.


Зураг 26. Хятадын нүүрсний импортод 2023 онд сар бүр гарсан өөрчлөлт, гарал үүслээр



Эх сурвалж: International Energy Agency (2023). Analysis and forecast to 2026.

2023 онд нүүрсний экспорт ихээхэн нэмэгдсэн шалтгааныг эндээс харах боломжтой. Үүний зэрэгцээ БНХАУ-ын ӨМӨЗО-ы эдийн засаг, гангийн үйлдвэрлэл, уул уурхайн салбарын эрдсийн бүтээгдэхүүний эрэлтийн байдал эергээр нөлөөлжээ. Энэ нөхцөл байдал цаашид хэрхэх вэ? гэдэг нь манай эдийн засгийн өсөлтийн хувьд гол асуудал юм. Бидний зүгээс энэ нөхцөл байдлыг гадаад болон дотоод орчны дараах хүчин зүйлсээс шалтгаална гэж үзэж, нарийвчлан судлах шаардлагатай.

Зураг 27. Нүүрсний экспортын өсөлтийн шалтгаан



Эх сурвалж: Төсвийн тогтвортой байдлын зөвлөл (2024)

Эдгээрээс биднээс шалтгаалах, эс шалтгаалах асуудал байгааг харж болох бөгөөд аль ч талд тодорхой эрсдэл байгаа юм. Ялангуяа БНХАУ-н эдийн засгийн нөхцөл байдал, гангийн үйлдвэрлэлтэй холбоотой асуудал ихээхэн нөлөөтэй байх болно.


Дэлхийн зах зээл дээрх эрдсийн бүтээгдэхүүний үнэ

Энэхүү тайлангийн эхний хэсэгт дурдсан олон улсын нөхцөл байдал, хөрш орнуудаас хамаарах эдийн засаг, улс төрийн нөхцөл байдал, үнийн өөрчлөлт зэргээс шалтгаалж Монгол Улсын эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөр юм. Иймд үнийн эрсдэлийг тодорхойлох хүрээнд үнийн талаар зарим мэдээлэл орууллаа.

Учир нь, эрдсийн бүтээгдэхүүний үнэ нь Монгол Улсын эдийн засаг төдийгүй төсөвт учирах гол эрсдэл юм. Олон улсын байгууллагуудын таамаглалаас харахад нүүрсний үнийн төлөвт нэлээд сөрөг хандлага ажиглагдаж байгаа бөгөөд үүнийг дараах шалтгаанаар тайлбарлаж байна. Үүнд:

- Дэлхийн геополитикийн нөхцөл байдал
- Орос-Украины дайн, Ойрхи Дорнодын хурцадмал нөхцөл байдал
- БНХАУ-ын эдийн засагт гарч байгаа хүндрэл, эргэлзээтэй нөхцөл байдал гэх мэт үзүүлэлтийг онцолж болохоор байна.


Зураг 28. Коксжих нүүрсний 2023-2027 оны таамаглал, төрлөөр



Эх сурвалж: Statista (2024). <https://www.statista.com/>

Монгол Улсын 2024 оны төсөвт тэнцвэржүүлсэн байдлаар нүүрсний үнийг 182.5 ам доллар хэмээн таамагласан нь энэ жилийн хувьд тооцсон нүүрсний үнийн таамаглалаас доогуур байгаа нь богино хугацаанд эрсдэл тулгарахгүй мэт харагдаж байгаа боловч дунд хугацааны хувьд өөрчлөлт гарахгүй гэсэн үг биш юм.

Зураг 29. Дэлхийн банкнаас гаргасан зэсийн үнийн таамаглал




Эх сурвалж: WBG (2022). Drivers of aluminum and copper prices

Монгол Улсын 2024 оны төсөвт тэнцвэржүүлсэн байдлаар зэсийн үнийг 7386.6 ам.доллар гэж тооцсон нь Дэлхийн банкны таамаглалаас доогуур байгаа юм. Зэсийн үнийн хувьд эрсдэл харьцангуй бага гэж ойлгож болох бөгөөд цаашид өсөх хандлагатай гэж таамаглаж байгаа нь эрсдэлийн хувьд нүүрстэй харьцуулахад бага гэсэн дүгнэлтэд хүргэж байна.

Харин Олон улсын эрчим хүчний агентлагаас гаргасан тайлангаас харахад сэргээгдэх ба цөмийн эрчим хүчний эх үүсвэрийн эрэлт нэмэгдэх хандлага ажиглагдаж байна.

Зураг 30. Кокежих нүүрсний хэрэглээний 2023-2026 оны өөрчлөлт, бүс нутгаар




Эх сурвалж: International Energy Agency (2023). Coal 2023 Analysis and forecast to 2026.

Ирэх жилүүдэд гангийн хэрэглээний дэд бүтэцтэй холбоотой хөрөнгө оруулалт буурах хандлагатай байгаа тул Хятадын эрчим хүчний салбарын нүүрсний хэрэглээ үйлдвэрлэлийн нийт үйл ажиллагаатай нийцнэ гэж хүлээхээргүй байна.

Олон Улсын эрчим хүчний агентлагийн үзэж байгаагаар нүүрсний эрэлт ойрын ирээдүйд хэвийн байх боловч энэ нөхцөл байдлыг хадгалах гол хүчин зүйл нь БНХАУ-ын бус, Энэтхэг улсын эрэлт хэмээн тодорхойлсныг анхаарах нь зүйтэй юм.

Зураг 31. Дэлхийн эрчим хүчний эрэлт, эх үүсвэрийн өөрчлөлт, 2022-2026 он



Эх сурвалж: International Energy Agency (2023). Coal 2023 Analysis and forecast to 2026.

Энэ хандлагыг дээр дурдагдсан коксжих нүүрсний хэрэглээ, БНХАУ-ын эдийн засгийн нөхцөл, импортын хандлагатай хамтад нь авч үзвэл Монгол Улсын эрчим хүчний болон коксжих нүүрсний хувьд эрсдэлтэй гэсэн хандлагаар төлөвлөлтөд хандах нь зүйтэй гэж үзэж байна.

3.4. ТӨСВИЙН ГОЛЛОХ ЭРСДЭЛ

Монгол Улсын эдийн засгийн түүхэн хөгжил, өнөөгийн байдал болон олон улсын хандлагаас харахад төсвийн хүрээнд томоохон эрсдэлүүд байгаа гэж үзэх үндэслэлтэй төдийгүй тэдгээрийг харгалзах шаардлагатай юм. Энд эдийн засгийн нөхцөл байдал, төсвийн хоорондын хамаарал, төсвийн бодлогын хувьд учирч болох гол эрсдэлийг тоймлон авч үзлээ.


Төсвийн орлого уул уурхайн салбараас хамаарах хамаарал

Хүснэгт 5. Төсөвт 2014-2023 онд төвлөрүүлсэн уул уурхайн салбарын татварын орлого, тэрбум төгрөгөөр (татварын төрлөөр)

	2014	2015	2016	2017	2018	2019	2020	2021	2022	2023
Уул уурхайн салбарын төлсөн татвар	1,097.8	1,155.4	767.7	1,622.9	2,393.6	3,138.8	2,699.4	4,609.2	5,355.1	8,090.7
АМНАТ	614.0	610.2	288.7	847.8	1,046.6	1,425.7	1,218.2	1,586.4	2,912.5	4,150.6
ААНОАТ	212.3	261.7	225.8	443.7	653.1	869.2	659.4	1,504.7	1,110.2	2,176.0
Бусад	271.5	744.1	253.3	331.5	693.9	843.9	821.8	1,518.1	1,332.5	1,764.1

Эдийн засаг өсөж буй нөхцөл байдал нь төсвийн орлогыг уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай болгож байгаа нь гол асуудал юм. Эрдэс баялгийн, ялангуяа нүүрсний салбарт тодорхой сөрөг нөлөө бий болоход Монгол Улсын хувьд 2014-2016 оны үед бий болсон төсвийн хүндрэлтэй адил эрсдэлтэй тулгарах юм.

Зураг 32. Төсвийн орлогод уул уурхайн салбарын орлогын эзлэх хувь




Эх сурвалж: СЭЗИС (2024). Уул уурхайн салбар, түүнд оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө. Судалгааны тайлан.

Төсвийн орлогод уул уурхайн салбарын эзлэх хувь нэмэгдсээр байгаа нь энэхүү эрсдэлийн түвшнийг илэрхийлнэ. Гиймээс бодит байдалд гарцаагүй мөчлөг сөрсөн төсвийн бодлогыг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Төсвийн зарлагын тэлэлт, алдагдал

Эдийн засгийн өсөлт тогтвортой бус, эмзэг, төсвийн орлогод уул уурхайн салбарын эзлэх хувийн жин нэмэгдэж байгаа гэх мэт эргэлзээтэй нөхцөл байдлын дунд Монгол Улс төсвийн зарлагыг эрчимтэй нэмэгдүүлж байгаа нь дараагийн гол эрсдэл юм.

Зураг 33. Төсвийн зарлага, орлого, тэнцэл



Эх сурвалж: (Судалгааны баг, 2023)

Төсвийн энэ өндөр тэлэлтийн нөгөө талд дээрх хүчин зүйлсээс гадна нь бүтцийн гажуудал, хэт халамжийн бодлого, хөдөлмөрийн зах зээл, санхүүгийн салбар дахь зээлийн өсөлт, бүтэц гэх мэт олон хүчин зүйлийг харгалзан үзвэл зайлшгүй гэж үзэж болох зардлаас бусад чиглэлд төсвийн тэлэлтийг хязгаарлах шаардлагатай нь харагдана. Үүн дээр урт хугацааны

хөгжлийн бодлого, ҮАБ-ын үзэл баримтлалд нийцүүлэн Монгол Улс ойрын ирээдүйд төсвийн бага тэлэлттэй байж, эдийн засгийн суурийг тэтгэх татварын бодлогын шинэчлэлд анхаарлаа хандуулах нь зүйтэй юм.

Зураг 34. Төсвийн тэнцлийн бодлогын хэрэгжилт




Эх сурвалж: (Судалгааны баг, 2023)

Төсвийн зарлагын өндөр тэлэлт нь алдагдал, өрийн хэмжээнд шууд нөлөөлж, улс орны санхүүгийн нөхцөл байдлыг дордуулах гол шалтгаан болж байна. Тиймээс төсвийн зарлагыг хөгжлийн бодлого, эдийн засгийн зорилго, зорилтуудад түлхүү чиглэсэн байдлаар дунд, урт хугацаанд сөрөг нөлөө багатай байхаар төлөвлөх нь чухал юм.

Ингэхгүйгээр үргэлжилсэн төсвийн тэлэлт нь төрийн оролцоог улам нэмэгдүүлэх, төсвийн бодлогын үр ашигт сөрөг нөлөө үзүүлэх магадлал өндөр байна.

Зураг 35. Эдийн засаг дахь төрийн оролцоо, хувиар



Эх сурвалж: (Судалгааны баг, 2023)

Төсвийн зарлагын өсөлт нь уул уурхайн бус ДНБ-ны өсөлтөөс өндөр гүйцэтгэлтэй байна. 2016 онд 31.0 хувиар, 2020 онд 21.1 хувиар давж гарсан нь эхний жилд эдийн засгийн уналтыг сөрөх¹, дараагийн удаад цар тахлын шалтгаантай хэмээн тайлбарладаг.

Ямар ч шалтгаантай байсан энэ нь эдийн засгийн аливаа гэнэтийн нөлөөлөлд хариу үйлдэл үзүүлэх чадварын түвшнийг илэрхийлэх бөгөөд эерэг үзүүлэлт биш юм.

¹ Тухайн үед эдийн засгийн уналтын эсрэг төсвийн тэлэх бодлого явуулж, эдийн засгаа хамгаалах байдлаар тайлбарлаж байсан. Үүнтэй адил хандлагыг өнөө ч зарим улс төрийн хүрээнийхэн гаргасаар байдаг.

Үүний нөлөөгөөр төсвийн алдагдал, өр, төрийн оролцооны түвшин нэмэгдэх зэрэг сөрөг үзэгдлүүд бий болж байна (Судалгааны баг, 2023, хууд. 30). Энд дурдсанчлан төсвийг аливаа гэнэтийн нөлөөнд бэлэн байх, эрсдэлийг бууруулах талаас нь харах нь зүйтэй юм.

Дүгнэлт

Дотоод эдийн засгийн хувьд дараах дүгнэлтүүдийг хийж болохоор байна. Үүнд:

- Сүүлийн 30 жилийн эдийн засгийн нөхцөл байдлын гол сургамж нь эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгож чадаагүй явдал юм. Эдийн засаг уул уурхайн салбараас хамаарах хамаарал улам нэмэгдэж байгаа нь эрсдэл нэмэгдэх гол нөхцөл болж байна. Иймд эдийн засгийн бүтцийн асуудал нь шинэ эрсдэлийг бий болгож байгаа хэрэг юм. Тодруулбал, уул уурхайн салбараас хэт өндөр хамааралтай, эрчим хүч зэрэг эдийн засгийн өсөлтийг тэтгэх дэд бүтцийн салбарын хөгжил доогуур гэх мэт сул талууд бий болжээ.
- Эдийн засгийн тогтвортой өсөлт хадгалагдахгүй байгаа болон бусад шалтгаантайгаар нэг хүнд ногдох ҮНО-ын хэмжээ урт хугацаанд нэг түвшинд хадгалагдах нь “дундаж орлогын хавх” хэмээх үзэгдлийг бий болгох нөхцөлийг бүрдүүлж байгаа нь анхаарах дараагийн асуудал юм.
- Төлбөрийн тэнцэл 2023 онд эерэг гарсан ч 2024 оны эхний сарын байдлаар алдагдалтай болж эхэлсэн нь төлбөрийн тэнцлийн эерэг хандлагыг хадгалахыг эргэлзээтэй болгож байна. Үүний зэрэгцээ гадаад худалдаанд импорт нэмэгдэх хандлагатай байгаа нь худалдааны дансны өндөр ашгийг бууруулах эрсдэл байгааг харуулж байна.
- Гадаад худалдааны тэнцэл, эрдсийн бүтээгдэхүүний экспортын эерэг байдал нь тогтвортой хадгалагдах магадлал өндөр биш байх нь бүх үзүүлэлтээс харагдаж байна.
- Төсвийн мөчлөг сөрсөн бодлого хэрэгжээгүй явдал нь дараагийн нэг гол асуудал юм. Монгол Улсын эдийн засгийн суурь нөхцөл, бүтцийг ажиглавал мөчлөг сөрсөн төсвийн бодлого хэрэгжүүлэх шаардлага өндөр байгааг илэрхийлнэ. Гэтэл төсвийн хэт тэлэх бодлого хэрэгжүүлэх нь эрсдэлийг улам нэмэгдүүлэх нөлөөтэй.
- Улсын төсвийн орлого уул уурхайн салбараас өндөр хамааралтай, тухайн салбарын орлого нь нийгмийн шинжтэй халамж, тэтгэвэр тэтгэмжийг санхүүжүүлэх эх үүсвэр болж байгаа нь томоохон эрсдэл үүсгэх магадлалтай байна.

Зөвлөмж

- Эдийн засгийн нөхцөл байдлыг 2023 оны түвшинд хадгалах нь цаашдын гол зорилт болох бөгөөд төсвийн бодлогод голлох нөлөө үзүүлнэ.
- Эдийн засгийн тогтвортой өсөлтийг бий болгох, хүрээмжтэй өсөлтийг хангахын тулд төсвийн тэлэлтийг бууруулж, төрийн оролцоог багасгах нь хувийн хэвшлийн хөгжлийг дэмжиж, эдийн засгийн бүтцэд эергээр нөлөөлнө.
- Төсвийн бодлогыг мөчлөг сөрсөн байдлаар хэрэгжүүлэх нь чухал. Төсвийг зайлшгүй шаардлагатай өөрчлөлтөөс бусад тохиолдолд тэлэхгүй байлгах нь эрсдэлийг бууруулах гол нөлөөтэй.

4.1. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮНДСЭН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Дэлхийн банкнаас 2022 онд хэрэгжүүлсэн “Монгол Улсын Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөлийн институцийн чадавхыг бэхжүүлэх SGM 11-002” төслийн 2 дахь бүрэлдэхүүн хэсэгт хамаарах тайланд дурдсанаар дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл боловсруулахад шаардагдах макро эдийн засаг болон төсөвтэй холбоотой үзүүлэлтүүд (хувьсагчид)-ийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

1. Макро-эдийн засгийн мэдээлэл (ирэх 3 жилээр, мөн жилээр тооцох боломжтой)
 - a. Салбараар тооцсон бодит ДНБ-ий (үйлдвэрлэлийн аргаар) төсөөлөл
 - b. Бодит ДНБ, зарлагын бүрэлдэхүүн хэсгүүдээр
 - c. Нэрлэсэн ДНБ-ий төсөөлөл, бүрэлдэхүүн хэсгүүдээр
 - d. Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн (зэс, нүүрс, төмрийн хүдэр, алт)-ий тоо хэмжээ, үнийн төсөөлөл
 - e. Гадаад валютын ханшийн төсөөлөл
2. Төсвийн орлогын мэдээлэл (ирэх 3 жилээр, мөн жилээр тооцох боломжтой)
 - a. Нийт орлогын нарийвчилсан төсөөлөл (нийт орлого ба буцалтгүй тусламж, тэнцвэржүүлсэн нийт орлого) болон орлогын төрлөөр (аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, үл хөдлөх хөрөнгийн татвар, НӨАТ, онцгой албан татвар, гадаад худалдааны татвар, бусад татвар, татварын бус орлого)
 - b. Уул уурхайн орлого (ашигт малтмалаар), түүхэн болон ирээдүйн төсөөлөл
3. Төсвийн зарлагын мэдээлэл (ирэх 3 жилээр, мөн жилээр тооцох боломжтой)
 - a. Нийт зардал ба цэвэр зээлийн төсөөлөл
 - b. Урсгал зардал (цалин хөлс, бусад орлого, татаас ба шилжүүлэг, хүүгийн төлбөр)-ын төсөөлөл
 - c. Хөрөнгийн зардлын төсөөлөл
 - d. Зээлийн болон эргэн төлөлтийн төсөөлөл
 - e. ТӨҮГ -уудад олгох шилжүүлэг
4. Өрийн болон сангуудын мэдээлэл (ирэх 3 жилээр, мөн жилээр тооцох боломжтой)
 - a. Засгийн газрын өрийн (гадаад, дотоод) төсөөлөл
 - b. Гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөрийн төсөөлөл
 - c. Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сангийн орлого, зарлага, үлдэгдлийн төсөөлөл багтана (Гардинер, П., 2021, хууд. 32).

Бид дээрх 4 бүлгийн 15 үзүүлэлтээс өгөгдлийн сангийн боломж, цаг хугацааны хүчин зүйл зэргээс шалтгаалан дараах 4 бүлгийн 10 үзүүлэлтийг сонгон авч ирэх 3 жилээр таамаглал боловсруулав. Үүнд

1. Макро-эдийн засгийн мэдээлэл
 - a. Бодит ДНБ-ий (үйлдвэрлэлийн аргаар) төсөөлөл
 - b. Нэрлэсэн ДНБ-ий төсөөлөл, бүрэлдэхүүн хэсгүүдээр
 - c. Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн (зэс, нүүрс, төмрийн хүдэр, алт)-ий тоо хэмжээ, үнийн төсөөлөл
 - d. Гадаад валютын ханшийн төсөөлөл
2. Төсвийн орлогын мэдээлэл
 - a. Нийт орлогын нарийвчилсан төсөөлөл (нийт орлого ба буцалтгүй тусламж, тэнцвэржүүлсэн нийт орлого)
 - b. Уул уурхайн орлого (ашигт малтмалаар), түүхэн болон ирээдүйн төсөөлөл

3. Төсвийн зарлагын мэдээлэл
 - а. Нийт зардал ба цэвэр зээлийн төсөөлөл
 - б. Хөрөнгийн зардлын төсөөлөл
 - с. Урсгал зардал (цалин хөлс, бусад орлого, татаас ба шилжүүлэг, хүүгийн төлбөр)-ын төсөөлөл
4. Өрийн мэдээлэл
 - а. Засгийн газрын өрийн (гадаад, дотоод) төсөөллийг багтаав.

4.2. ТААМАГЛАЛ БОЛОВСРУУЛСАН АРГАЧЛАЛ

Макро эдийн засгийн таамаглал боловсруулахдаа:

- (1) *Хазайлтгүй байх (unbiasedness)*: Таамаглал болон биелэлийн зөрөөний хүлээгдэх утга 0 байх буюу таамаглал аль нэг тал руу (давах эсвэл дутах) хазайхгүй байх зарчим. Судалгаанаас үзэхэд төсөв боловруулах зорилгоор Засгийн газрын боловсруулсан таамаглал бодит байдлаас давах хандлагатай байдаг (Annet (2006) & Pina and Venes (2011)). Үүнээс гадна голлон нөлөөлөх хувьсагчдыг тооцохгүйгээр, эсвэл хувьсагчид хоорондын хамаарлыг буруу тооцон үнэлгээ хийснээс энэ зарчим алдагддаг.
- (2) *Үр ашигтай буюу рационал байх (efficiency)*: Таамаглал боловсруулахдаа тухайн үед бэлэн байсан бүх мэдээллийг оновчтой ашиглах зарчим.
- (3) *Ончтой байх (accuracy)*: Таамагласан болон биелсэн утгууд тоон дүнгээрээ ойролцоо байх болон чиг хандлагын хувьд нийцтэй байх гэсэн гурван зарчмыг урьтал болгон мөрдөх нь зүйтэй гэжээ (Leal et al. (2008)).

Хөгжингүй орнуудад макро эдийн засгийн таамаглал боловсруулахад эдийн засаг-математикийн загвар ашигладаг бөгөөд загварын давуу тал нь онолын үндэслэл бүхий туршигдсан аргачлалд суурилсан, өөр хоорондоо нийцтэй, бүтэн (дутуу юмгүй) таамаглал боловсруулах боломж олгодогт оршино². Загварт үндэслэн таамаглал боловсруулахдаа:

- (1) *Макро-төсөв нэгдмэл буюу интегриред*: Төсвийн талаар дэлгэрэнгүй тусгасан макро эдийн засгийн нэгдмэл загварыг ашиглан тооцоолол хийх;
- (2) *Давтамжтай буюу интератив*: Төсвийн болон макро хувьсагчдын хамаарлыг үнэлсэн дэд загвар, макро хувьсагчдыг тооцон гаргадаг суурь загвар хоёрыг хослуулан нэг загвараас гарсан үр дүнг нөгөө загварт уншуулах замаар тогтворжих хүртэл нь давтах гэсэн үндсэн хоёр аргачлалыг ашиглаж байна (Leal et al. (2008)).
Аль ч тохиолдолд:

$$\begin{cases} E_t[F_{t+1}] = fE_t[M_{t+1}] + F_t^* \\ E_t[M_{t+1}] = m_1(L)M_t + m_2(L)F_t \end{cases}$$

гэсэн хэлбэр бүхий бүтцийн тэгшитгэлийг үнэлэх шаардлага үүсдэг байна.

Энд $E_t[\cdot]$ -ээр t хугацаан дахь математик дундаж операторыг, (L) -ээр лаг буюу хоцрогдол операторыг, f, m_1, m_2 тус бүр коэффициентын векторуудыг, M -ээр макро эдийн засгийн хувьсагчдын векторыг, F -ээр төсвийн хувьсагчдын векторыг тус тус тэмдэглэв (Leal et al. (2008)).

Энэ жилийн хувьд бид таамаглал боловсруулахдаа эхний буюу макро-төсөв нэгдмэл загварт суурилах аргачлалыг сонгов. Энэ хүрээнд макро-төсөв нэгдмэл байх дөрвөн загварыг судалж үзсэний үндсэн дээр тэдний дотроос:

² Хувьсагч тус бүрийг нэг бүрчлэн үнэлэх нь харилцан хамаарлыг тооцохгүй байх сул талтай.

- (1) ОУВС-аас 2014 оноос хэрэглэж эхэлсэн байгалийн баялагтай, бага дунд орлоготой орнуудын эдийн засгийн өсөлт, хөрөнгө оруулалт болон өрийн динамикийг судлахад зориулан хөгжүүлсэн [DIGNAR](#) загвар (Melina et al. (2016));
- (2) Үндэсний Баялгийн Засаглалын Хүрээлэнгээс 2016 онд Монголын эдийн засагт зориулан Монголын эдийн засаг, төсвийн тогтвортой байдлын талаар урт хугацааны үнэлгээ, шинэ нөхцөл байдал болон бодлогын хувилбарын тогтвортой байдалд хэрхэн нөлөөлөхийг тооцох зорилгоор боловсруулсан [Mongolia Macro-Fiscal Model](#) загвар (Baksa et al. 2016)-ыг сонгон авч ажиллуулав.

Хүснэгт 6. Сонгосон загваруудын мэдээлэл

Загвар	Эх сурвалж	Төрөл	Хэрэглэгдэхүүн	Систем	Монголд хэрэглэгдэж байсан эсэх
DIGNAR-19	IMF	DSGE	Toolbox with codes and description.	Matlab23, Dynare 4.5.6, MS Excel, Windows, Mac	Li et al. (2017)
Mongolia Macro-Fiscal Model 2017	NRGI	Semi-structural	Toolbox with codes and description	Matlab17, Iris 2014, MS Excel, Mac Wind	Designed for Mongolia

Эх сурвалж: Загваруудын мэдээлэлд тулгуурлан боловсруулав.

DIGNAR загварын хувьд 2019 оныг суурь он гэж авсан бөгөөд загварыг ажиллуулахдаа:

- 1) Холбогдох программ хамгамжуудыг олж зүгшрүүлэх, туршилт хийх;
- 2) Шаардлагатай өгөгдлүүдийг тодорхойлж цуглуулах;
- 3) 2019 оныг суурь болгон Монголын өгөгдөлд үндэслэн тохируулга хийх (calibration);
- 4) Гадаад хүчин зүйлс буюу экзоген 14 хувьсагчдын түүхэн динамикт тулгуурлан ирэх гурван жилийн таамгийг боловсруулж оруулах;
- 5) Уул уурхайн салбарын экспортын мэдээлэлд үндэслэн, загварын онцлогт тохируулан уул уурхайн бүтээгдэхүүний экспортын багц хэмээх шинэ бүтээгдэхүүн үүсгэх;
- 6) Загвараа ажиллуулан нэр бүхий 21 макро, төсвийн хувьсагчийн 2020-2027 оны төсөөллийг гаргах;
- 7) 2020-2023 оны загварын төсөөллийг бодит биелэлттэй харьцуулах ажлыг гүйцэтгэв.

Харин макро, уул уурхай, төсөв гэсэн гурван үндсэн хэсэг бүхий NRGI-MMFM-ийн хувьд:

- 1) Холбогдох программ хамгамжуудыг олж суулгах, туршилт хийх;
- 2) Шаардлагатай өгөгдлүүдийг тодорхойлж, цуглуулах;
- 3) Макро хэсгийн суурь өгөгдлийг 2015 оноос 2023 он болгон засварлах, ийнхүү өгөгдөл шинэчилсэнтэй холбоотойгоор тэгшитгэлүүдийн коэффициентийг дахин үнэлэх, макро хэсэгт Хятад, АНУ, Европын холбооны өсөлт, инфляцын төсөөлөл, зэс, төмрийн хүдрийн үнийн төсөөллийг боловсруулах;
- 4) Уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байсан зургаан том аж ахуйн нэгжийн гүйцэтгэл болон төсөөлөлд суурилсан байсан хэсгийг тус салбарын гол бүтээгдэхүүн болох алт, зэс (тунгаамал болон баяжмал), нүүрс (хүрэн болон чулуун) болон төмрийн хүдэр гэсэн дөрвөн бүтээгдэхүүнд суурилсан болгож өөрчилсөн. Улмаар бүтээгдэхүүн тус бүрийн олборлолт болон үнийн таамгийг эконометрикийн шинжилгээнд тулгуурлан боловсруулах;
- 5) Уул уурхайн хэсгийг дээрх байдлаар өөрчилсөнтэй холбогдуулан тус салбараас төсөвт оруулах орлогыг дахин тооцох. төсвийн бусад орлого болон зардлыг мөн 2015 оноос хойшхи өгөгдлөөр дахин шинэчлэх ажлуудыг хийсэн болно³.

³ NRGI-MMFM-ийн уул уурхайн хэсгийг бид нэлээд өөрчилсөн тул энэ хувилбарыг NRGI-FSC-24 хэмээн нэрлэв.

Уул уурхайн секторын төсөөлөл

Аль аль загварын хувьд уул уурхайн орлогын төслөөлөл чухал орц бөгөөд бид экспортод эзлэх жинг нь харгалзан үзээд алт, зэс, нүүрс болон төмрийн хүдэр гэсэн дөрвөн бүтээгдэхүүний экспортлох биет хэмжээ болон үнийн таамгийг дараах байдлаар боловсруулав.

Биет хэмжээний төсөөлөл: Уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн биет хэмжээний төсөөллийг бүтээгдэхүүн тус бүрээр нэг хувьсагчийн ARIMA загвар болон олон хувьсагчийн VAR загвар ашиглан үнэлэв. ARIMA загвар нь тухайн цувааны болон үлдэгдлийн өнгөрсөн үеийн утгуудаас хамааруулан ирээдүйн утгыг таамагладаг. Нүүрснээс бусад бүтээгдэхүүний олборлолтын биет хэмжээг тоо баримт, өгөгдлийн чанар, олдоцоос хамааран экспортын биет хэмжээтэй тэнцүү гэж үзээд экспортын биет хэмжээний сарын давтамжтай өгөгдөл ашиглан боловсруулав. Нүүрсний хувьд олборлолт болон экспортын биет хэмжээний тоон мэдээлэл олдох боломжтой тул нүүрсний олборлолтын сарын давтамжтай тоон мэдээллийг ашигласан.

Хувьсагчдын тайлбар:

- Нүүрсний биет хэмжээ (DL_COAL)-ний төсөөллийг боловсруулахдаа ОУВС-аас гаргадаг Австрали болон Өмнөд Африкийн нүүрсний үнийн индекс (DL_COAL_PRICE_INDX), БНХАУ-ын аж үйлвэрлэлийн өсөлт (DL_IP_CN)-ийн цувааг ашиглав.
- Зэс (DL_COPPER) болон төмрийн хүдэр (DL_IRON)-ийн төсөөллийг боловсруулахдаа дэлхийн зах зээл дээрх суурь металлын үнийн индекс (DL_BASE_METAL_INDX), БНХАУ-ын аж үйлвэрлэлийн өсөлт (DL_IP_CN)-ийн цувааг ашиглав.
- Алт (DL_GOLD)-ны олборлолтын төсөөллийг боловсруулахдаа дэлхийн зах зээл дээрх үнэт металлын үнийн индекс (DL_PRECOIUS_INDX) болон АНУ-ын бодлогын хүү (DL_FED_RATE)-ний цувааг тус тус ашиглав.

Дараах хэсэгт бүтээгдэхүүн тус бүрийн хувьд үнэлсэн VAR загварын тэшитгэлийн үр дүнг харуулж байна⁴.

Нүүрс:

$$DL_COAL = -0.06*DL_COAL(-1) + 0.03*DL_COAL(-2) + 0.02*DL_COAL_PRICE_INDX(-1) - 0.18*DL_COAL_PRICE_INDX(-2) - 0.04*DL_IP_CN(-1) - 0.04*DL_IP_CN(-2) + 0.03$$

$$DL_COAL_PRICE_INDX = -0.004*DL_COAL(-1) - 0.001*DL_COAL(-2) + 0.40*DL_COAL_PRICE_INDX(-1) + 0.03*DL_COAL_PRICE_INDX(-2) - 0.001*DL_IP_CN(-1) + 0.005*DL_IP_CN(-2) + 0.001$$

$$DL_IP_CN = -0.02*DL_COAL(-1) + 0.08*DL_COAL(-2) + 1.36*DL_COAL_PRICE_INDX(-1) - 0.77*DL_COAL_PRICE_INDX(-2) - 0.32*DL_IP_CN(-1) - 0.12*DL_IP_CN(-2) - 0.009$$

Зэс:

$$DL_COPPER = -0.37*DL_COPPER(-1) - 0.24*DL_COPPER(-2) + 0.34*DL_BASE_METAL_INDX(-1) - 0.04*DL_BASE_METAL_INDX(-2) + 0.02*DL_IP_CN(-1) + 0.04*DL_IP_CN(-2) + 0.005$$

$$DL_BASE_METAL_INDX = -0.007*DL_COPPER(-1) - 0.006*DL_COPPER(-2) + 0.33*DL_BASE_METAL_INDX(-1) - 0.02*DL_BASE_METAL_INDX(-2) + 0.01*DL_IP_CN(-1) + 0.002*DL_IP_CN(-2) + 0.002$$

$$DL_IP_CN = 0.04*DL_COPPER(-1) - 0.08*DL_COPPER(-2) + 0.65*DL_BASE_METAL_INDX(-1) - 0.0006*DL_BASE_METAL_INDX(-2) - 0.16*DL_IP_CN(-1) - 0.13*DL_IP_CN(-2) - 0.007$$

⁴ VAR загварын үнэлгээг боловсруулахдаа хувьсагчдаас лог-ялгавар хувиргалт авч суурин процесс болгон ашиглав. Хувьсагчдын лагийн тоог сонгохдоо мэдээллийн шалгуурын аргаар сонгов. Үнэлсэн тэшитгэлүүдийн үлдэгдлүүдийн хооронд сериал корреляц байхгүй гэсэн тэг таамаглалыг хүлээн авсан болно.

Төмрийн хүдэр:

$$DL_IRON = -0.46*DL_IRON(-1) - 0.16*DL_IRON(-2) + 0.06*DL_BASE_METAL_INDX(-1) + 0.91*DL_BASE_METAL_INDX(-2) + 0.23*DL_IP_CN(-1) + 0.27*DL_IP_CN(-2) + 0.01$$

$$DL_BASE_METAL_INDX = -0.003*DL_IRON(-1) + 0.007*DL_IRON(-2) + 0.33*DL_BASE_METAL_INDX(-1) + 0.014*DL_BASE_METAL_INDX(-2) + 0.02*DL_IP_CN(-1) - 0.006*DL_IP_CN(-2) + 0.002$$

$$DL_IP_CN = -0.03*DL_IRON(-1) - 0.03*DL_IRON(-2) + 0.52*DL_BASE_METAL_INDX(-1) + 0.04*DL_BASE_METAL_INDX(-2) - 0.15*DL_IP_CN(-1) - 0.12*DL_IP_CN(-2) - 0.009$$

Алт:

$$DL_GOLD = -0.54*DL_GOLD(-1) - 0.39*DL_GOLD(-2) - 0.34*DL_GOLD(-3) - 0.04*DL_PRECOIUS_INDX(-1) - 0.02*DL_PRECOIUS_INDX(-2) - 0.01*DL_PRECOIUS_INDX(-3) - 0.6*DL_FED_RATE(-1) + 0.82*DL_FED_RATE(-2) + 0.3*DL_FED_RATE(-3) + 0.003$$

$$DL_PRECOIUS_INDX = 0.18*DL_GOLD(-1) - 0.43*DL_GOLD(-2) + 0.16*DL_GOLD(-3) + 0.13*DL_PRECOIUS_INDX(-1) - 0.09*DL_PRECOIUS_INDX(-2) - 0.1*DL_PRECOIUS_INDX(-3) - 1.9*DL_FED_RATE(-1) - 6.8*DL_FED_RATE(-2) + 2.3*DL_FED_RATE(-3) + 0.95$$

$$DL_FED_RATE = 0.004*DL_GOLD(-1) - 0.018*DL_GOLD(-2) - 0.019*DL_GOLD(-3) + 0.003*DL_PRECOIUS_INDX(-1) + 0.006*DL_PRECOIUS_INDX(-2) - 0.003*DL_PRECOIUS_INDX(-3) + 0.25*DL_FED_RATE(-1) + 0.07*DL_FED_RATE(-2) + 0.19*DL_FED_RATE(-3) - 0.001$$

Түүхий эдийн олборлолтын ARIMA загварын үр дүн**Хүснэгт 7. Зэсийн баяжмалын олборлолт: ARIMA (3, 4)**

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	4.76E-05	0.004024	0.011825	0.9906
AR(1)	-1.535668	0.085081	-18.04954	0.0000
AR(2)	-0.356073	0.161629	-2.203031	0.0286
AR(3)	0.299545	0.093123	3.216659	0.0015
MA(1)	0.107433	0.325995	0.329553	0.7421
MA(2)	-1.648684	6.022890	-0.273736	0.7845
MA(3)	-0.223234	1.310102	-0.170394	0.8649
MA(4)	0.764485	5.597105	0.136586	0.8915
SIGMASQ	210.6269	29.46363	7.148710	0.0000
R-squared	0.728261	Mean dependent var		0.014817
Adjusted R-squared	0.718289	S.D. dependent var		27.90226
S.E. of regression	14.80954	Akaike info criterion		8.310747
Sum squared resid	47812.31	Schwarz criterion		8.446538
Log likelihood	-934.2698	Hannan-Quinn criter.		8.365541
F-statistic	73.02996	Durbin-Watson stat		2.016219
Prob(F-statistic)	0.000000			

Хүснэгт 8. Алтны олборлолт: ARIMA (3, 2)

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	1.080867	0.186911	5.782775	0.0000
AR(1)	1.424134	0.054322	26.21658	0.0000
AR(2)	-1.330330	0.073083	-18.20306	0.0000
AR(3)	0.446851	0.043792	10.20391	0.0000
MA(1)	-1.049428	0.064766	-16.20338	0.0000
MA(2)	0.893432	0.069707	12.81698	0.0000
SIGMASQ	1.181472	0.114221	10.34375	0.0000

R-squared	0.204513	Mean dependent var	1.087135
Adjusted R-squared	0.183013	S.D. dependent var	1.221365
S.E. of regression	1.103959	Akaike info criterion	3.069241
Sum squared resid	270.5571	Schwarz criterion	3.174202
Log likelihood	-344.4281	Hannan-Quinn criter.	3.111584
F-statistic	9.512376	Durbin-Watson stat	2.053082
Prob(F-statistic)	0.000000		

Хүснэгт 9. Төмрийн хүдрийн олборлолт: ARIMA (4, 4)

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	2.376598	2.217936	1.071536	0.2851
AR(1)	0.510052	0.119120	4.281839	0.0000
AR(2)	-0.015068	0.028920	-0.521044	0.6029
AR(3)	-0.945877	0.030337	-31.17869	0.0000
AR(4)	0.498332	0.108253	4.603392	0.0000
MA(1)	-1.048931	0.110328	-9.507355	0.0000
MA(2)	0.318991	0.103942	3.068928	0.0024
MA(3)	0.638494	0.105556	6.048872	0.0000
MA(4)	-0.639725	0.066524	-9.616400	0.0000
SIGMASQ	10445.67	671.4455	15.55699	0.0000
R-squared	0.668124	Mean dependent var	2.614906	
Adjusted R-squared	0.654422	S.D. dependent var	177.8011	
S.E. of regression	104.5219	Akaike info criterion	12.19206	
Sum squared resid	2381612.	Schwarz criterion	12.34247	
Log likelihood	-1379.895	Hannan-Quinn criter.	12.25274	
F-statistic	48.76343	Durbin-Watson stat	2.005656	
Prob(F-statistic)	0.000000			


Хүснэгт 10. Нүүрсний олборлолт: ARIMA (3, 3)

Variable	Coefficient	Std. Error	t-Statistic	Prob.
C	17.33364	3.137202	5.525191	0.0000
AR(1)	0.561819	0.046832	11.99653	0.0000
AR(2)	-0.711247	0.037795	-18.81875	0.0000
AR(3)	0.763436	0.048671	15.68554	0.0000
MA(1)	-0.672821	19.06289	-0.035295	0.9719
MA(2)	0.672819	22.28291	0.030194	0.9759
MA(3)	-0.999998	61.03403	-0.016384	0.9869
SIGMASQ	350411.7	4570406.	0.076670	0.9389
R-squared	0.128436	Mean dependent var	22.00868	
Adjusted R-squared	0.106647	S.D. dependent var	635.1773	
S.E. of regression	600.3528	Akaike info criterion	15.68750	
Sum squared resid	1.01E+08	Schwarz criterion	15.78925	
Log likelihood	-2251.000	Hannan-Quinn criter.	15.72828	
F-statistic	5.894508	Durbin-Watson stat	1.973666	
Prob(F-statistic)	0.000002			


Нэг хувьсагчийн ARIMA загвар болон олон хувьсагчийн VAR загварын төсөөллийн үр дүнг дараах хэсэгт зургаар харуулав. Зэсийн баяжмалын олборлолт төсөөллийн хугацаанд алгуур нэмэгдэхээр байна. БНХАУ-ын аж үйлдвэрлэлийн салбарын өсөлт удаашрах хүлээлт олон улсын шинжээчдийн дунд үүсээд байгаа тул төмрийн хүдрийн олборлолтыг төсөөллийн хугацаанд аажмаар буурах VAR загварын үр дүнгээр авав. 2025 оноос Оюу

толгойн үйлдвэрлэл эрчимжих тэр дундаа зэсийн баяжмалын алтны агууламж нэмэгдэх хүлээлттэй байгаагаас үүдэн алтны олборлолтыг ARIMA загварын үр дүнгээр авлаа. Нүүрсний олборлолтыг 2024-2025 онд 2 загварын үр дүнгийн дунджаар, түүнээс хойш алгуур буурах байдлаар авч үзлээ.


Зураг 36. Зэсийн баяжмал, мян.тн




Зураг 37. Төмрийн хүдэр, мян.тн



Зураг 38. Алт, тн




Зураг 39. Нүүрс, мян.тн




Үнийн төсөөлөл: Түүхий эдийн үнийн төсөөллийг NRG1 загварын аргачлал⁵ болон бусад байгууллагын төсөөлөлд үндэслэн боловсруулав. Тодруулбал, нүүрсний үнэ 2023 оны гүйцэтгэлээр 2022 оны өндөр өсөлттэй үеэсээ буурсан бөгөөд Дэлхийн банк болон Австралийн Аж үйлдвэр, шинжлэх ухаан, нөөцийн байгууллагаас гаргасан төсөөллөөр нүүрсний үнэ 2024-2025 онд буурах хүлээлттэй байна. Манай улсын хувьд нүүрсийг биржээр борлуулахтай холбоотойгоор түүхэн дунджаас бага зэрэг өндөр байхаар буюу нүүрсний үнийн төсөөллийг тонн тутам нь 100 ам.долларын орчимд байхаар авч үзлээ. Дэлхий нийтээр ногоон шилжилтэд анхаарал хандуулж байгаатай холбоотойгоор зэсийн эрэлт өндөр байх хүлээлттэй тул зэсийн үнэ 2025 оноос алгуур нэмэгдэхээр байна. БНХАУ-ын аж үйлдвэрийн салбарын өсөлт удаашралтай байгаагаас үүдэн төмрийн хүдрийн эрэлт буурах хүлээлттэй тул төмрийн хүдрийн үнэ төсөөллийн хугацаанд буурахаар байна.

Зураг 40. Нүүрсний үнэ, ам.доллар/тн




⁵ Зэсийн үнийг ашиглан энергийн бус түүхий эдийн үнийн индексийг тооцож, энэхүү индексээ ашиглан бусад түүхий эдийн үнийг тооцно.


Зураг 41. Зэсийн үнэ, ам.доллар/тн



Зураг 42. Төмрийн хүдрийн үнэ, ам.доллар/тн



Зураг 43. Алтны үнэ, ам.доллар/унц



Бид дээр дурдсан таамаглал зохих 15 үзүүлэлтээс 10-ийг нь таамаглахдаа хоёр загварын хослолыг дараах байдлаар ашиглав.

Хүснэгт 11. Гардинерийн жагсаалт болон ТТБЗ-өөс гаргаж буй таамаглал

Төрөл	Хувьсагч	Модел 1 (DIGNAR)	Модел 2 (NRGI-FSC)
Макро	Бодит ДНБ-ий төсөөлөл	a	a
	Нэрлэсэн ДНБ	b	a
	Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн (зэс, нүүрс, төмрийн хүдэр, алт)-ий тоо хэмжээ, үнийн төсөөлөл	a, b	b, нүүрс, алтны үнийг загварын аргачлалыг ашиглан тооцсон.
	Гадаад валютын ханшийн төсөөлөл	b	a
Төсвийн орлого	Нийт орлогын нарийвчилсан төсөөлөл (нийт орлого ба буцалтгүй тусламж, тэнцвэржүүлсэн нийт орлого)	c	a
	Уул уурхайн орлого (ашигт малтмалаар), түүхэн болон ирээдүйн төсөөлөл	a	b
Төсвийн зарлага	Нийт зардал ба цэвэр зээлийн төсөөлөл	c	a
	Урсгал зардал (цалин хөлс, бусад орлого, татаас ба шилжүүлэг, хүүгийн төлбөр)-ын төсөөлөл	a (зарим нь c)	a
	Хөрөнгийн зардлын төсөөлөл	a, b	c
	Зээлийн болон эргэн төлөлтийн төсөөлөл	c	c
	ТӨҮГ-уудад олгох шилжүүлэг	c	c
Өр ба сангууд	Засгийн газрын өрийн (гадаад, дотоод) төсөөлөл	a, b	c
	Гадаад, дотоод зээлийн хүүгийн төлбөрийн төсөөлөл	c	c
	Төсвийн тогтворжуулалтын сан, Ирээдүйн өв сангийн орлого, зарлага, үлдэгдлийн төсөөлөл	c	c

Тайлбар: а) Загвараар тооцож гаргасан; b) Загварт гаднаас оруулж ашигласан; c) Аль нь ч биш буюу энэ төсөөлөл хийгдээгүй, ашиглагдаагүй.

4.3. DIGNAR ЗАГВАРЫН ТОХИРУУЛГА БА ЭКЗОГЕН ХУВЬСАГЧДЫН ТӨСӨӨЛӨЛ

Энэхүү загварын тохируулга нь үндэсний тооцоо, хүү, бүтцийн параметр, байгалийн нөөц болон төсөв гэсэн үндсэн 5 хэсгээс бүрддэг. DIGNAR-2019 нь ковидын онцлогийг тусгасан загвар тул тохируулга хийх суурь оныг 2019 оноор сонгосон. Хүснэгт 12-т Үндэсний тооцооны хэсгийн тохируулга утгуудыг харуулав. Тус хэсгийн тохируулгыг хийхдээ Үндэсний статистикийн хороо, Сангийн яам, Монголбанкны тоон мэдээллийн сан, Li, B. G., Gupta, P., J. Yu, (2017) нар болон олон улсын макро мэдээллийн CEICDATA сангийн тоон мэдээллийг ашигласан.

Хүснэгт 12. Үндэсний тооцооны хэсгийн тохируулга

Хувьсагчид	Тохируулга утга (хувиар)	Эх сурвалж
Эдийн засгийн өсөлт	5.5	Үндэсний статистикийн хороо
ДНБ-д экспортын эзлэх хувь	65.13	Үндэсний статистикийн хороо
ДНБ-д импортын эзлэх хувь	65.18	Үндэсний статистикийн хороо
ДНБ-д Засгийн газрын хэрэглээний эзлэх хувь	13.12	Үндэсний статистикийн хороо
ДНБ-д Засгийн газрын хөрөнгө оруулалтын эзлэх хувь	7.97	Үндэсний статистикийн хороо
ДНБ-д хувийн хөрөнгө оруулалтын эзлэх хувь	27.62	Үндэсний статистикийн хороо
ДНБ-д байгалийн нөөцийн нэмэгдсэн өртгийн эзлэх хувь	25.34	Үндэсний статистикийн хороо
ДНБ-д Засгийн газрын дотоод өрийн эзлэх хувь	1.23	Сангийн яам
ДНБ-д хувийн гадаад өрийн эзлэх хувь	74.24	Үндэсний статистикийн хороо
ДНБ-д Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн эзлэх хувь	2.9	Сангийн яам
ДНБ-д Засгийн газрын гадаад арилжааны зээлийн эзлэх хувь	30.1	Сангийн яам, Үндэсний статистикийн хороо
ДНБ-д гадаад буцалтгүй тусламжийн эзлэх хувь	0	Монголбанк
ДНБ-д Засгийн газрын нийт орлогын эзлэх хувь	28.82	Сангийн яам
ДНБ-д гадаад тусламжийн эзлэх хувь	0.39	Seicdata
Засгийн газрын нийт зардалд худалдааны салбарын эзлэх хувь	50	Li et al. (2017)
Өрхийн хэрэглээнд худалдааны салбарын эзлэх хувь	50	Li et al. (2017)
Худалдааны салбарын засгийн газрын зардалд байгалийн баялгийн бус худалдааны эзлэх хувь	50	Li et al. (2017)
Худалдааны салбарын өрхийн хэрэглээнд байгалийн баялгийн бус худалдааны эзлэх хувь	20	Li et al. (2017)

Дараах хүснэгтэд бодит хүүгийн хэсгийн тохируулга утгуудыг харуулав. Тус хэсгийн тохируулгын хийхдээ Үндэсний статистикийн хороо, Олон улсын мэдээллийн сан, Дэлхийн банкны тоон мэдээллийг ашиглав.

Хүснэгт 13. Бодит хүүгийн хэсгийн тохируулга

Хувьсагчид	Тохируулга утга (хувиар)	Эх сурвалж
Дотоодын бодит хүү	6.4	Дэлхийн банк
Хөнгөлөлттэй зээлд төлж буй бодит хүү	0	Li et al. (2017)
Гадаад эрсдэлгүй хөрөнгийн өгөөж (Америкийн Засгийн газрын бондын бодит хүү)	1.5	Morningstar, Дэлхийн банк
Засгийн газрын хөнгөлөлттэй зээлд төлж буй бодит хүү	2.9	Олон улсын валютын сан

Бүтцийн параметр болон байгалийн нөөцийн салбарын хэсгийн тохируулгыг Дэлхийн банк, Li et al. (2017), Үндэсний статистикийн хорооны Ажиллах хүчний судалгааны 2019 тайлан, Монголбанкны [Монгол Улсын өрхийн түүвэр судалгаа \(2023\)](#) судалгааг ашиглан хийсэн.

Хөдөлмөрийн зах зээлийн ирээдүйн хэрэглээгээ оновчилдог иргэдийн эзлэх хувийг түүвэр судалгаанд оролцсон дундаж, боломжийн, чинээлэг иргэдийн эзлэх хувийн нийлбэрээр тооцсон болно.

Хүснэгт 14. Бүтцийн параметрийн хэсгийн тохируулга

Хувьсагчид	Тохируулга утга	Эх сурвалж
Засгийн газрын хөрөнгө оруулалтын үр өгөөж	75	Дэлхийн банк
Хөдөлмөрийн зах зээлийн баян иргэдийн эзлэх хувь	35-50	Li et al. (2017)
Хөдөлмөрийн орлуулалтын мэдрэмж	0.53	Үндэсний статистикийн хороо
Худалдааны болон худалдааны бус салбарын орлуулалтын мэдрэмж	0.5	Li et al. (2017)
Худалдааны бус салбарын хөрөнгө оруулалтын тохируулгын зардлын параметр	25	Li et al. (2017)
Худалдааны салбарын хөрөнгө оруулалтын тохируулгын зардлын параметр	25	Li et al. (2017)
Худалдааны салбарын капиталын элэгдэл	10	Li et al. (2017)
Засгийн газрын капиталын элэгдэл	7	Li et al. (2017)

Дараах хүснэгтэд төсвийн болон байгалийн нөөцийн салбарын хэсгийн тохируулга утгуудыг харуулав. Тус хэсгийн тохируулгын хийхдээ Сангийн яамны тоон мэдээллийг ашиглав. Засгийн газрын дэд бүтэц ашигласны төлбөрийг татварын орлогын бусад төлбөр, хураамж хэсгийг нийт урсгал зардалд хувааж тооцов.

Хүснэгт 15. Төсвийн болон байгалийн нөөцийн салбарын хэсгийн тохируулга

Хувьсагчид	Тохируулга утга	Эх сурвалж
Засгийн газрын нийт орлогод эзлэх байгалийн нөөцийн орлогын хувь	6.5	Сангийн яам
Засгийн газрын нийт орлогод эзлэх Хүн амын орлогын албан татварын хувь	11.2	Сангийн яам
Засгийн газрын нийт орлогод эзлэх Хэрэглээний албан татварын хувь	31.7	Сангийн яам
Засгийн газрын дэд бүтцийг ашигласны төлбөр	11.1	Сангийн яам

Дээр дурдсанаас бусад энэхүү загварт ашигласан улаан болон цэнхэр өнгөөр тэмдэглэсэн тохируулга утгуудыг загварын анхны утгаар үлдээсэн болно.

DIGNAR-19 загварт байгалийн нөөцийн салбар, төсөв, нийтийн салбарын санхүүжилт, төлбөрийн баланс болон хөдөлмөрийн зах зээлтэй холбоотой нийт 5 бүлгийн 14 экзоген хувьсагч орц болж ашиглагдах бөгөөд үүнээс Засгийн газрын хөрөнгө оруулалт, хэрэглээ, шилжүүлэг, хөнгөлөлттэй зээл, ажилчдын гуйвуулга, экспорт, хөдөлмөрийн нийлүүлэлт зэрэг 7 хувьсагчийн 2024-2026 оны утгуудыг E-views програм ашиглан дараах AR болон ARMA, ARIMA буюу нэг хувьсагчийн хугацааны цувааны загварыг ашиглан таамагласан.

AR(p) загварын тэгшитгэл:

$$y_t = \mu + \varphi_1 y_{t-1} + \varphi_2 y_{t-2} + \dots + \varphi_p y_{t-p} + u_t$$

ARMA(p,q) загварыг тэгшитгэл:

$$y_t = \mu + \varphi_1 y_{t-1} + \varphi_2 y_{t-2} + \dots + \varphi_p y_{t-p} + \theta_1 u_{t-1} + \theta_2 u_{t-2} + \dots + \theta_q u_{t-q} + u_t$$

Харин d удаагийн ялгавар авсан хувьсагч дээр тулгуурласан ARMA(p,q) загварыг оригинал (ямар нэгэн хувиргалт хийгээгүй) хугацааны цувааны хувьд үнэлснийг ARIMA(p,d,q) загвар гэнэ. Мөн хувьсагчдын суурин эсэхийг өргөтгөсөн Дики Фуллер тест ашиглан шалгаж суурин бус хувьсагчдыг хувиргасан бөгөөд үнэлгээ хийсний дараа үлдэгдлийн шинжилгээг хийлээ.

Дотоодын нийт бүтээгдэхүүн: Энэхүү загварын тохируулга болон экзоген хувьсагчдын ихэнх нь ДНБ-д эзлэх хувиар илэрхийлэгддэг. Иймээс ДНБ-ий өсөлтийг Дэлхийн банкны таамагласнаар 2024 онд 6.1, 2025 онд 6 хувь, 2026 онд 6 хувь харин инфляцыг Trade ecomomics-ийн таамагласнаар 2024 онд 8.7, 2025 онд 6.5 хувь, 2026 онд 6 хувь байна хэмээн төсөөлж нэрлэсэн ДНБ-ий 2024-2026 оны утгыг тооцоолсон.


0. Байгалийн нөөцийн салбар

- *Байгалийн нөөцийн гарцын өсөлт:* Байгалийн нөөцийн ашиглалтын хэмжээг экспортын гол бүтээгдэхүүнүүд болох алт, зэс, төмрийн хүдэр, нүүрс гэсэн дөрвөн гол бүтээгдэхүүний гарцын өсөлтөөр тооцсон. 2024-2026 оны тоон утгуудыг NRG1 загварт ашигласан төсөөллөөр авлаа.
- *Нөөцийн үнэ:* Монгол Улсын экспортын гол бүтээгдэхүүний үнийн индексийг олон улсын түүхий эдийн үнийн индекст харьцуулж тооцсон. Гэсэн хэдий ч Монгол Улсын хувьд зөвхөн 2022-2023 оны мэдээлэл байгаа тул тус индексийг экспортын⁶ дундаж үнийн өсөлтөөр нэмэгддэг гэсэн таамаглал дэвшүүлж, 2019-2021 оны утгуудыг нөхөн тооцсон. Цаашлаад загварын мэдрэг байдлаас хамааран Ходрик-Прескоттын филтер ашиглан харьцангуй үнийн индексийн тренд болон шокийг салгаж тренд утгыг загвартаа оруулсан.

1. Төсвийн үзүүлэлтүүд

- *Засгийн газрын хөрөнгө оруулалт:* Энэхүү хувьсагч нь суурин бус байсан тул логарифм болон нэгдүгээр эрэмбийн ялгавар авч суурин болгоод AR(3) загвараар үнэлсэн. Энэхүү загварын таамаглалын sMAPE=8.03 байна. Засгийн газрын хөрөнгө оруулалт 2025 онд буурах, 2026 онд өсөх төлөвтэй байна.

Зураг 44. Засгийн газрын хөрөнгө оруулалтын төсөөлөл (2024-2026)




- *Засгийн газрын хөрөнгө оруулалтын өгөөж:* Засгийн газрын хөрөнгө оруулалтын үр өгөөжийг барилга болон тоног төхөөрөмжид оруулсан Засгийн газрын хөрөнгө оруулалтыг нийт Засгийн газрын хөрөнгө оруулалтад хувааж тооцсон.

⁶ Байгалийн нөөцийн үнийг экспортын гол дөрвөн бүтээгдэхүүний экспортод эзлэх хувиар багцалж дундаж үнийг тооцоолсон.

- *Засгийн газрын хэрэглээ:* Энэхүү хувьсагч нь суурин бус байсан тул логарифм болон нэгдүгээр эрэмбийн ялгавар авч суурин (стационар) болгож AR(2) загвараар үнэлсэн. Энэхүү загварын таамаглалын sMAPE=0.77 байна. Засгийн газрын хэрэглээ нь 2025-2026 онд өсөх төлөвтэй байна.

Зураг 45. Засгийн газрын хэрэглээний төсөөлөл (2024-2026)



- *Засгийн газрын шилжүүлэг:* Энэхүү хувьсагч нь суурин бус байсан тул логарифм болон нэгдүгээр эрэмбийн ялгавар авч суурин болгож AR(2) загвараар үнэлсэн ба таамаглалын sMAPE=3.54 байна. Засгийн газрын шилжүүлэгт тэтгэврээс бусад нийгмийн шилжүүлгийг оруулсан. Учир нь ахмад настны тэтгэвэр нь DIGNAR-19 моделийн хөдөлмөрийн зах зээлд загварчлагдаагүй болно.

Зураг 46. Засгийн газрын шилжүүлэг (халамж зардал)-ийн төсөөлөл (2024-2026)




- *Нэмэгдсэн өртгийн албан татварын өөрчлөлтийн хувь:* НӨАТ-ын татварын хувь хэмжээ нь 2019 оноос хойш өөрчлөгдөөгүй тул 2019-2026 оны татварын өөрчлөлтийн хувийг 0 байхаар загварт оруулсан.
- *Хүн амын орлогын албан татварын өөрчлөлтийн хувь:* 2023 онд ХАОАТ-ын хувь хэмжээг орлогын хэмжээнээс хамааруулан шатлалтайгаар тогтоосон бол 2024 онд хувиараа бизнес эрхлэгчдээс авах ХХОАТ-ыг 1 хувь болгож бууруулсан. Иймээс Монголбанкны өрхийн түүвэр судалгааны ядуу, эмзэг, дундаж, боломжийн, чинээлэг иргэдийн эзлэх хувь болон хувиараа хөдөлмөр эрхлэгчид болон бусад ажилчдын тоог ашиглан жигнэсэн дундаж ХХОАТ-ыг ойролцоогоор тооцсон⁷.

⁷ Тус үзүүлэлтийг тооцоход шаардлагатай нарийн тоон мэдээлэл олдоогүй болно.

2. Нийтийн салбарын санхүүжилттэй холбоотой үзүүлэлтүүд

- *Буцалтгүй тусламжийн орлого:* Монголбанкны статистик тоон мэдээллийн санд мэдээлснээр 2019-2024 онд буцалтгүй тусламжийн орлого 0 байсан. Иймд буцалтгүй тусламжийн орлогыг 0 байхаар төсөөлөв.
- *ДНБ-д эзлэх хөнгөлөлттэй зээлийн хувь:* Энэхүү хувьсагч нь суурин бус байсан тул логарифм болон нэгдүгээр эрэмбийн ялгавар авч суурин болгож AR(4) загвараар үнэлсэн ба таамаглалын sMAPE=2.06 байна. Засгийн газрын хөнгөлөлттэй зээл нь 2025-2026 онд буурах төлөвтэй байна.

Зураг 47. Засгийн газрын хөнгөлөлттэй зээлийн төсөөлөл (2024-2026)




- *Эрсдэлийн урамшуулал:* Энэхүү үзүүлэлтийн 2019-2023 оны гүйцэтгэл болон 2024-2026 оны төсөөллийг Олон улсын валютын сангийн тооцооллоор авсан.

3. Төлбөрийн баланстай хамааралтай хувьсагчид


- *ДНБ-д эзлэх ажилчдад олгох мөнгөн гуйвуулгын хувь:* Энэхүү хувьсагч нь суурин бус байсан тул логарифм болон нэгдүгээр эрэмбийн ялгавар авч суурин болгож AR(2) загвараар үнэлсэн. Энэхүү загварын таамаглалын sMAPE=3.54 байна. Ажилчдад олгох мөнгөн гуйвуулга нь 2025-2026 онд бага зэрэг өсөх төлөвтэй байна.

Зураг 48. Ажилчдад олгох мөнгөн гуйвуулгын төсөөлөл (2024-2026)



- *ДНБ-д экспортын эзлэх хувь:* Экспортын 2024-2026 оны утгуудыг төсөөлөхдөө 2005-2023 оны улирлын тоон мэдээллийг ашиглав. Энэхүү хувьсагч нь суурин бус байсан тул логарифм болон нэгдүгээр эрэмбийн ялгавар авч суурин болгож ARMA(13,5) загвараар үнэлсэн. Загварын хувьсагчдын хоцрогдлын зэргийг Мэдээллийн шалгуурын аргаар тодорхойлсон ба таамаглалын sMAPE=15.22 байна. Экспортын хэмжээ 2025-2026 онд өсөх төлөвтэй байна.


Зураг 49. Экспортын төсөөлөл (2024-2026), улирлаар



4. Хөдөлмөрийн зах зээл

- *Хөдөлмөрийн нийлүүлэлт буюу ажиллах хүчний оролцооны түвшин:* Ажиллах хүчний оролцооны түвшнийг ARIMA загвараар үнэлсэн ба тус үзүүлэлт 2025-2026 онд буурах төлөвтэй байна.

Зураг 50. Ажиллах хүчний оролцооны түвшний төсөөлөл (2024-2026)



4.4. NRG1-FSC24 ЗАГВАРТ АШИГЛАСАН УУЛ УУРХАЙН САЛБАРААС ТӨВЛӨРӨХ ТӨСВИЙН ОРЛОГЫН ТӨСӨӨЛӨЛ

Алт, зэс, нүүрс, төмрийн хүдэр зэрэг голлох эрдэс бүтээгдэхүүнээс төсөвт 2016 оноос хойш төвлөрүүлсэн орлого болон эдгээрийн экспортын орлогын хамааралд үндэслэн ирээдүйд бий болох төсвийн орлогын төсөөллийг боловсрууллаа. Хувьсагчдын урт хугацааны хамаарлыг F Bound тестээр шалгасан бөгөөд зэс, нүүрс, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүнээс бүрдсэн төсвийн орлого болон экспортын орлого урт хугацааны хамааралтай гэж гарсан тул урт хугацааны хамааралтай хувьсагчдын хамаарлыг үнэлэхэд түлхүү ашиглагдах ARDL (auto regressive distributed lag) загварыг ашиглав⁸. Энэхүү загвар нь богино болон урт хугацааны хамаарлын аль алиныг харуулдаг онцлогтой. Алтны борлуулалтаас олох төсвийн болон экспортын орлого урт хугацааны хамааралгүй гэж гарсан тул алтны экспортын болон төсвийн орлогын богино хугацааны хамаарлыг энгийн хамгийн бага квадратын аргаар үнэллээ.

Дараах хэсэгт үнэлсэн тэгшитгэлийн үр дүнг бүтээгдэхүүн тус бүрээр харууллаа (Үр дүнгийн дэлгэрэнгүйг хавсралтаас үзнэ). Нүүрс, зэс, төмрийн хүдрийн тодруулсан параметрууд нь урт хугацааны хамаарлыг илэрхийлэх утга юм. Тухайлбал:

- Нүүрсний экспортын орлого (L_E_COAL) 1 хувиар нэмэгдэхэд нүүрснээс бий болох төсвийн орлого (L_B_COAL) 1.05 хувиар нэмэгддэг.
- Зэсийн экспортын орлого (L_E_COPPER) 1 хувиар нэмэгдэхэд зэсээс бий болох төсвийн орлого (L_B_COPPER) 1.5 хувиар нэмэгддэг.
- Төмрийн хүдрийн экспортын орлого (L_E_IRON) 1 хувиар нэмэгдэхэд төмрийн хүдрээс бий болох төсвийн орлого (L_B_IRON) 1.5 хувиар нэмэгддэг.
- Алтны экспортын орлого (L_E_GOLD) 1 хувиар нэмэгдэхэд алтнаас бий болох төсвийн орлого (L_B_GOLD) 0.6 хувиар нэмэгддэг.

Нүүрс:

$$L_B_COAL = 3.3 + 1.05 * L_E_COAL$$

Зэс:

$$L_B_COPPER = 13.3 + 1.5 * L_E_COPPER$$

Төмрийн хүдэр:

$$L_B_IRON = 12.8 + 1.5 * L_E_IRON$$

Алт:

$$L_B_GOLD = 3.9 + 0.6 * L_E_GOLD$$

Эдгээр үнэлэгдсэн коэффициентуудын утгууд болон экспортын орлогын төсөөллийг ашиглан төсөөлөх хугацаанд уул уурхайн салбараас бий болох төсвийн орлогын төсөөллийг тооцлоо.

Хүснэгт 16. Уул, уурхайн салбар орлого, татварын төрлөөр

CIT	Royalty	Other
Gold	21%	Gold 67% Gold 12%
Coking coal	34%	Coking coal 55% Coking coal 11%
Iron ore	22%	Iron ore 63% Iron ore 15%
Copper ore	28%	Copper ore 52% Copper ore 23%

⁸ Тэгшитгэлийн ерөнхий хэлбэр: $D(L_Y) = \alpha_0 + \alpha_1 * D(L_X) - \delta * (L_Y(-1)) - (\beta_1 * L_X(-1)) - \beta_0$

Уул уурхайн салбараас бий болж буй төсвийн орлогыг дотор нь аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, АМНАТ болон бусад гэсэн 3 үндсэн ангилалд задлах боломжтой. Энэхүү задаргааг тооцоходоо нийт төсвийн орлогод бүтээгдэхүүн бүрээс төвлөрөх орлогын эзлэх хувийг ашиглалаа.

4.5. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮДИЙН 2024 ОНЫ ХҮЛЭЭГДЭЖ БУЙ ГҮЙЦЭТГЭЛ, 2025-2027 ОНЫ ТААМАГЛАЛ

Монгол Улсын дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулахад ашиглах макро эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийн 2024 оны хүлээгдэж буй гүйцэтгэл, цаашдын таамаглалыг DIGNAR, NRG1-FSC24 загварыг ашиглан тооцоход дараах байдалтай байна.

Хүснэгт 17. DIGNAR загварын төсөөлөл

Хувьсагч	2024		2025		2026	
Бодит ДНБ-ний төсөөлөл (өсөлтөөр) ^a	7.1%		5.9%		7.3%	
Нэрлэсэн ДНБ ^b /сая төг./	77,548,621.38		84,424,676.60		91,665,412.17	
Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн (зэс, нүүрс, төмрийн хүдэр, алт)-ий тоо хэмжээ, үнийн төсөөлөл ^{a,b}	Хэмжээ	\$/т	Хэмжээ	\$/т	Хэмжээ	\$/т
	1539 м.т	1901.50	1607 м.т	1977.73	1691 м.т	1969.76
	58496 м.т	122.16	50664 м.т	132.2802606	52208 м.т	120.14
	6865 м.т	105.18	6757 м.т	104.78	6792 м.т	103.54
	11.5 т	67,902,732.28	12.95т	68,326,136.16	12.96т	69,486,932.31
Гадаад валютын ханшийн төсөөлөл ^a (бодит ханш, 2019 онтой харьцуулсан % өөрчлөлт)	0.75		0.05		-4.79	
Уул уурхайн орлого (ДНБ-д эзлэх %)-ын ирээдүйн төсөөлөл ^a	6.59		6.71		6.47	
Урсгал зардал ба шилжүүлгийн төсөөлөл ^a /2019 оны ДНБ-д эзлэх хувьтай харьцуулахад хувьд гарах өөрчлөлт/	0.87		1.08		1.83	
	0.21		0.33		0.13	
Хөрөнгийн зардлын төсөөлөл ^{a,b} /2019 оны ДНБ-д эзлэх хувьтай харьцуулахад хувьд гарах өөрчлөлт/	-1.09		-1.99		-0.33	
Засгийн газрын өрийн (гадаад, дотоод) төсөөлөл ^{a,b} /2019 оны ДНБ-д эзлэх хувьтай харьцуулахад хувьд гарах өөрчлөлт/	2.95		2.87		2.06	
	2.43		2.72		4.00	

Тайлбар а) загвар өөрөө тооцсон, б) загварт тооцож оруулсан.

Хүснэгт 18. NRG1-FSC24 загварын тооцоолол


Хувьсагч	2024		2025		2026		2027	
Бодит ДНБ-ний төсөөлөл ^а /өсөлтийн %/	5.36		6.71		7.69		7.61	
Нэрлэсэн ДНБ ^а /тэрбум төг/	87,858.7		101,000		116,000		133,000	
Экспортын гол нэрийн бүтээгдэхүүн (зэс, нүүрс, төмрийн хүдэр, алт)-ий гоо хэмжээ, үнийн төсөөлөл ^б	Тоо	\$/т	Тоо	\$/т	Тоо	\$/т	Тоо	\$/т
	1,539 м.тн	1,688	1,607 м.тн	1,765.53	1,691 м.тн	1,761.75	1,761.75 м.тн	1,847.55
	58,496 м.тн	104.4	50,664 м.тн	106.88	52,208 м.тн	105.8	49,489.45 м.тн	107.7
	6,865 м.тн	105.18	6,514 м.тн	101.14	6,240 м.тн	95.76	6,016.56 м.тн	94.3
	11.5 тн	67,902,732.28	12.95тн	68,326,136.16	12.96тн	69,486,932.31	12.96тн	69,465,013.17
Гадаад валютын ханшийн төсөөлөл ^а	3,379.8		3,458.1		3,556.1		3,637.1	
Нийт орлогын нарийвчилсан төсөөлөл ^а /тэрбум төг/	23,693.6		26,170.2		28,360.1		31,123.2	
Уул уурхайн орлогын ирээдүйн төсөөлөл ^б /тэрбум төг/	6,412.2		6,804.2		6,747.3		7,068.2	
Нийт зардлын төсөөлөл ^а /тэрбум төг/	26,116.1		28,947.6		32,119.8		35,527.0	
Хүүгийн төлбөрийн төсөөлөл ^а /тэрбум төг/	1,173.6		1,173.6		1,173.6		1,173.6	
Цэвэр зээлийн төсөөлөл ^а /тэрбум төг/	3,536,562.5		4,920,434.78		6,657,058.82		8,083,571.43	

Тайлбар: а) Загвар тооцож гаргасан, б) Загварт тооцож оруулсан.

NRG1 загварын макро блок

Хагас бүтцийн макро эдийн засгийн загвар ашиглан макро эдийн засгийн гол үзүүлэлтүүдийн төсөөллийг боловсрууллаа. Энэхүү загвар нь үндсэндээ 6 гол дэд хэсгээс бүрдэх бөгөөд загварын тэгшитгэлүүдийг өөр хоорондын онолын уялдаа, хамааралд үндэслэн тодорхойлсон байна.

Калман филтерийн тусламжтайгаар загварын бүх хувьсагчид зөрүү болон тренд гэсэн хэсэгт хуваагдана. Трендийн тэгшитгэлүүд ихэвчлэн өөрийн өмнөх үеийн утга болон тэнцвэрт төлвийн утгаас хамаарсан хэлбэртэй байна. Учир нь эдийн засагт ямар нэг шок үүсэхгүй тохиолдолд хувьсагчдын зөрүү хэсэг тэг болж, урт хугацааны тренд нь тогтвортой төлвийн утга руугаа дөхөх юм. Харин зөрүүний тэгшитгэлүүд нь өөрийн өмнөх болон дараа үеийн утга, бусад тайлбарлагч хувьсагчдаас хамаарсан хэлбэртэй байна. Эдийн засгийн агентууд өнгөрсөн болон ирээдүйн нөхцөл байдлаас хамааран одоогийн шийдвэр гаргадаг тул ийнхүү загварчилжээ. Дараах зурагт харуулсанчлан бодит утгын тренд утгаасаа өөрчлөгдөж буй хэсгийг зөрүү гэж үзнэ.



Загварын гол бүрэлдэхүүн:

- *Эрэлтийн муруй:* Бодит ДНБ-ийг эцсийн хэрэглээ болон үйлдвэрлэл талаас задлан төсөөлнө. Тухайлбал, ДНБ-ий эцсийн хэрэглээний зөрүүг өөрийнх нь лаг болон хүлээлт, бодит хүүний зөрүү, хөдөлмөрийн орлогын зөрүү, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зөрүүнээс хамааруулан загварчилсан. Бодит хүүний зөрүү нэмэгдэх нь хэрэглээ, хөрөнгө оруулалтын зардлыг өсгөх тул агентууд хэрэглэхээс илүүтэй хадгалах шийдвэр гаргах тул эцсийн хэрэглээ, хөрөнгө оруулалт бодит хүүнээс урвуу хамааралтай байна.
- *Филлипсийн муруй:* Инфляц нь лаг, хүлээлт, гадаад инфляц, бодит ханш, хэрэглээ, хүнс, шатахууны харьцангуй үнээс хамаарна. Тухайлбал, хэрэглээний зөрүү эерэг байх нь эрэлтийн шалтгаантай инфляцыг нэмэгдүүлнэ. Гадаад улсуудын инфляц өсөх, бодит ханш сулрах зэрэг нь импортын барааны үнийг өсгөх замаар дотоодын үнийг өсгөнө.
- *Мөнгөний бодлогын дүрэм:* Бодлогын хүү нь лаг, хүлээлт, ханш, инфляц, үйлдвэрлэлийн зөрүүнээс хамаарна. Тухайлбал, инфляц зорилтот түвшнээс өндөр тохиолдолд бодлогын хүү өснө. Бодлогын хүү өссөнөөр бодит хүү өсч улмаар зээл санхүүжилтийн нөхцөл чангарч хэрэглээ, хөрөнгө оруулалтыг хумих замаар үнийн өсөлтийг бууруулна.
- *Нэрлэсэн хани ба UIP блок:* Ханш нь гадаад, дотоод хүү, эрсдлийн урамшууллаас хамаарна. Тухайлбал, гадаад хүү өсөх нь хөрөнгийн гадагшлах урсгалыг өдөөж, ханш сулрах дарамтыг нэмэгдүүлнэ. Ханш сулрах нь үнийн өсөлтийн шалтгаан болно.

- *Хөдөлмөрийн блок:* Хөдөлмөрийн зах зээлийн гол үзүүлэлт болох ажил эрхлэлт, цалингийн хэсгийг үйлдвэрлэлийн зөрүүний бүрэлдэхүүн хэсгүүдээс хамааруулан загварчилсан. Тухайлбал, уул уурхайн салбарын үйлдвэрлэлийн зөрүү эерэг байх нь энэ салбарын үйлдвэрлэл эрчтэй байгааг илтгэх бөгөөд үйлдвэрлэлд шаардагдах хөдөлмөрийн эрэлт нэмэгдсэнээр ажил эрхлэлт, цалин өсөх нөлөө бий болно. Энэ нь эргээд хөдөлмөрийн орлогыг тэтгэх байдлаар хэрэглээ, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, цаашлаад үнийн өсөлтөд нөлөө үзүүлнэ.
- *Гадаад блок:* БНХАУ, Европын холбоо, АНУ зэрэг улсуудын үйлдвэрлэл, инфляцын тооцооллыг ашиглан гадаад эрэлт, инфляцыг загварчилсан байна. Тухайлбал, гадаад эрэлт өндөр байх нь уул уурхайн салбарын үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх замаар эдийн засгийн идэвхжилд эергээр нөлөөлнө.

NRGI загварын төсвийн блок

Уул уурхай болон макро блокын төсөөллийг ашиглан төсвийн блокын төсөөлөл хийгдэнэ. Төсвийн орлого, зарлагын гол бүрэлдэхүүнүүдээр задлан төсөөлнө.

Төсвийн орлогын хэсэг нь ААНОАТ, ХХОАТ, НӨАТ, ОАТ зэрэг татварын орлого, хөрөнгийн орлого, урсгал шилжүүлэг, бусад орлого гэсэн хэсгүүдэс бүрдэнэ. ААНОАТ, бусад орлого гэсэн хэсгүүд нь уул уурхай болон уурхайн бус гэсэн хэсгүүдээс бүрдэнэ. Уул уурхайн бус төсвийн орлогын бүрдлүүдийн төсөөллийн аргачлалын товч тайлбар:

- Бусад орлого хэсгийн уул уурхайн бус орлогын төсөөлөл нь ДНБ-д уул уурхайгаас бусад салбарын эзлэх орлогын хэсгийн хувийг ашиглан тооцно.
- ААНОАТ-ын уул уурхайн бус төсвийн орлогын хэсгийг уул уурхай, хөдөө аж ахуйгаас бусад салбарын ДНБ-ий дефлятор, цэвэр үйл ажиллагааны илүүдэл (орлогын аргаар тооцсон ДНБ-ийг ашиглана), ААНОАТ-ын хувь зэрэг үзүүлэлтийг ашиглан тооцно.
- ХХОАТ-ыг төсөөлөхдөө нийт цалин хөлсний зардал, цалин хөлсний зардалд эзлэх ХХОАТ-ын хувь болон бусад нэмэлт тооцооллыг ашиглана.
- НӨАТ төсөөлөхдөө хувийн хэрэглээ, Засгийн газрын хэрэглээ, Засгийн газрын дотоод хөрөнгө оруулалт буюу хөрөнгийн зардал, татварын хувийг ашиглан тооцно.
- ОАТ-ын төсөөллийг боловсруулахдаа хувийн хэрэглээ болон ОАТ-ын хувийн хэрэглээнд эзлэх дундаж хувийг ашиглан тооцно.

Төсвийн зарлагын хэсэг нь төрийн албан хаагчдын цалин хөлсний зардал, татаас шилжүүлэг, бараа үйлчилгээний худалдан авалт, хөрөнгийн зардал, хүүгийн төлбөр гэсэн хэсгүүдээс бүрдэнэ.

- Төрийн албан хаагчдын цалин хөлсний зардлыг тооцохдоо Засгийн газрын хэрэглээ, дундаж цалин, ажиллагсдын тоо зэрэг үзүүлэлтийг ашиглан тооцно.
- Бараа үйлчилгээний худалдан авалтыг Засгийн газрын хэрэглээ, Засгийн газрын капиталын хэрэглээ, ажиллагсдын нөхөн олговор зэргийг ашиглан тооцно.
- Хөрөнгийн зардлыг тооцохдоо хөрөнгийн зардал болон нийт капиталын хуримтлалд хөрөнгийн зардлын эзлэх хувийг ашиглан тооцно.
- Хүүгийн төлбөрийг 2024 оны батлагдсан төсөвт туссан дүнгээр авав.

ЭХ СУРВАЛЖ

- International Energy Agency. (2023). *Coal 2023 Analysis and forecast to 2026*. Masdar: International Energy Agency.
- Office of the Chief Economist. (2023). *resources-and-energy-quarterly-december-2023-forecast-data*. Sydney: Australian Government Department of Industry and Resource.
- S&P Global. (2024 оны 02 04). *S&P Global*. S&P Global Market Intelligence: <https://www.spglobal.com/marketintelligence/en/news-insights/latest-news-headlines/china-s-coal-imports-to-stay-high-in-2024-after-record-breaking-q4-2023-80251799>-ээс Гаргасан
- Statista. (2024 оны 03 03). <https://www.statista.com/>. Statista Price and Access: <https://www.statista.com/statistics/779868/forecasted-price-of-coking-coal-by-type/#:~:text=It%20is%20forecast%20that%20the,per%20metric%20ton%20that%20year.-ээс Гаргасан>
- The coal hub. (2023 оны 5 10). *The Coal Hub Industry Portal*. The coal hub: <https://thecoalhub.com/report-presentation/coal-price-and-fx-market-forecasts-11>-ээс Гаргасан
- TM. (2024 оны 03 06). <https://www.consensuseconomics.com/>. Consensus Economics: <https://www.consensuseconomics.com/what-are-consensus-forecasts/>-ээс Гаргасан
- WBG. (2022). *Drivers of aluminum and copper prices*. Washington D.C: WBG.
- Гардинер, П. (2021). *Монгол Улсад Засаглалын Бэхжүүлэх нь Төсөл: Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөл. SGM 11-002 төслийн тайлан*. Улаанбаатар: ТТБЗ.
- Дэлхийн банк. (2022/4). *Монголын Эдийн Засгийн тойм /Шуурган дунд зүг чигээ олохуй/*. Улаанбаатар: Дэлхийн банк.
- Дэлхийн банк. (2023/11). *Монголын Эдийн Засгийн тойм*. Улаанбаатар: Дэлхийн банк.
- Дэлхийн банк. (2023/12). *Монгол Улсын Гадаад Худалдааны Өрсөлдөх Чадварын Шинжилгээ*. Улаанбаатар: Дэлхийн банк.
- Судалгааны баг. (2023). *Монгол Улсын Төсвийн Шинжилгээ*. Улаанбаатар: Кост Менежмент ХХК.
- СЭЗИС. (2024). *Уул уурхайн салбар, түүнд оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө*. Улаанбаатар: СЭЗИС.
- ТТБЗ. (2024). *Монгол Улсын Макро эдийн засгийн төлөв*. Улаанбаатар: ТТБЗ.
- ҮСХ. (2024). *Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2023.XII*. Улаанбаатар: ҮСХ.
- ҮСХороо. (2024 оны 03 12). *Үндэсний Статистикийн Хороо*. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: <https://1212.mn/mn>-ээс Гаргасан
- Annett, A. (2006). *Enforcement and the Stability and Growth Pact: How Fiscal Policy Did and Did Not Change Under Europe's Fiscal Framework*, IMF Working Papers, No 2006/116.
- Baksa, D., Mihalyi, D. and Romhanyi, B. (2016) *Monoglia Macro-Fiscal Model: Model Guide*. NRGi web site.
- International Energy Agency. (2023). *Coal 2023 Analysis and forecast to 2026*. Masdar: International Energy Agency.
- Melina, G., Yang, S-C S., L-F. Zanna (2016) *Debt sustainability, public investment, and natural resources in developing countries: The DIGNAR model*, *Economic Modelling* (52): 630-649.

- Leal, T., Pérez, J. J., Tujula, M., and J-P. Vidal (2008) Fiscal Forecasting: Lessons from the Literature and Challenges, *Fiscal Studies*, 29(3): 347-386.
- Li, B. G., Gupta, P. and J. Yu, (2017) From natural resource boom to sustainable economic growth: Lessons from Mongolia, *International Economics*, 151: 7-25.
- Office of the Chief Economist. (2023). *resources-and-energy-quarterly-december-2023-forecast-data*. Sydney: Australian Government Department of Industry and Resource.
- Pina, A. and Venes, N. (2011). The political economy of EDP fiscal forecasts: An empirical assessment, *European Journal of Political Economy*, 27(3): 534-546.
- S&P Global. (2024 оны 02 04). *S&P Global*. S&P Global Market Intelligence: <https://www.spglobal.com/marketintelligence/en/news-insights/latest-news-headlines/china-s-coal-imports-to-stay-high-in-2024-after-record-breaking-q4-2023-80251799-ээс> Гаргасан
- Statista. (2024 оны 03 03). <https://www.statista.com/>. Statista Price and Access: <https://www.statista.com/statistics/779868/forecasted-price-of-coking-coal-by-type/#:~:text=It%20is%20forecast%20that%20the,per%20metric%20ton%20that%20year.-ээс> Гаргасан
- The coal hub. (2023 оны 5 10). *The Coal Hub Industry Portal*. The coal hub: <https://thecoalhub.com/report-presentation/coal-price-and-fx-market-forecasts-11-ээс> Гаргасан
- TM. (2024 оны 03 06). <https://www.consensuseconomics.com/>. Consensus Economics: <https://www.consensuseconomics.com/what-are-consensus-forecasts/-ээс> Гаргасан
- WBG. (2022). *Drivers of aluminum and copper prices*. Washington D.C: WBG.
- Гардинер, П. (2021). *Монгол Улсад Засаглалын Бэхжүүлэх нь Төсөл: Төсвийн Тогтвортой Байдлын Зөвлөл. SGM 11-002 төслийн тайлан*. Улаанбаатар: ТТБЗ.
- Дэлхийн банк. (2022/4). *Монголын Эдийн Засгийн тойм /Шуурган дунд зүг чигээ олохуй/*. Улаанбаатар: Дэлхийн банк.
- Дэлхийн банк. (2023/11). *Монголын Эдийн Засгийн тойм*. Улаанбаатар: Дэлхийн банк.
- Дэлхийн банк. (2023/12). *Монгол Улсын Гадаад Худалдааны Өрсөлдөх Чадварын Шинжилгээ*. Улаанбаатар: Дэлхийн банк.
- Судалгааны баг. (2023). *Монгол Улсын Төсвийн Шинжилгээ*. Улаанбаатар: Кост Менежмент ХХК.
- СЭЗИС. (2024). *Уул уурхайн салбар, түүнд оруулсан гадаадын шууд хөрөнгө оруулалтын Монгол Улсын нийгэм, эдийн засагт үзүүлэх нөлөө*. Улаанбаатар: СЭЗИС.
- ТТБЗ. (2024). *Монгол Улсын Макро эдийн засгийн төлөв*. Улаанбаатар: ТТБЗ.
- ҮСХ. (2024). *Монгол Улсын нийгэм, эдийн засгийн байдал 2023.XII*. Улаанбаатар: ҮСХ.
- ҮСХ. (2024 оны 03 12). *Үндэсний Статистикийн Хороо*. Статистикийн мэдээллийн нэгдсэн сан: <https://1212.mn/mn-ээс> гаргасан

ХАВСРАЛТ

Хавсралт 1. ДНБ, эдийн засгийн салбарын ангиллаар (2022, 2023 он)

Эдийн засгийн үйл ажиллагааны салбарын ангилал	2022		2023	
	ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр сая төгрөг	Өсөлт, бууралт (хувь)	ДНБ, 2015 оны зэрэгцүүлэх үнээр сая төгрөг	Өсөлт, бууралт (хувь)
Бүгд	28,455,108.60	5.0	30,453,508.60	7.0
Хөдөө аж ахуй, ойн аж ахуй, загас барилт, ан агнуур	4,252,405.60	1.7	3,873,867.60	-1.3
Уул уурхай, олборлолт	3,133,197.60	-2.1	3,867,011.90	2.6
Боловсруулах үйлдвэрлэл	2,343,317.90	0.5	2,462,032.20	0.4
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	641,417.30	0.1	674,676.20	0.1
Усан хангамж; бохир ус, хог, хаягдлын менежмент болон цэвэрлэх үйл ажиллагаа	119,462.90	0	124,579.60	0
Барилга	892,953.00	0.2	898,121.50	0
Бөөний болон жижиглэн худалдаа, машин, мотоциклийн засвар, үйлчилгээ	3,256,387.00	1.1	3,441,563.30	0.7
Тээвэр ба агуулахын үйл ажиллагаа	1,279,749.80	0.4	1,782,095.20	1.8
Зочид буудал, байр, сууц болон нийтийн хоолны үйлчилгээ	349,449.80	0.3	425,910.00	0.3
Мэдээлэл, холбоо	783,111.10	0.2	911,204.10	0.5
Санхүүгийн болон даатгалын үйл ажиллагаа	1,456,846.80	0.1	1,601,977.10	0.5
Үл хөдлөх хөрөнгийн үйл ажиллагаа	1,802,728.70	0.1	1,837,404.00	0.1
Мэргэжлийн, шинжлэх ухаан болон техникийн үйл ажиллагаа	486,192.40	0.1	497,417.30	0
Удирдлагын болон дэмжлэг үзүүлэх үйл ажиллагаа	233,734.10	0.1	257,487.90	0.1
Төрийн удирдлага ба батлан хамгаалах үйл ажиллагаа, албан журмын нийгмийн хамгаалал	1,692,186.50	0.1	1,774,826.60	0.3
Боловсрол	1,218,241.90	0.5	1,247,295.00	0.1
Хүний эрүүл мэнд ба нийгмийн үйл ажиллагаа	662,472.50	0.1	672,062.80	0
Урлаг, үзвэр, тоглоом, наадам	137,610.70	0.1	146,169.30	0
Үйлчилгээний бусад үйл ажиллагаа	142,719.50	0	143,694.70	0
Бүтээгдэхүүний цэвэр татвар	3,570,923.60	1.4	3,814,112.20	0.9

Эх сурвалж: (ҮСХороо, 2024)